

АГУУЛГА

- Г.Далайжамц
Монгод улс дахь эдийн засаг, нийгэм соёлын эрхийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудлууд 3
- П.Оюунчимэг
Хүний эрх ба хүнийг хил дамнуулан худалдаалах гэмт хэргийн тухай 19
- Г.Нарантуяа
Хүний эрх ба улсын бүрэн эрхт байдал 24
- У.Туяа
Ерөнхий боловсорлын сургуулийн хүний эрхийн сургалт 30
- Ц.Цэрэнням
Оршин суух газраа сонгох эрх, түүний эрх зүйн үндсийг шинэтгэх асуудал 37
- Ж. Дашдорж
Хурдан морины уралдааны явц дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдал, анхаарах асуудал 46
- Хүний эрх Хөгжил төв
о«Монгол улс дахь уул уурхай ба хүний эрх» сэдэвт үндэсний хэлэлцүүлгийн баримт бичиг 57
о Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэлийн, хоёрдугаар бүлэг: /2006/ Эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулах, хамтын гэрээ хэлэлцээр хийх эрхийн төлөв байдал 78
- М.Бат-Очир
Тактикийн зураглал боловсруулах аргачлалын талаар 97

CONTENT

• G. Dalaijamts	
Some concerning issues of the economic, social and political rights in Mongolia	3
• P. Oyunchimeg	
Human rights and trafficking	19
• G. Narantuya	
Human rights and sovereignty of the country	24
• U. Tuya	
Human rights curriculum in secondary schools	30
• Ts. Tserennyam	
Right to residence and its improvement of legal basis	37
• Speech and recommendation from National Forum organized by NHRCM,	
• J. Dashdorj	
Rights and conditions of children, during the horse raising	46
• Recommendation released by organizers and participants of the Forum	52
• Center for human rights and development	
o National discussion paper «Human rights and mining in Mongolia»	57
o Report on human rights and freedoms in Mongolia by NHRCM, 2006, /Right to freedom of association/	78
• M.Bat-Ochir	
The tactical mapping process	97

МОНГОЛ УЛС ДАХЬ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ СОЁЛЫН ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШИД АНХААРАХ АСУУДЛУУД

Г.Далайжамц
ХЭҮК-ын гишүүн

Монгол улсын шинэ үндсэн хуульд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын заалт, үзэл санааг бүрэн тусгаж, хүн бүр эдийн засаг, нийгэм, соёлын талаар өргөн эрх эдлэх боломжийг баталгаажуулж, түүнийг хэрэгжүүлэх төрийн үүргийг нарийвчлан тодорхойлж өгсөн нь чухал ач холбогдолтой болсон юм.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг эрх тус бүрээр нь товч авч үзье.

НЭГ. ХҮНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХИЙН БАЙДАЛ

Монгол улсын шинэ үндсэн хуульд (1992):

- Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.
- Өмчлөгчийн эрхийг зөвхөн хуульд заасан үндэслэлээр хязгаарлана.
- Бэлчээр нийтийн эдэлбэрийн ба тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно.
- Монгол Улсын иргэн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй.
- Хувийн өмчийг хууль бусаар дайчлан авахыг хориглоно. Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө.
- Иргэд хувийн аж ахуй эрхлэх, зохиол бүтээл туурвих, түүнийхээ үр шимийг хүртэх эрхтэй гэж хуульчлан тогтоож, иргэн хүний эдийн засгийн эрхийг баталгаажуулж өгчээ.

1.1. Эд хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх эрх



Үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэх нь өмчийн эрхийг хамгаалах нэг үндэс мөн. Үл хөдлөх хөрөнгийн энэхүү бүртгэлийг үл хөдлөх хөрөнгийн газар эрхлэн бүртгэж, бие даан үйл ажиллагаагаа явуулж байсныг 2003 оноос Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын харьяа алба болгон өөрчилж, энэ байгууллагын хавсарга болгосон нь олон талын сөрөг үр дагаврыг бий болгож болзошгүй байгааг эргэж харах нь зүйтэй юм.

1.2. Газар өмчлөх эрх

Үндсэн хуулийн 6-р зүйлийн 3 дахь хэсэгт “Бэлчээр нийтийн эдэлбэрийн ба тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол улсын иргэнд өмчлүүлж болно” гэж заасан. Үүний дагуу УИХ-аас 2002 онд анх

удаа Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг батлан гаргаж, 2003 оны 5-р сарын 1-ээс эхлэн дагаж мөрдүүлсэн билээ.

Газрын харилцаа, геодези зураг зүйн газраас 2005 оны 12-р сарын 31-ний байдлаар гаргасан мэдээгээр улсын хэмжээнд 135055 иргэн буюу өрхөд газар өмчлүүлсэн байна. Үүнд:

- а/ Нийслэлд 54300 өрхөд газар өмчлүүлсний 53040 өрхөд тухайн үед ашиглаж, эзэмшиж байсан хашааных нь 2683.3 га газрыг өмчлүүлсэн. Үлдсэн 1260 өрхөд шинээр 88.2 га газрыг үнэгүй өмчлүүлжээ.
- б/ Аймгуудын 80755 өрхөд газар өмчлүүлсний 57505 өрхөд тухайн үед ашиглаж эзэмшүүлж байсан 7986.814 га газрыг нь өгч өмчлүүлсэн. үлдсэн 23185 өрхөд шинээр 4714.2 га газрыг үнэгүй олгож өмчлүүлжээ.
- в/ Хөдөө аж ахуйн зориулалтаар (давуу эрхээр) 65 иргэн (аж ахуйн нэгжид)-д 5.9052 га газрыг үнээр нь худалдах замаар олгож өмчлүүлсэн байна.

2000 оны тооллогын дүнгээр 541149 өрх байсан гэж үзвэл:

Эдгээр өрхийн 135055 нь 24.9 хувьд нь газар өмчлөх эрх хэрэгжсэн гэж үзэж болохоор байна (Энд аж ахуйн зориулалтаар газар өмчилсөн иргэд, аж ахуйн нэгжүүд ороогүй). Үүнээс үзэхэд газар өмчлөх эрхийн хэрэгжилт удаашралттай явагдаж байгаагийн зэрэгцээ газар хувьчлах, эзэмшүүлэх ажил шударга биш явагдаж буйг олон нийт шүүмжлэн дургүйцэж байгааг холбогдох байгууллагууд нэн анхааралтай авч үзүүштэй юм.

Өөрийн эзэмшлийн хашаа, байшингүй ядуу буюу нэн ядуу иргэн бүхий өрхөд газар өмчлөн авах ямар ч боломжгүй тухай гомдол, мэдээлэл байдаг. Тэдэнд нийслэлээс алслагдсан газарт газар авч амьдрахыг төрийн захиргааны зарим холбогдох албан тушаалтнууд шаарддаг ч, тэдгээр ядуу амьдралтай хүмүүс, төрийн үйлчилгээ болон амьжиргааны эх үүсвэрээсээ хол газар авч хэрхэн яаж амьдрах билээ. Энэ нь мэдээж ойлгомжтой асуудал юм.

1.3. Аж ахуй эрхлэх

Улсын бага хурлаар 1991 онд Аж ахуйн нэгжийн тухай хууль батлан гаргаснаар хувь хүн боломжтой үедээ аж ахуйн нэгж байгуулах замаар аж ахуй эрхлэх боломж нээгдсэн бөгөөд Монгол Улсын Их Хурал 1995 онд “Хоршооны тухай хууль”, “Нөхөрлөл компанийн тухай хууль”, 1999 онд “Компанийн тухай” хуулийг тус тус батлан мөрдүүлсэн юм.

Ийнхүү Монгол улсын иргэн аж ахуйн нэгж байгуулах буюу байгуулахгүйгээр иргэнийхээ хувьд хувийн аж ахуй эрхлэх эрхтэй болсон.

Иргэн хүн хувиараа эрхлэх аж ахуйг өргөдөл гаргаж, түүндээ нэр, хаяг, регистрийн дугаар, эрхлэх ажил үйлчилгээнийхээ төрлийг зааж,

байгуулдаг, түүнчлэн хүн амын орлогын татвар төлдөг зэргээрээ иргэдэд хамгийн дөхөмтэй байдаг.

Аж ахуйн нэгжийн тухай хуулийн 3-р заалтыг эс тооцвол хувиараа аж ахуй эрхлэхэд тэдний эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт байхгүйгээс эрсдэлтэй ажил: гар аргаар ашигт малтмал эрхлэх зэрэг ажил хийж буй иргэн амь нас, эрүүл мэндээрээ хохирох, бусад эрхээ эдлэх боломж бүрдэхгүй байх зэрэг хүндрэл бэрхшээл багагүй тохиолддог байна.

Энэ оны 1-р сарын 5-нд УИХ-ын 01-р тогтоолоор “Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого” гэсэн чухал баримт бичиг батлан гаргасан нь хувиараа аж ахуй эрхэлж, албан бус хөдөлмөр эрхэлж буй иргэдийн эрхийг хамгаалахад ач холбогдолтой эхний алхам болсон гэж үзэж болох юм.



Татварын дарамтын эцсийн үр дагавар

Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад хамгийн хүндрэлтэй, үйл ажиллагаагаа явуулахад учирч буй бэрхшээлийн нэг бол олон янзын татварын дарамт юм. Энэ нь тухайн аж ахуйн нэгжид төдийгүй, улс нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлтөд ч сөрөг нөлөө үзүүлж байгааг үгүйсгэх аргагүй юм.


Хувийн өмчийн харилцаанд түшиглэсэн улс орнуудад улсын төсвийн зохистой хэмжээг харгалзан татвар төлөх чадамж нь хязгаартай байдаг бөгөөд татварын түвшин ДНБ-ний 15 хувийн дотор хэлбэлзэж байвал боломжийн гэж үздэг, үүнээс давбал эдийн засгийн хөгжил буурах хандлагад ордог байна.

Манай улсын татварын дундаж түвшин сүүлийн 5 жилийн байдлаар ДНБ-ний 28%-иас дээш байгаа нь хөгжиж байгаа болон хөгжингүй орнуудын дунджаас 10 нэгжээр их байна гэж үзээд доктор профессор С.Баатар татварын бодлогын шинэчлэл хийх шаардлагын талаар санал дэвшүүлснийг анхааралтай авч үзэх нь зүйтэй.

1.4. Зохиол бүтээл туурвих, түүнийхээ үр шимийг хүртэх эрх /Энэ эрх нь эдийн засгийн эрхийн салшгүй хэсэг мөн/



Мөн оюуны өмчийн чиглэлээр 30 гаруй төрийн бус байгууллага бүртгүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна. Тэдгээрийн зарим нь зохиолч уран бүтээлчдийн зохиол, уран бүтээлийг бүртгэн авч гишүүдийнхээ бүтээлийг ашиглуулахаар аж ахуйн нэгж байгууллага, иргэдтэй гэрээ байгуулан ажилладаг байна.



1.5. Хөдөлмөрлөх эрх нь өмчийг арвижуулахад чиглэгддэгээрээ эдийн засгийн хамаарагдаж болох авч энэ эрхийн олон хэлбэрүүд нь нийгэм, соёлын эрхийн шинжийг бүрдүүлдэг учир нийгэм, соёлын эрхийн бүрэлдэхүүн хэсэг гэж үзсэнээр хамааруулсан болно.

ХОЁР. НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХ

1.5. Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн байдал

Үндсэн хуулийн 16-р зүйлийн 2-д “Эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан бол энэ эрх доорх байдлаар зөрчигдөж байна.

1. Агаарын бохирдлын эх үүсвэр

- а/ Жилд 3.3 сая гаруй тонн нүүрс хэрэглэдэг 3 дулааны цахилгаан станц, тэдгээрийн агаар мандалд хаягдаж байгаа хүхэр ба азотын исэл, нүүрстөрөгчийн исэл, дэгдэмхий үнснээс бүрдсэн хорт бодис
- б/ 700 гаруй маркийн 70 гаруй мянган авто машины угаарын хий, хорт утаа
- в/ Нүүрс, модоор галладаг зуух бүхий 90 гаруй мянган айл өрхийн пийшин зуухнаас агаарт гаргаж байгаа хорт утаа
- г/ Нүүрс түлдэг халаалтын болон технологийн зориулалттай (нам даралтын) 400 орчим жижиг зуух, тэдгээрт жилд их хэмжээний нүүрс шатааж ямар ч шүүлтүүр хяналтгүйгээр агаар мандалд хаяж буй хорт бодис
- д/ Жил ирэх тутам нэмэгдэж байгаа хаягдал төмөрлөг боловсруулах 30 гаруй үйлдвэрийн үйл ажиллагаанаас агаарт гаргаж байгаа хорт бодис
- е/ Эвдрэл, элэгдэлд орсон газраас боссон тоос шороо, хогийн цэгийн шаталт зэрэг орно.

2. Хөрсний бохирдол

- а/ Холбогдох байгууллагуудаас хөрс, орчин, агаарын бохирдлын байдалд хийсэн шалгалт судалгааны дүнгээс авч үзэхэд Улаанбаатар хотод амьдарч байгаа гэр хорооллын айл өрхүүдийн 67% нь стандартын шаардлага хангаагүй бие засах газартай, 34.5% нь бие засах газаргүй, бохир усны цооноггүй байна.
- б/ 2004 онд нийслэлийн хэмжээний хөрсний дээжид хийсэн нян судлалын шинжилгээгээр 35.0% нь 3-р зэргийн, 65.0% нь 4-р зэргийн бохирдолттой гарснаас харахад хөрсний бохирдолт жилээс жилд нэмэгдсээр байна.

3.а. Усны хангамж аюулгүй байдал

- а/ Улсын хэмжээнд ундны усны 30.8%-ийг ус түгээгүүрийн төвлөрсөн системээр, 24.4%-ийг зөөврийн усаар, 35.7%-ийг ус түгээх цэг болон худгаас, 9.1%-ийг булаг шанд, гол горхи, цас мөсний усаар хангаж байна.
- б/ Туул гол 5-р зэргийн бохирдолттой гарч энэ нь зөвшөөрөгдөх хэмжээнээс 10 дахин их байна. Бохирдсон усны 47%-ийг үйлдвэрийн хаягдал, 53%-ийг ахуйн болон орон сууцны хаягдал эзэлж байна.
- в/ Төв, орон нутгийн МХГ-ын лабораторид нийт 2442 усны дээжид хими, физик, нян судлалын 10119 үзүүлэлтээр шинжилгээ хийсний 36.5% нь ундааны усны чанарын шаардлага хангаагүй гарчээ.
- г/ Улаанбаатар хотын ундны усны төвийн эх үүсвэрийн хөрсөн бүрхэвч нь нянгийн бохирдолтоор дунд зэргийн хэмжээнд, ус нь нянгийн болон хүнд металлын бохирдолттой, тухайлбал Дунд голын урд хэсэг 36-р худаг орчим, Нарантуул захын урд хэсэг, Улиастайн гүүрний баруун урд, төмөр замын гармын урд 27-р худаг, баруун захын 43-р худаг орчимд хүнд металлын бохирдолт харьцангуй өндөр гарсан дүнтэй байна.

Иймд ус цэвэршүүлэх орчин үеийн өндөр түвшингийн техник, технологи нэвтрүүлэх талаар хойшуулшгүй арга хэмжээ авах шаардлагатай байна.

3.б. Улаанбаатар хотын усан хангамж

- а/ Улаанбаатар хотын ундны усны төвийн эх үүсвэр нь Оргил рашаан сувиллын зүүн урд хэсэг Их тэнгэрийн гүүрний хойд хэсгээс Гачуурт хар усан тохой хүртэлх нийт 15 км орчим газар үргэлжилдэг.
- б/ Гэтэл усны эх үүсвэрийг хамгаалах асуудал сул бөгөөд хоногт 114.0 мянган шоо метр ус олборлож байгаа нь хотын усны хэрэглээний 50 гаруй хувь, хүн амын усны хэрэглээний 70-80%-ийг хангаж байна.

4. Эмийн аюулгүй байдал

- а/ Дэлхийн эмийн зах зээлд эргэлдэж буй эмийн 10%-ийг хуурамч стандартын бус эм эзэлж, 32 тэр бум ам.долларт хүрсэн байна.

- б/ Манай хойд хөршийн эмийн зах зээлийн 35-40%-д хуурамч, стандартын бус эмийн бүтээгдэхүүн зарагдаж, өмнөд хөршид өнгөрсөн он гэхэд 1600 эмийн нууц үйлдвэрийг хаасан байна.
- в/ Манай улс хэрэгцээт эмийнхээ 80 гаруй %-ийг импортолдог, ийм хэмжээний эмийг импортолдог улсын хувьд ДЭМБ-ын “Олон улсын худалдаанд зориулсан эмийн бүтээгдэхүүний чанарын баталгаажсан схем”-ийг мөрдөж экспортлогч улсын эрх бүхий байгууллагын чанарын сертификат бүхий эмийг захиалан авч байх зарчмыг мөрдөх ёстой.
- г/ Манай эмийн чанарын хяналтын улсын байцаагчдаас эмийн худалдааны зах зээлийн борлуулалтад хийсэн шалгалтаар импортын болон эх орны үйлдвэрийн нийт 18 нэр төрлийн эм хуурамчаар үйлдвэрлэгдсэн болохыг тогтоосон юм,
- д/ Эмийн чанарын лабораторийн материалаас үзэхэд эмнэлгийн эмийн санд найруулсан эмэнд 8-12% стандартын шаардлага хангаагүй эм байдаг.
- ж/ 2005 оны эхний хагас жилд УМХГ, ЭМЯ-тай хамтран “Зах зээлд дэх хуурамч эмийн тандалт” судалгааг Нийслэлд болон 4 аймагт хийж үзэхэд зах зээл дээр шаардлага хангасан эм 73.3%, чанарын шаардлага хангаагүй эм 26.7%, хуурамч эм 13.3%-ийг тус тус байсан байна.

5. Барилга, авто замын аюулгүй байдал

- а/ Стандартын бус, чанар муутай материалаар барилга барих буюу барилга угсралтын техник, технологи зөрчиж чанаргүй барилга барих нь хүний аюулгүй орчинд амьдрах эрхийг ноцтой зөрчиж байна. Жишээ нь: УМХГ-ын хяналт шалгалтаар Дээжис балгиа ХХК-ны борлуулагч Б.З. гэгч Хятад улсын нэр хүндтэй үйлдвэрийн уут шошгыг ашиглан Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийн цементийг нэг уут цементээс 2-3.5 кг дутуу савлан зарж байсан, БҮК-2 ХХК-ны хашаан дотор байрлах Буянцогт эзэнтэй савлах цэг Хөтөлийн үйлдвэрийн уутыг хуурамчаар дуурайлган ашиглаж стандартын бус цемент савлаж байсан. Стандартаар савлагдах ёстой цемент нь 4.025 маркийн байх ёстой байтал түүн дээр 3.025 маркийн доод зэрэглэлийн цементийг хооронд нь хольж савлан хуурамч бүтээгдэхүүн болгон худалдаалсан зэрэг зөрчлүүд илэрчээ.
- б/ Авто замын даац, ачаалал хэт ихэссэн, чанар муутай, стандартын бус зам барих, замын засвар зогссоноос авто авто замын аюулгүй байдал алдагдаж осол их гарч байна.
- Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжсэн Дархан-Эрдэнэт чиглэлийн 180 км хатуу хучилттай авто замын 91дэх км-т технологи зөрчигдөж зохиогдсон төслийн улмаас хөдөлгөөний аюулгүй байдал алдагдаж тухайн цэгт автын осол удаа дараа гарч байсан.
 - Мянганы зам төслийн хүрээнд хэрэгжсэн Багануур-Өндөрхаан

чиглэлийн хатуу хучилттай авто замд үзэгдэх орчин хязгаарлагдмал, эргэлтийн хэвгий авто зам норм дүрмийн дагуу бус төлөвлөгдсөн нь хөдөлгөөний аюулгүй байдалд муугаар нөлөөлөхүйц болсон.

- Сүүлийн жилүүдэд хүн ам олноор төвлөрөн суурьшиж зорчигч үйлчилгээний хүрээ тэлж, тээврийн үйлчилгээ эрхлэх байгууллага аж ахуйн нэгж, иргэд олшрохтой уялдан гудамж замаар зорчих тээврийн хэрэгслийн тоо жил бүр 7-10%-иар өсөж хөдөлгөөн эрс нэмэгдэн уулзварууд болон замд бөглөрөл үүсэж замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж чадахгүй боллоо.
- Хотын барилга байгууламжуудын инженерийн шугам сүлжээний төлөвлөлт авто замын доогуур байдаг учир зам дээрх дулаан цэвэр бохир усны худгуудын таг цөмрөх, алдагдах зэрэг нь замын хөдөлгөөний аюулгүй байдалд ч сөрөг нөлөө үзүүлж байна.

6. Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа

Ажилтан аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрхтэй.

Энэ эрхийг хангахын тулд аж ахуйн нэгж байгууллагууд юу хийх ёстой вэ?

- а/ Ажилтныг сургаж дадлагажуулах, мэргэжил мэргэшилтэй болгох
- б/ 3 шатны зааварчилгаа өгөх
- в/ Шинэ техник, технологи нэвтрүүлэх, хувцас хамгаалах хэрэгслээр хангах
- г/ Үйлдвэрийн явцад хөдөлмөрийн эрүүл ахуй, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болох хими, физик, биологийн хүчин зүйлийн нөлөөллийг багасгаж цаашид гаргуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх
- д/ Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хэрхэн хангаж буйд тавих хяналтын механизмыг төгөлдөржүүлэх

Дээрх шаардлагыг хангаагүйн улмаас сүүлийн 5 жилд 1895 хүн осолд орсны 57.5% буюу 1089 хүн нь Зам тээвэр, холбоо, уул уурхай, барилга, хөнгөн, хүнсний үйлдвэрийн салбараас осолд өртөгсөд байна /УМХГ-ын дүн/.

1997 онд улсын үзлэгт 5000 гаруй аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсаны 90 орчим % нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангаагүй гэсэн дүн гарчээ /НХХЯ-ны мэдээнээс/.

Ажлын байрны сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс болж жил бүр мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчлөгсдийн тоо 463-522 нэмэгдэж сүүлийн 5 жилд 2.3 мянган хүн шинээр мэргэжлийн өвчний онош тогтоолгон, ажлын нөхцөлөө өөрчилж, хөдөлмөрийн чадвараа 40-75%-

иар алдсан байна /УМХГ-ын мэдээллээс/.

Мэргэжлээс шалтгаалах өвчин, уул уурхай, эрчим хүч, барилгын салбарын ажилтны дунд зонхилон тохиолдож нийт мэргэжлээс шалтгаалах өвчний 90 гаруй хувь нь эдгээр салбарт ноогдож байна.

2005 онд Налайхад нүүрс олборлож байсан иргэдээс 16 хүн ослын улмаас нас барсны 9 нь агааргүй орчинд ажилласнаас, 5 нь нуралт үүссэнээс дарагдаж амь насаа алдсан байна /УМХГ-ын мэдээллээс/.

2.2. Зохистой, аюулгүй хоол хүнсээр хангагдах эрхийн байдал

Энэхүү эрх нь ЭЗНСЭОУП болон ЭЗНСЭХ-ны Ерөнхий зөвлөмж (1999) Монгол улсын хүнсний тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжоор баталгаажсан байдаг.

Манай улс зах зээлд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн (махнаас бусад) үр тариа, гурил, будаа, төмс, хүнсний ногоо цөцгийн болон ургамлын тос, жимс жимсгэнэ зэрэг бүтээгдэхүүний 70-100%-ийг импортоор оруулж хэрэгцээгээ хангаж байна.

- Энэ нь хүнсний хангамжийн баталгаа, аюулгүй байдалд аль хир нийцэж байна.
- Олон улсын хэмжээнд тогтсон жишгээр хүнсний хэрэгцээний 30^н-аас дээш хувийг импортоор авдаг орныг хүнсний хангамжийн баталгаагүй гэж үзэх бөгөөд нэг төрлийн бүтээгдэхүүний хэрэгцээний 20-оос илүү %-ийг зөвхөн ганц орноос импортоор авдаг орныг хүнсний хангамжийн хувьд хараат байдалтай гэж үзэж байна.

Тэгвэл манай улсад хүнсний бараа, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал ямар байгааг УМХГ-ын удаа дараагийн хяналт шалгалт, лабораторийн шинжилгээний дүн нотолж байна.

а/ Импортынх

1. 2004 оны байдлаар улсын хилээр 31 гол нэрийн 550 мянга гаруй тонн хүнсний бүтээгдэхүүн импортолсны 40 гаруй %-ийг УМХГ-ын хилийн болон гүний мэргэжлийн хяналт шалгалтад хамруулсан бөгөөд хяналтын явцад авсан 12500 гаруй сорьц, дээжид УМХГ-ын үндэсний төв лаборатори 31 мянга гаруй үзүүлэлтээр шинжилгээ хийхэд 8.2% нь буюу 1012 сорьц эрүүл ахуйн шаардлага хангаагүй гарсан байна.
2. Жимс жимсгэнэ, хүнсний ногоонд гарч буй нитратын агуулга, цай, кофе, какаонд хөгц, мөөгөнцрийн бохирдол зөвшөөрөгдөх нормоос их, бүх төрлийн архи, спиртэд хийсэн шинжилгээгээр совсны тос, цууны алдегидийн хэмжээ стандартад заасан нормоос их гарчээ.

б/ Хүнсний үйлдвэрүүд

3. Улсын хэмжээнд гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 1500 гаруй жижиг, дунд үйлдвэр ажиллаж байгаагаас мах махан бүтээгдэхүүн боловсруулах 120 гаруй, гурил гурилан бүтээгдэхүүний 600 гаруй, сүү цагаан идээний 160 гаруй, спиртийн 21, архины 183, шар айргийн 41, дарсны 9, цэвэр усны 19, рашааны 9, ундаа жимс шүүсний 350 гаруй үйлдвэр, цех байна.
4. Сүүлийн 3 жилийн байдлаар (2002-2004) хоол хүнсээр дамжсан хоолны хордлогот халдварын 4 удаагийн томоохон дэгдэлт гарч нийт 300-аад хүн өвчилсөн бөгөөд энэ нь (2000-2001) өвчлөлөөс 4 дахин нэмэгдсэн байна. Үүнийг тохиолдлоор нь авч үзвэл 2002 онд 100 гаруй хүн, 2003 онд зусланд амарч байсан 37 хүүхэд, Улаанбаатар хотод нэг гэрийн 5 хүн, 2005 онд 57 хүнийг хамарсан хоолны хордлогот халдварт өвчлөл гарсан байна.

в/ Хүнсний бараа бүтээгдэхүүний худалдаанд

5. Нийслэл Улаанбаатар хотын хүнсний захуудад борлуулагдаж буй махнаас дээж авч шинжлэхэд 100% нянгаар бохирдсон байснаас гадна 60 гаруй хувь нь хальсгүйжсэн, 9-12% нь үнэр, өнгөний өөрчлөлт орсон, 16% нь өнгөц ялзралттай, 3.9% нь салсжилттай, хөгцрөлт, толбодолт тус бүр 2%-ийг эзэлж байна.

г/ Стандартын бус, чанар муутай хоол хүнс, эм хэрэглэсний үршиг, үр дагавар

7. 2003-2004 оны өвчлөлийн мэдээнээс үзэхэд нийт өвчлөлд хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг 2-р байрыг эзэлж, улмаар хорт хавдрын тохиолдол, тархалт, нас баралтын үзүүлэлтэд элэгний болон ходоодны хорт хавдрын өвчлөлийн тохиолдлын тоо, тархалт, нас баралтын 10 мянган хүн амд ноогдох үзүүлэлтээр хамгийн их хувийг эзэлж, жилээс жилд өссөн үзүүлэлттэй байна.
8. 2003 оны байдлаар улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт нас барсан хүний тоог үхэлд хүргэсэн өвчнөөр авч жагсаахад хавдар нь нас баралтын 2 дахь гол шалтгаан болж, хоол боловсруулах эрхтний өвчин 5-рт орж байжээ.

2.3. Зохистой орон байраар хангагдах эрх

Энэ эрх нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн салшгүй хэсэг мөн. Энэ эрхийн хууль зүйн баталгаа, эрх зүйн үндэс нь олон улсын болон үндэсний доорхи хууль, тогтоомжуудаар тодорхойлогдоно.

- а) ХЭТТ-ын 25-ын 1 ба ЭЗНСЭОУП-ын 2-ын 1, 11 дүгээр зүйл.

- б) НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны Ерөнхий 4-р Зөвлөл
- в) НҮБ-ын Нийгмийн хөгжил, дэвшлийн төлөө /1969 он/ Тунхаглал, НҮБ-ын Хүний оршин суух байрны тухай Ванкуверийн Тунхаглал
- г) Монгол улсын үндсэн хуулийн 16-р зүйл
- д) Дундын өмчлөлийн орон сууцны тухай хууль /1996 он/
- е) Орон сууцны тухай хууль /1999 он/
- ё) Орон сууц хувьчлах тухай хууль /1996 он/
- ж) Төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого /УИХ-ын 1999 оны 25-р тогтоол/
- з) 40 мянган айлын орон сууцны тухай хөтөлбөр
- и) Орон сууцны үндэсний хөтөлбөр /ЗГ-ын 2002 оны тогтоолоор баталсан/

2002 оны хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр 541149 өрх байсны 54.8 хувь нь хот, сууринд, 45.2 хувь нь хөдөөд амьдардаг байсны 49.1 хувь нь байшинд, үүний 71.7 хувь нь хот, сууринд, 21.7 хувь нь хөдөөд амьдардаг. Гэрт амьдардаг 50.9 хувь болох өрхийн 28.3 хувь нь хот, сууринд, 78.3 хувь нь хөдөөд амьдарч байжээ. Орон гэргүй 4305 хүн байсны дотор байшингийн хонгил, орц, дулааны шугам, сүлжээ, ой, мод, хад ууланд амьдардаг өрх 800 гаруй байжээ. Одоо ч энэ тоо төдийлөн багасаагүй болов уу.

Орон сууцаар хангах явдал бол төрийн бодлогын тулгамдсан гол асуудлын нэг мөн.

2.4. Хөдөлмөрлөх эрх

Энэ эрх нь иргэн ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхээ хэрэгжүүлж эхэлсний дараа буюу ажилтан, ажил олгогчидтой хөдөлмөрийн гэрээ байгуулах үеэс үүсэж бий болдог.

Хөдөлмөрлөх эрхэд доорхи эрхүүд хамаарагдана.

- а) Хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах
- б) Хийж буй ажлын тоо, чанарт тохирсон, өөрийн болон гэр бүлийнхээ хэрэгцээнд хүрэлцэхүйц цалин авах
- в) Амрах /долоо хоногийн амралтын, нийтийн баяр ёслолын, ээлжийн амралт/
- г) Нэмэгдэл цалин, хөлсүүд /илүү цагийн, долоо хоногийн амралт, баяр ёслолын өдөр, шөнийн цагийн г.м/
- д) Эрүүл мэндээ хамгаалуулах /эрүүл мэндийн үзлэгт оруулах, эмнэлэг сувилалд явуулах/
- е) Ажил зогсоох онцгой эрх /үйлдвэрлэлийн, аюулгүй ажиллагааны журам зөрчигдсэн буюу амь бие, эрүүл мэндэд нь сөрөг, аюултай

нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажлаа зогсоож, энэ тухай ажил олгогчид мэдэгдэх/

- ё) Хөдөлмөрийн гэрээг өөрийн санаачилгаар цуцлах санал тавих
- ж) Хөдөлмөрлөх явцад эрх ашгаа хамгаалах, хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, дүгнэхэд оролцох, ҮЭ-д эвлэлдэн нэгдэх зэрэг эрхүүд

2.5. Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх

Монгол улсын үндсэн хуулийн 16.6-д “Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй” гэж заасан.

Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийн байдал

Энэ эрх нь НҮБ-ын ЭЗНСЭОУП болон эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Ариун цэврийн тухай хууль, Хүнсний тухай хууль болон холбогдох хууль тогтоомжуудаар баталгаажсан байдаг.

Зарим тоо баримтыг үзүүлье.

ЭМХ, ЭТАЭ-ийг хэрэгжүүлэхэд учирч буй бэрхшээл, дутагдал

1. Сум, багийн болон нийслэлийн захын хорооллын эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар дутмаг.
 2. Мөн тэдгээрт эмч, оношилгооны багаж төхөөрөмж, эм, урвалж бодис хүрэлцдэггүй.
 3. Төв, орон нутагт шилжин суурьшигчид болон гар аргаар ашигт малтмал олборлогчид эмнэлгийн тусламж авч чадахгүй цаг алддаг. 2002 онд зөвхөн нийслэлд зөвшөөрөлгүй шилжин суугчид 47863 хүн байсан.
 4. Шатлал дэвшин улсын хэмжээний үйлчилгээтэй эмнэлэгт шилжин эмчлүүлэхэд хугацаа алдаж өвчин хүндэрдэг.
 5. Төвлөрсөн томоохон эмнэлгүүдэд лабораторийн шинжилгээ, оношилгоо хийлгэхэд цаг хугацаа алдаж, өвчин хүндрэх, зарим эмч нар хайхрамжгүй, хөнгөн гоомой хандах, хэт мэдэмхийрч буруу оношлох, эрчимтэй эмчилгээ хийхгүй алгуурлах
 6. Цөөн тооны эмч, эмнэлгийн ажилтны хувьд гар харах, шан харамж өгөхгүй бол өвчтөний оношилгоо, эмчилгээн дээр төдийлөн анхаарал тавихгүй байх буюу өөрөөсөө зайлуулах хандлага байсаар байна.
- Эдгээр дутагдлыг арилгаж, бэрхшээлийг даван туулж, дээрх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, идэвхтэй ажиллах.



2.6. Сурч боловсрох эрх

Энэ эрх нь үндсэн хууль болон Боловсролын тухай багц хуулиуд, олон улсын гэрээгээр баталгаажсан юм.



2000-2001 онд 351 дотуур байранд 38024 сурагч байрлаж байсан бол 2005-2006 онд 410 дотуур байранд 41068 сурагч байрлаж байр 59-өөр буюу 16.8 хувиар, сурагчдын тоо 3044-өөр буюу 8 хувиар тус тус өссөн байна.

ЕБС-д 2000-2001 оны хичээлийн жилд 15590 бүлэгт 494544 сурагчид сурч байсан бол 2005-2006 онд 17157 бүлэгт 556876 сурагч сурч байгаа

нь бүлгийн тоо 1567-оор, сурагчдын тоо 62332 сурагчаар буюу 12 хувиар тус тус өссөн байна.

Багшийн хүрэлцээ: ЕБС-д 2000-2001 онд үндсэн багш 19223 буюу нэг багшид 25.7 сурагч ноогдож, 719 багш дутагдалтай байсан бол 2005-2006 онд үндсэн багш 22627 буюу нэг багшид 24.6 сурагч ноогдож, 495 багш дутагдаж байна.

Сургууль завсардалт: ЕБС-иас 2000-2001 онд 13730 хүүхэд сургууль завсардаж байсан бол 2005-2006 онд 9032 хүүхэд сургууль завсардаж байгаа гэсэн мэдээ байна. Ингэж сургууль завсардаж буй гол шалтгаан нь янз бүрийн түвшинд хийсэн судалгааны дүнгээс үзвэл: Ядуурал, орлого багатай байдал, хүүхдийн хөдөлмөр эрхэлж буй явдал, шилжих хөдөлгөөн, дотуур байрны хүрэлцээгүй, эцэг эхийн суурин амьдарч ажиллахгүй байдалтай холбоотой байна. Энд нөлөөлж буй хүчин зүйл эцэг, эхийн анхаарал, халамж, амьжиргааны түвшин, багш нарын зүгээс ялгаварлан гадуурхалт, ажлын ачаалал, сургуулийн өмнөх боловсролын хүртээмжгүй байдал, стандартын шинэчлэл, багш нарын мэргэжил дээшлүүлэлт, ажлын ур чадвар нөлөөлж байна.

Нэн ядуу өрхийн хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч боловсрох эрхээ эдэлж чадахгүй байна.

2.7. Нийгэм, хангамжийн эрх

Үндсэн хуульд энэ эрхийг “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй” гэж баталгаажуулсан болно. Тэрчлэн энэхүү эрхийг Нийгмийн даатгалын багц хууль, Нийгмийн халамжийн тухай хууль болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль зэрэг хуулиудаар давхар баталгаажуулж байна.

Энэ эрх нь нийгмийн даатгалын, нийгмийн халамжийн гэсэн хоёр төрөлтэй байна.

А. Нийгмийн даатгалаар хангагдах эрхийн төрөл

- а) өндөр настны тэтгэвэр 2005 оны бүтэн жилд нийгмийн даатгалаас 179.9 мянган хүнд 83.6 тэрбум төгрөг олгосон.
- б) Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэтгэвэр 2005 онд 49.3 мянган хүнд 16.6 тэрбум төгрөг нийгмийн даатгалаас олгожээ.
- в) Тэжээгчээ алдсаны тэтгэвэр: 2005 онд 34.9 мянган хүнд 13 тэрбум төгрөг нийгмийн даатгалаас олгосон.
- д) ҮОМШӨ-ний даатгалын сангаас 2005 онд 6.8 мянган хүнд 4.4 тэрбум төгрөг олгосон.
- е) Цэргийн тэтгэвэр: 2005 онд 12.7 мянган хүнд 7.9 тэрбум төгрөг олгосон.

Дээрх тэтгэвэр авагчдад тэтгэврийг хугацаанд нь бүрэн олгохын баталгаа нь ажил олгогчид, ажилтан болон байгууллагаасаа нийгмийн даатгалын шимтгэлийг цаг тухайд нь авч нийгмийн даатгалын санд шилжүүлж байх явдал юм. Зарим аж ахуйн нэгж, байгууллагууд шимтгэлийг төлөхгүй олон сар, жилээр үргэлжилж байдаг нь дээрх тэтгэвэр авагчдын эрх ашгийг хохирооход хүрч байна. Жишээ нь: Улсын хэмжээнд нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 2005 оны эхэнд 8.3 тэрбум төгрөг байсан бол оны эцэст 8.6 тэрбум төгрөг болж, 300 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Б. Нийгмийн халамжийн эрхийн төрөл

- а) Нийгмийн халамжийн тэтгэвэр: Ахмад настны, хөгжлийн бэрхшээлтэй иргэний, дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхийн гэсэн гурван төрлийн тэтгэвэр байдаг. 2005 онд 44947 хүнд 7764302.5 мянган төгрөгийн тэтгэвэр олгожээ:
- б) Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, тусламж, хөнгөлөлт үйлчилгээ: 2005 онд давхардуулсан тоогоор нийт 742233 хүнд 28760193.1 мянган төгрөгийн тэтгэмж олгосон, мөн онд нийгмийн эмзэг бүлгийн амьжиргааг дэмжих зорилгоор давхардсан тоогоор 168504 хүнд 5711621.2 мянган төгрөгийн хөнгөлөлт, тусламж олгосон байна. Мэдээ, судалгаанаас үзвэл хөнгөлөлт, тусламжаа авч чадаагүй хүмүүс ч цөөнгүй байдаг байна.

Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нэн ядуу иргэдийн амьжиргааг дэмжих, тэднийг орлогын эх үүсвэртэй болгох, ажиллах боломжтойд нь ажилтай болгох талаар төрийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан онцгой анхаарал хандуулах нь хүний эрхийг дээдлэх зарчимд нийцэх юм.

Авах арга хэмжээ

ЭЗНС-ын эрхийн хэрэгжилтийн байдлаас үзэхэд дараах асуудалд анхаарлаа илүү их хандуулах шаардлагатай гэж үзлээ.

1. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн мөн чанар, практикт хэрэгжүүлэх арга механизмыг судалж, тэдгээрийг хэрэгжүүлдэг чадавхыг холбогдох албан тушаалтанд эзэмшүүлэх
2. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ядуу, нэн ядуу иргэдийн эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хэрэгжилтийг хангах механизмыг боловсронгуй болгож, үр дүнг тооцдог болгох.
3. Дээрх эрх тус бүрд дурдагдсан зөрчил, дутагдал, нөлөөлж буй хүчин зүйлийг арилгаж, хэрэгжилтийг хангах орчин нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг тогтмол авч байх.
4. Төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагуудад дээрх эрхийг Хүний эрхийн үндэсний хөтөлбөрийн заалттай уялдуулан судалж, сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг тооцож ажиллах.

ХҮНИЙ ЭРХ БА ХҮНИЙГ ХИЛ ДАМНУУЛАН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ

П.Оюунчимэг
ХЭҮК-ын Ажлын Албаны дарга, магистр

1948 онд батлагдсан Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 22-р зүйлд: "Хүн бүр нийгмийн гишүүнийхээ хувьд нийгмээс хангамж авах эрхтэй бөгөөд нэр төрөө хамгаалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм, соёлын талын эрх дархаа тухайн орны хүчин чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны нөөц бололцоонд нийцүүлэн эдлэх эрхтэй" хэмээн заажээ. 1986 оны Хүний хөгжлийн тухай тунхаглалд зааснаар хүний болон хөгжлийн хоорондын харилцаа холбоог тодруулж өгсөн байна.

НЭГ. ХҮН ХУДАЛДАХ ГЭМТ ХЭРЭГ БА ХҮНИЙ ЭРХ

Өнөөдөр дэлхий дээр цаг тутам хүн хил дамнуулан наймаалах асуудал эрс өсөн нэмэгдэж байгаа билээ. Мянга мянган залуу эмэгтэйчүүд, охидыг хуурч мэхлэн хүчээр биеэ үнэлэх болоод хүсээгүй гэрлэлтэд хүчээр татан оруулж байна.

Тэдгээр охид эмэгтэйчүүдийн нас, царай зүс, онгон байдлаас хамаарч үнийн тохиролцоо хийдэг бөгөөд өндөр үнээр худалдан орчин цагийн боолчлолын хэлбэр нөхцөлөөр байлгадаг байна.

Энэ асуудал ингэж газар авч байгаа нь эмэгтэйчүүдийн тэгш бус статустай шууд холбоотой байдаг. Нийлүүлэлтийн тал дээр тодорхой бүс нутгийн эдийн засаг, нийгмийн буурай нөхцөл байдал нь тэдгээрийг хүчээр биеэ үнэлэх магадлалыг эрс ихэсгэдэг. Тэгэхээр энэ нь тухайн улсын нийгэм эдийн засгийн хөгжилтэй салшгүй холбоотой гэсэн үг юм.

Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын том хотуудад илүү цалин хөлстэй ажил, илүү сайхан амьдралын нөхцөл байдал нь эмэгтэйчүүд охидыг ихээр татаж хууль бус эдгээр ажиллагааг хүлээн зөвшөөрөхөд хүргэдэг том сурталчилгаа болж өгдөг.

Түүнээс гадна тухайн охид болон эмэгтэйчүүд өөрөө хүсээгүй, ямар нэгэн эрмэлзлэл байхгүй ч гэсэн тухайн нийгмийн гаж үзэгдлийн золиос болж байгаа нь нууц биш. Зарим нэг улс оронд шашин шүтлэг, зан заншлын хэм хэмжээнээс шалтгаалан эрэгтэй хүүхдийг эмэгтэй хүүхдээс илүүд үздэг, эмэгтэй хүүхдийг бусдад зарсан тохиолдолд мөнгийг бэлнээр өгч

байгаа нь гэр бүлд ийм уур амьсгалыг бий болгоход тодорхой хэмжээгээр нөлөөлдөг байна.

Хүн наймаалах гэмт хэрэгт татагдан орсон улс орнуудыг дотор нь хүлээн авагч, дамжуулагч, илгээгч улс хэмээн гурван төрөлд ангилдаг байна.

Хүлээн авагч улсуудын хувьд секс туризм ихээхэн хэмжээгээр өсөж байгаа нь нэг талаар энэ гэмт хэргийг гарахад ихээхэн хүчин зүйл болж байгааг хэлэх хэрэгтэй.

Дамжуулагч улсуудын хувьд өөрсдөө хүнээ бэлтгэдэггүй, ихэвчлэн транзит маягаар дамжин өнгөрүүлдэг улс орнууд хамардаг.

Илгээгч улс орнууд бол тусгай арга хэлбэрээр эн төрлийн гэмт хэргийг нэгдсэн зохион байгуулалттайгаар маш өндөр түвшинд бэлтгэн зохион байгуулдаг.

Нэгэнт тэр эмэгтэйчүүд бэлтгэгдээд тэдний гарт орсон тохиолдолд хүчээр биеэ үнэлүүлэх ажиллагаанд өөрийнх нь хүсэл зоригоос гадуур ордог. Үүнтэй холбоотойгоор тухайн эмэгтэйг зөөвөрлөж авчирсан, орон байр, хоол хүнс, хувцас хэрэгслэлээр хангадаг болохоор өрийн асуудал гарч ирдэг. Энэ нь тухайн эмэгтэйг тэнд байнгын байлгаж ашиг хонжоо олох эх үүсвэрийг нэг нөхцөл болохоос гадна хяналтын нэг систем болж өгдөг талтай.

Үүнээс зайлсхийх зугатах ямар ч нөхцөл байхгүй бөгөөд хэрвээ ийм оролдлого хийсэн тохиолдолд зөвхөн өрөө төлөх асуудал яригддаг.

Янхны газраас зугатах нь тэдгээр эмэгтэйчүүд, охидод том аюул эрсдэлд хүргэдэг. Тэдгээр эмэгтэйчүүдийг бусдыг залилсан гэх аль эсвэл хууль бусаар оршин сууж байсан мэтээр цагдаагийн байгууллагад мэдэгдэх эсвэл эцэг эхийг нь янз бүрийн байдлаар дарамтлах арга хэмжээнүүдийг авдаг байна.

Энэтхэгийн туршлагаас харахад бүхэл насныхаа туршид ядуу, нийгмийн зүгээс ямар нэгэн дэмжлэггүй тусад нь нийгмийн олонхоос зааглаж харьцдаг, нийгмийн давхаргын ялгаварлан гадуурхалт, дарамт шахалт зэрэг нөхцөл байдал нь тодорхой хэмжээгээр нөлөөлдөг.

Энэтхэг, Непал, Бангладешийн хувьд энэ төрлийн гэмт хэрэг маш их тоогоор гардаг бөгөөд хүн наймаалах гэмт хэргийн алтан гурвалжин болсон улс орнууд хэмээн нэрлэдэг.

Эдгээр улсуудад насанд хүрээгүй охидыг гэрийн үйлчлэгчээр олноор ажиллуулж хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн хэлбэрийг сонгодог утгаар нь хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь олон нийтийн анхаарлыг төвд оршсоор ирсэн билээ.

Насанд хүрээгүй охидыг порнографид уруу татах, томчуудын зугаа цэнгээг гаргагч нэгэн болгохын тулд охидыг олноор нь хил дамнуулан

худалдаалдаг нарийн зохион байгуулалттай том гэмт бүлэглэлүүд олноор бий болсон байна.

Түүнээс гадна хүнийг хил дамнуулан наймаалж байгаа энэ гэмт хэрэг нь хүний эрх тэр дундаа эмэгтэйчүүд, хүүхдийн эрхийн хамгийн том зөрчил мөн болохын хувьд хүний эрхийг зөрчсөн маш олон хэлбэрийг агуулдаг. Хүний амьд явах, эрх чөлөө, эрүүл аюулгүй орчинд амьдрах, эрүүдэн шүүгдэхээс ангид байх, гэр бүл болоод орон гэртэй байх, сурч боловсрох эрх, зохистой нөхцөлд гэр бүлийн харилцаатай байх зэрэг хүний сайн сайхан амьдрал, нэр төр эрүүл амьдрах бүх эрхүүдийг зөрчдөг байна.

Энэ төрлийн гэмт хэргийн цаана мөнхийн мөнгөний ашиг сонирхол дагалддаг гэдгийг ойлгох хэрэгтэй.

Олон улсын Интерполоос гаргасан дэлхий дээрх гэм хэргүүдийн нийгмийн хор аюул, хүний эрхийг хамгийн ноцтойгоор зөрчдөг гэмт хэргийн ангиллаас харахад терроризм мөнгө угаах гэмт хэргийн дараа энэ төрлийн гэмт хэрэг орж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн хир аюултай болохыг бэлхнээ харуулж байна.

Эмэгтэйчүүд, охид нь нас хүйс, биеийн галбир, боловсрол мэдлэгээр шууд хэлбэрээр ялгаварлан гадуурхсан сонголтод хамрагдан түүн дээр нь элсүүлэгч байгууллага нь цалин ихтэй ажил, орчин сайтай амьдралыг амлаж худалдах сүлжээндээ оруулдаг тогтсон энэ хэв маягийн цаана хүн худалдах гэмт хэргийн үнэн нүүр царай оршдог.

Хүн худалдах гэмт хэргийн золиос болж байгаа эмэгтэйчүүд, охид нь маш хатуу хүнд нөхцөлд амьдардаг. Тэд зөвхөн янхны газар амьдрах бөгөөд тэндээс хаашаа ч зугатах эрхгүй ба эдгээр эмэгтэйчүүд охидод гадагш ямар нэгэн байдлаар холбоо тогтоох харьцахыг хатуу хориглодог.

Тэднийг биеийг нь үнэлүүлэх ажлыг хийлгэхдээ хүчээр бас эрүүдэн шүүж тамлан зовоох аргыг хэрэглэн хийлгэдэг. Янхны газар байгаа эмэгтэйчүүд охидын ихэнх нь тэр байранд байхдаа хүчиндүүлэх, зодуулах бие махбодийн ямар нэгэн тамлалд өртдөг.

Янхны газар байгаа эдгээр хүмүүсийн ихэнх нь ДОХ болон бэлгийн замын халдварт өвчнөөр өвдөх магадлал, эрсдэл маш өндөр байдаг. Бэлгэвч хэрэглэх хамгаалах хэрэгсэлд тухайн газрын зүгээс тавих хяналт маш муу түвшинд байдаг.

Өсвөр насны охидын хувьд ДОХ-ын халдварыг авах эрсдэл өндөр байна. Тэдгээр эмэгтэйчүүдийн ихэнх нь өөрийн суурь эрхийн талаар ямар нэгэн ойлголтгүй байдгаас гадна тамлуулах, биеийн болон сэтгэл санааны хохирол амссан талаарх асуудлыг зохицуулах олон улсын хуулийн механизмын талаар тэр дундаа тухайн улсад үйл ажиллагаагаа явуулдаг өөрийн орны элчин сайдын яамдын үйл ажиллагааны талаарх мэдлэг, мэдээлэл хомс байдаг байна.

Зарим газар оронд /улсад/ өөрсдөө энэ асуудлыг хохирогч болсноороо гэмт хэрэг үйлдэгч мэт болдог хандлага байна. Энэ нь ихэвчлэн лалын шашинтай улс орнуудын хувьд түгээмэл байдаг.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нийгэм эдийн засгийн хөгжил буурай, хүмүүсийн ухамсар сул дорой байдал, ядуурал, ажилгүйдэл нь хүмүүсийг ийм гэмт хэрэг үйлдэхэд таатай орчныг бүрдүүлж өгдөг.

Нөгөөтэйгүүр залуусын дунд гадаад орнуудад хууль бусаар цагаачлан ажиллах, амьдрах болсон, охид эмэгтэйчүүд гадны иргэдтэй гэр бүл болох сонирхол дэлгэрсэн гадаадын иргэд бага насны хүүхдүүдийг үрчлэн авч байгаа зэрэг нөхцөлүүд нь энэ гэмт хэрэг үйлдэгдэх таатай нөхцөлийг бүрдүүлж байгааг хэлэх хэрэгтэй.

Монголчууд гадаадын улс орнуудын тухай хөнгөн хийсвэр төсөөлөлтэй, зуучлагч хүмүүсийн худал хуурмаг үгний нөлөөнд хурдан автамтгай, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүрч буй зарын агуулгад анхаарал хандуулдаггүй зэрэг нь нөлөөлж байна.

Монголын эмэгтэйчүүд сүүлийн үед богино хугацаанд ахиухан хэмжээний мөнгө олох хүсэл сонирхолдоо автан сонин хэвлэлээр гарсан зарын дагуу цаад талын ашиг сонирхлыг үл огоорон олноороо гадаад улс оронд янз бүрийн хууль бус аргаар гарах нь хэвийн үзэгдэл болж байна.

Анх 2001 онд Югослав улсад хоёр монгол эмэгтэйг ОХУ-ын харьяат иргэн хууран мэхэлж аваачин хүчээр биеийг нь үнэлүүлсэн гэмт хэрэг гарч шуугиан тарьснаас хойш нилээд хэдэн гэмт хэрэг шүүхээр шийдвэрлэж зарим нэг нь мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байна.

Энэ төрлийн гэмт хэрэг ихэвчлэн хохирогч талын мэдүүлэг дээр голлож нотлогддог. Учир нь энэ гэмт хэргийн сэжигтэн этгээдүүдийн ихэнх нь манай орны харьяат биш гадаад улс оронд амьдардаг, гадаадын харьяат иргэд байдаг тул хүндрэлтэй байдгаас гадна энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд тодорхой бэрхшээлүүд гардаг.

Гэвч амьдрал практик дээр энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болсон эмэгтэйчүүд энэ талын мэдээллийг нуух, ямар нэгэн байдлаар дарамт шахалтад орох, өөрийн нэр төр, алдар хүндийг бодох, төрөл садан болон гэр бүлийнхэндээ мэдэгдэхгүйн тулд мэдүүлгүүдээсээ буцах хандлага гаргадаг.

Нөгөө талаар хуулийн байгууллагын практикт нэгэнт шалгаж тогтсон практик энэ төрлийн гэмт хэрэг дээр байдаггүй учраас хуулийн байгууллагын ажилтнуудаас уг гэмт хэргийн мөн чанар учир холбогдлыг анхааралгүйгээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэдэг байдал ажиглагддаг.

Ингэснээр тухайн гэмт хэргийг үйлдсэн этгээдүүд ял завших магадлал өндөр байдаг.

Мөн үүнээс гадна гадаад орны иргэд Монгол улсаас хүүхэд үрчлэн авч нутаг буцдаг. Энэ асуудал зөвхөн нэг яамны хэмжээнд шийдэгдэж байгаа нь анхаарвал зохих асуудлын нэг яалт ч үгүй мөн билээ.

Насанд хүрсэн хүн Монгол улсын харьяатаас гарахдаа өргөдлөө Монгол улсын Ерөнхийлөгчид хандаж шийдвэрлүүлдэг. Гэтэл Монгол улсын иргэн насанд хүрээгүй хүүхдийн асуудал яахаараа нэг яамны шийдэх асуудал болж байгаа нь сонирхолтой. Үүнийг ялгаварлан гадуурхалт гэж үзэх үү?

Гэтэл эдгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, амьдрах нөхцөл орчны талаар хяналт тавьж байгаа нэг ч байгууллага, эрх зүйн зохицуулалт үнэндээ алга байна.

Үрчлэгдсэн хүүхдүүдийн хэд нь охин хүүхэд байсан ямар насны хүүхдүүд аль оронд үрчлэгдэж байгаа талаар ч мэдээлэл хомс, зөвхөн нэг яамны тайлан мэдээнд тусгагдаад явж байгааг ч анхаарах цаг нэгэнт болсон байна. Монгол эмэгтэйчүүд ихэвчлэн БНХАУ, Макао, Гонгконг, Япон, Солонгос, Сингапур, Малайз, Герман зэрэг орнуудад худалдаалагддаг байна.

Хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор 2000 оны 12-р сард “НҮБ-ын улс хоорондын зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг “олон улсын конвенцид нэмэлт болгож “...Хүн худалдаалах ялангуяа охид, эмэгтэйчүүдийг худалдах, залхаан цээрлүүлэхийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх протокол” гарсан байна.

Хэдийгээр энэ асуудлын талаар олон улсын гэрээ конвенцууд гарсан байгаа хэдий ч монгол улс эдгээр олон улсын гэрээ конвенцийг соёрхон баталж нэгдэн ороогүй байна.

Гэвч эмэгтэйчүүд, охидыг хил дамнуулан худалдаалахын эсрэг олон улсын гэрээ, конвенцуудад нэгдэн орох зайлшгүй шаардлага урган гарч байгааг дээрх асуудлууд бэлхнээ харуулж байна.

ХҮНИЙ ЭРХ БА УЛСЫН БҮРЭН ЭРХЭТ БАЙДАЛ

Г.Нарантуяа
ХЭҮК-ын референт

Хүний эрхийг хамгаалахын төлөө тэмцэл хил хязгааргүй болжээ. Харин төрийн бүрэн эрхэт байдал хил хязгаарыг хүсэмжилнэ. Гэвч эдгээр ойлголтууд үл эсрэгцэнэ. Учир нь иргэнийхээ эрхийг бүрэн эрхэт төр баталгаажуулж, эрх бүхий иргэд нь бүрэн эрхэт төр улсыг бий болгож байдаг юм. Хүний эрх, улсын бүрэн эрхэт байдал хэмээх ойлголтуудын харилцан хамаарлыг хөндөх онолын цуврал өгүүллүүдийн эхний хэсгийг та бүхний өмнө дэлгэж байна. Хүмүүнлэгийн халдлага, хүмүүнлэгийн оролцоо, глобальчлал, эрх, эрх чөлөөний хязгаарлалт гэх мэт хүний эрхийн онолын хүрээнд харьцангуй шинэлэг хэдий ч эн салбарын судлаачийн зайлшгүй өнгийж үзэлтэй сэдвүүдээр өгүүллүүд үргэлжлэх болно.

НЭГ. ХҮМҮҮНЛЭГИЙН ИНТЕРВЕНЦИ

2003 оны 3-р сарын 20-ны Пүрэв гарагт АНУ, цэргийн эвсэл болох Их Британийн хамт 300 000 орчим цэргийн хүчээр Иракт довтоллоо. Энэхүү дайныг эхлүүлэх тухай шийдвэр НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөр дэмжигдээгүй бөгөөд Франц, Герман, Орос, Хятад улсууд болон НҮБ-ын гишүүн ихэнх улс эсэргүүцэж байлаа. Энэ үйл явдлыг судлаачдын нэг хэсэг олон улсын харилцаанд улс төрийн хямрал авчирсан ажиллагаа гэж байсан бол нөгөө хэсэг нь терроризмын эсрэг авч буй чухал арга хэмжээ, Иракийн ард түмний эрх, эрх чөлөөний төлөөх “хүмүүнлэг” дайралт хэмээн тайлбарлаж байсан юм. Тэртээ Ойрхи Дорнодод эхэлсэн цэрэг дайны үйл ажиллагаа Ази тивийн цээжнээ орших Монгол улсыг ч тойроогүйг бид мэдэх билээ.

Хүмүүнлэгийн интервенц /Энэхүү ойлголтыг монгол хэлнээ орчуулж гаргасан ном зохиолд хүмүүнлэгийн зорилгоор хөндлөнгөөс оролцох хэмээсэн нь олонтаа байна. Гэвч өгүүлэлд хүмүүнлэг халдлага гэж нэрлэе./ хэмээх нэр томъёо анх 17-р зууны үед олон улсын эрх зүйд орж иржээ. Хьюго Гротуус нарын эрх зүйчдийн эх барьж авсан гэгддэг энэ онолын анхны агуулга нь аливаа нэг улсын нутаг дэвсгэр дээр хүний эрхийн зөрчил, хүчирхийлэл газар авч, иргэдийн оршин суух нөхцөл байдал бүрмөсөн алдагдсан тохиолдолд энэ байдлыг таслан зогсоохоор нэг буюу хэд хэдэн улсын зүгээс тухайн улсад зэвсэглэн халдах ажиллагааг хууль ёсны зүйл хэмээсэнд оршиж

байгаа юм. Х.Виктор Кондэ гуай уг үйлдлийг хүн төрөлхтнийг цочоосон, түрэмгий халдлагаас хүмүүсийг хамгаалах зорилгоор түрэмгийлэл үйлдэгдэж буй улсын бүрэн эрхэт байдалд заналхийлэхгүйгээр өөр улс хөндлөнгийн халдлага хийж буй үйлдэл хэмээн тодорхойлжээ.

Хүмүүнлэгийн халдлагын тухай ойлголт нь онолын хувьд *jus ad bellum* номлолтой нягт холбоотой. Олон улсын эрх зүйн дагуу нэг буюу хэд хэдэн улсын эсрэг эвсэлд нэгдсэн бусад улстай хамтран, эсвэл төлөөлөх байгууллагаараа дамжуулах зэвсэгт мөргөлдөөнд оролцох эрхийг хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн зарчмыг *jus ad bellum* буюу дайн хийх эрх /right to war/ гэдэг.¹ Энэхүү номлол нь хүмүүнлэгийн хуулийг² зөрчилгүйгээр цэрэг дайны ажиллагаа явуулах, хүч хэрэглэсэн болон дайнд оролцсоныхоо төлөө эрүүгийн хариуцлага хүлээхгүй байх нөхцөлийг бүрдүүлдэг ажээ.

Олон улсын эрх зүйн хөгжлийн явцад хүмүүнлэгийн халдлагын талаарх анхны тодорхойлолтод өөрчлөлт орж, хүч хэрэглэх эрхийг олон улсын байгууллага хадгалах болов. НҮБ-ын дүрмийн 2-р зүйлийн 4 дэх хэсэгт³ улс орнууд өөрийгөө хамгаалахаас бусад тохиолдолд зэвсэгт халдлага хийхийг хориглосон нь хүмүүнлэгийн халдлагын анхны тодорхойлолтыг өөрчилсөн юм. Түүнчлэн тус дүрмийн 24-р зүйлийн 1 дэх хэсэг⁴, 7-р бүлэгт⁵ НҮБ-ийн Аюулгүйн зөвлөл нь олон улсын эрх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах үүднээс шаардлагатай гэж үзсэн аливаа арга хэмжээ авах эрхтэй болохыг заасан байна. Ийнхүү эрх олгогдсон учраас Аюулгүйн Зөвлөлийн гишүүд тохиролцоонд хүрч, гарч буй үйлдлийг олон улсын эрх тайван, аюулгүй байдалд хохирол учруулж байна хэмээн үзсэн тохиолдолд НҮБ тухайн улсад хүмүүнлэгийн халдлага хийж болох юм. Түүнчлэн, Аюулгүйн Зөвлөл нь ямар үйлдлийг олон улсын эрх тайван, аюулгүй байдалд хохирол учруулхуйц гэж үзэхийг тодорхойлон томъёолох үүрэгтэй. Энэ талаар НҮБ-ын дүрмийн 39-р зүйл заасан байдаг.⁶

¹ Тухайн улсад халдан довтолсон тохиолдолд нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлаа хамгаалах зорилгоор дайны ажиллагаа явуулах эрхтэй. Х.Виктор Кондэгийн “Хүний эрхийн олон улсын нэр томъёоны гарын авлага” бүтээлийн 90-р хуудаснаас үзнэ үү.

² 1899 болон 1907 оны Гаагийн дүрэм, 1949 оны Женевийн 4 конвенци, эдгээр конвенциудын 1977 оны 2 нэмэлт протокол болон бусад зэвсгийн талаарх тодорхой гэрээнүүд олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг бүрдүүлдэг.

³ НҮБ-ын бүх гишүүн нь олон улсын харилцаандаа аливаа улсын бүрэн бүтэн байдал буюу улс төрийн тусгаар тогтнолын эсрэг хүчээр сүрдүүлэх болон хүч хэрэглэх, түүнчлэн НҮБ-ын зорилгод харшлах ямарваа бусад үйлдэл хийхийг цээрлэнэ.

⁴ НҮБ-ын шуурхай бөгөөд үр нөлөөтэй ажиллагааг хангахын тулд түүний гишүүд олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулах гол хариуцлагыг Аюулгүйн зөвлөлд хүлээлгэж, уг Зөвлөл энэ хариуцлагаас үүдэн гарах үүргээ биелүүлэхдээ гишүүдийн нэрийн өмнөөс ажиллаж байгыг зөвшөөрөв.

⁵ Тус бүлэгт НҮБ-ын энх тайванд заналхийлэх, энх тайвныг бусниулах, түрэмгийлэл үйлдэх тухайд авах арга хэмжээний талаар заажээ.

⁶ Энх тайванд учирч байгаа аливаа заналхийлэл, энх тайвныг бусниулж байгаа аливаа зөрчил буюу түрэмгийлсэн үйлдэл байгааг Аюулгүйн зөвлөл тодорхойлох бөгөөд олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сэргээн тогтоох талаар 41, 42-р зүйлийн дагуу ямар арга хэмжээ авбал зохих тухай шийдвэр гаргана.

Улс орны бүрэн эрхэт байдал болон хүний эрх, эрх чөлөөний харилцан хамаарал, тэнцвэртэй байдал нь хүмүүнлэг халдлага хэмээх ойлголтын гол мөн чанар юм. Учир нь, аливаа улсад гарч байгаа хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох явдал нь хүмүүнлэгийн халдлага явуулах шийдвэр гаргахад хүргэж буй гол шалтгаан нь байх ёстой бөгөөд энэ ажиллагааны дүнд тухайн улсын бүрэн эрхэт байдал зөрчигдөх болдгоороо хүмүүнлэгийн халдлага нь бусад цэргийн ажиллагаанаас ялгаатай.

НҮБ-ийн дүрмийн 2-р зүйлийн 7-р хэсэгт⁷ зааснаар улс орны бүрэн эрхэт байдал нь олон улсын харилцааны тулгуур ойлголтын нэг мөн бөгөөд гадны ямар нэг оролцоогүйгээр дотоод асуудлаа бие даан шийдвэрлэх хууль ёсны эрх мэдлийг улс гүрнүүдэд олгодгоороо дорой буурай улс орнуудыг хүчирхэг гүрний нөлөөллөөс хамгаалдаг. өнгөц харахад бүрэн эрхэт байдлын зарчмыг дэлхийн хаа ч адилхан дээдлэгдэх, эдлэгдэх учиртай хүний эрхийн түгээмэл байх зарчимтай сөргөлдөх боломжтой хэмээн тайлбарлаж болох мэт. Улс гүрнүүд олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу хүний эрхийг хамгаалах, хөхүүлэн дэмжих үүрэгтэй хэдий ч бүрэн эрхэт байдал хэмээх далбааны цаана хүний эрхийг зөрчигчид нуугдаж болох талтай. Гэвч НҮБ-ын дүрмийн үзэл санаанаас улс орны бүрэн эрхэт байдлыг хэт дөвийлгөлгүй хүний эрхийн зарчимтай харилцан тэнцвэртэйгээр авч үзэх ёстой нь харагдаж байна. Тухайлбал, тус дүрмийн 55-р зүйлд *“Улс түмний тэгш байх, өөртөө засан тохинох зарчмыг хүндэтгэх үндсэн дээр улс үндэстнүүдийн хоорондын энх тайван, найрсаг харилцаанд зайлшгүй хэрэгтэй тогтвортой байдал, сайн сайхан аж байдлын нөхцөлийг бүрдүүлэх үүднээс НҮБ нь ... арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэгээр үл алагчлан хүний эрх, бүх нийтийн үндсэн эрх чөлөөг бүх нийтээр хүндэтгэн сахихад тус дөхөм үзүүлнэ...”* гэж заажээ.

Эрхийг тодорхойлох хандлагын үүднээс авч үзвэл⁸, олон улсын эрх зүйн тулгуур баримт бичгүүдэд заасны дагуу аливаа хувь хүн хүмүүнлэгийн туслалцаа хүртэх эрхтэй бөгөөд олон улсын байгууллагад ч бас ямар нэг улсын хүсэл зоригоос үл хамааран хүмүүнлэгийн туслалцааг хүмүүст хүргэх эрх бий. Энэ нь зөвхөн эрх төдийгөөр хязгаарлагдахгүй бөгөөд хүний эрхийн нийтийг хамарсан ноцтой зөрчлийг таслан зогсооход хөндлөнгөөс оролцох үүрэгтэй юм.

Хүмүүнлэгийн халдлагын талаар дээр өгүүлсэн онолын тодорхойлолтоос өөр олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажсан тодорхойлолт одоогоор алга байна. Гэсэн хэдий ч дэлхий нийтэд энх тайван тогтоож, хүн бүрийн эрх, эрх чөлөөг бодитойгоор эдлүүлэх үүднээс

⁷ Энэхүү дүрмийн ямар ч заалт аливаа улсын дотоод эрх мэдэлд гарцаагүй хамаарах асуудалд хөндлөнгөөс оролцох эрхийг НҮБ-д олгохгүй бөгөөд тийм асуудлыг энэхүү дүрэмд заасан журмаар шийдвэрлүүлэхээр мэдүүлэхийг гишүүн улсуудаас үл шаардана. Гэхдээ энэ зарчим нь 7-р бүлэгт заасан албадах арга хэмжээ хэрэглэхийг үл хөндөнө.

⁸ Хувь хүн олон улсын эрх зүйн субъект болох халдлага сүүлийн үед ихээхэн нэмэгдэж байна.

хүмүүнлэгийн халдлага хийх тохиолдол практик дээр цөөнгүй байгаа билээ. Тухайлбал, Аюулгүйн Зөвлөлөөс Иракийн Курдууд, хуучин Югослав болон Гайти улсад хэрэгжүүлсэн цэргийн ажиллагааг энд дурдаж болох юм. Түүнчлэн, хуучин Югославын нутаг дэвсгэрт төрлөөр устгах болон дайны гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг шүүх үүрэгтэй Трибунал буюу цэргийн шүүхийг байгуулж арга хэмжээ авч буй явдлыг ч мөн хүмүүнлэгийн халдлагын шинэ хэлбэр хэмээн үзэж болох талтай. Мөн НҮБ төдийгүй улс орны зүгээс өөр улсад хүмүүнлэгийн халдлага хийж байсан тохиолдолд олон улсын харилцааны практикт бий. 1971 онд Зүүн Пакистанд Баруун Пакистаны Армийн өдөөсөн хүний эрхийн ноштой зөрчил хариу өгөх зорилгоор Энэтхэгийн явуулсан цэргийн ажиллагаа болон 1979 онд Иди Амины бурангуй дэглэмийг түлхэн унагаахаар Танзанийн Угандад хийсэн зэвсэгт халдлагын энд дурдаж болох юм.

Хүмүүнлэгийн халдлага нь хэдийгээр хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс авч буй чухал ач холбогдолтой алхам боловч энэ арга хэмжээг олон улсын эрх зүйгээр нарийвчлан зохицуулахгүй бол улсын бүрэн эрхэт байдалд хохирол учруулж болзошгүй. Үүний тул ямар арга хэмжээг хүмүүнлэгийн халдлага гэж үзэх талаар тодорхой шалгуур боловсруулж, хангагдаж байгаа эсэхэд хяналт тавих нь чухал ач холбогдолтой юм. Олон улсын эрх зүйн ном зохиол, эрдэмтдийн зохиол бүтээлээс нэгтгэж үзвэл дараах шалгуурыг хангасан цэргийн ажиллагааг хүмүүнлэгийн халдлага гэж үзэж болох мэт. Үүнд:

- Тухайн улсад/газар нутагт нийтийг хамарсан хүний эрхийн ноштой зөрчил гарсан байх
- Тийнхүү хүний эрх, эрх чөлөө ноштой зөрчигдөж байгааг нотлох тодорхой нотлох баримттай байх
- Тухайн улсын засаг захиргааны зүгээс ийм үйлдлийг таслан зогсоох, зөрчигдсөн эрхийг сэргээх талаар арга хэмжээ авах хүсэл зориггүй байх эсвэл тийм арга хэмжээ авах боломжгүй байх
- Авах арга хэмжээ цаг үеийн хувьд яаралтай байх
- Хүч хэрэглэх нь эцсийн, зайлшгүй арга хэмжээ болсон байх
- Халдлагын ажиллагаанд аль болох олон тооны оролцогч оролцох боломжтой байх /Олон улсын хамтын нийгэмлэгийн зөвшөөрлийг авсан байх/
- Халдлагын зорилго нь олон нийт болон олон улсын хамтын нийгэмлэгт тодорхой байх
- Халдлагын зорилго нь зөвхөн тухайн нутагт гарсан хүний эрхийн зөрчлийг таслан зогсоохоор хязгаарлагдаж байх
- Халдлагад оролцож буй хүчний хэмжээ халдлагын зорилгод тохирсон байх

- Хүмүүнлэгийн халдлага нь гарцаагүй амжилтад хүрэх магадлалтай байх
- Хүмүүнлэгийн халдлагыг зорилтот улсын иргэд дэмжиж байх
- Дайны дараах сэргээн босголтын талаарх дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулсан байх
- Хүмүүнлэгийн халдлагын үед олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн хэм хэмжээ чанд мөрдөгдсөн байх гэсэн шалгууруудыг тавьж болох юм.⁹

Олон улсын эрх зүй бол өнгөрсөн зууны дунд үеэс л эрчимтэй хөгжиж эхэлсэн харьцангуй шинэ эрх зүйн салбар учир үндэсний эрх зүйтэй харьцуулахад зохицуулж чадаагүй харилцаа олон бий. Түүнчлэн, харилцан адилгүй ашиг сонирхолтой улс орнуудын хоорондын харилцааг зохицуулдаг онцлогтой нь уялдан эрх зүйгээр зохицуулахад төвөгтэй олон улсын харилцаа ч нэн элбэг. Ийм асуудлуудын нэг бол яахын аргагүй хүмүүнлэгийн халдлага юм. Өмнө өгүүлсэнчлэн ийм арга ажиллагааг хэрхэн явуулах талаар тусгай горим журам үгүй учраас хүмүүнлэгийн халдлагатай холбоотой маш олон асуудлууд өнөөг хүртэл асуултын тэмдэгтэй хэвээр байна. ТУХАЙЛБАЛ,

Бидний нүдний өмнө өрнөж буй Иракийн дайны ажиллагаа Их Британийн Ерөнхий сайд Тони Блайрын тодорхойлсны адил үнэхээр хүмүүнлэгийн халдлага мөн үү? Эсвэл өөрийгөө хамгаалах ажиллагаа буюу *ius ad bellum*-ийн үндсэн дээр авч буй арга хэмжээ юу? Ер нь аливаа улсад хүмүүнлэгийн халдлага хийхэд НҮБ-ийн зөвшөөрөл шаардлагатай юу? Хэрвээ энэ асуултад шаардлагагүй гэж хариулахад хүрвэл НҮБ-ийн дүрмийн хүч хэрэглэхийг хязгаарласан заалтад маш том өөрчлөлт орох нь тодорхой.

Хүмүүнлэгийн халдлагын талаар тодорхой горим журмыг бий болгож чадах дээрх маягийн шалгууруудыг хэн баталж, хэн хэрэгжилтэд нь хяналт тавьж болох вэ? Хамгийн боломжит субъект бол НҮБ бөгөөд хэрвээ ийм шалгуурууд батлагдвал НҮБ-ийн дүрмийн 7-р бүлгийг өөрчлөн найруулж таарна, түүнчлэн олон улсын энх тайван, аюулгүй байдалд хохирол учруулхуйц хүмүүнлэгийн гамшгийн талаарх ойлголт ч энэ хэвээр үлдэхгүй нь ойлгомжтой. Олон улсын хамтын нийгэмлэгээс хүний эрхийн ноцтой зөрчил, хүмүүнлэгийн гамшиг гэх зэрэг ойлголтуудыг тодорхойлоход улс төржих хандлага бий болох нь маргаангүй. Аливаа ойлголтыг тайлбарлах хүмүүнлэгийн хандлага бол асуудлын зөвхөн нэг тал бөгөөд улс төрийн, цэргийн болон эдийн засгийн гэх мэт ашиг сонирхол олон улсын бусад

⁹ CSS Brief paper, HUMANITARIAN INTERVENTION: Definition and Criteria болон Sovereignty eclipsed? Legitimacy of humanitarian intervention and accession зэрэг өгүүллүүдийг интернэтийн google хайлтын систем, www.jha.ac/articles/a019.htm сахим хуудаснаас дэлгэрүүлэн үзнэ үү.

шийдвэрийн нэгэн адил эдгээр ойлголтыг тайлбарлах тусгагдаж болох талтай.

Ямар тохиолдолд хүмүүнлэгийн халдлага жинхэнэ нэн шаардлагатай хүмүүнлэг ажиллагаа байж, хүний эрхийг хамгаалах, зөрчлийг таслан зогсоох, хохирлыг барагдуулах зорилгоо гүйцэлдүүлж чадах вэ? Асар их хэмжээний хүн хүч, хөрөнгө санхүү, зэр зэвсгийн нөөц шаардагдах цэрэг дайны үйл ажиллагааг аливаа улс зөвхөн хүмүүнлэгийн зорилгоор явуулах нь хэр боломжтой бол? Хүмүүнлэгийг халдлагыг улс төрийн зорилгоор ангид байлгах, зөв голидролоор явуулах ухаалаг хөшүүрэг чухам юу байж таарах вэ?

Маргаан мэтгэлцээний талбар болсоор байгаа, тодорхой хариултгүй, цаашид улам илүү судлагдах, хөгжих шаардлагатай ийм мэтийн олон асуудал олон улсын эрх зүйчдийн өмнө тавиагатай байна. Та ч гэсэн энэ талаар нарийвчлан судалж, хүний эрхийг хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулж юу нь болохгүй гэж?

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ХҮНИЙ ЭРХИЙН СУРГАЛТ

У.Туяа

Боловсрол судлалын докторант

Хүний эрхийн сургалт нь агуулга, арга зүйн хувьд ерөнхий боловсролын сургуульд судлагдаж буй бусад хичээлээс ялгагдах өвөрмөц онцлогтой. Энэ нь тухайн судлагдахууны хэрэгцээ, шаардлага, зорилго, агуулгаас үүдэлтэй.

Хүний эрхийн сургалтын онцлог

- Хүний эрх нь өөрөө мөн чанарынхаа хувьд түгээмэл, зайлшгүй, тэгш, ялгаварлан гадуурхахгүй байх, эрхэм байдлыг хүндэтгэх зарчимтай тул мөн л тийм зарчим дээр үндэслэсэн сургалт явуулах хэрэгтэй болдог.
- Хүний эрхийн сургалтад оролцогчид бие биеэ ойлгосон, хүндэтгэсэн, хүлээн зөвшөөрсөн өөрөөр хэлбэл танхимын уур амьсгал нь ардчилсан байх шаардлагатай байдаг.
- Хүний эрхийн сургалт нь оролцогчдод үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бүлэг, хамт олныг төлөөлөх, шийдвэр гаргах, үндэслэл нотолгоо дэвшүүлэх, бусдыг сонсох, санал нийлэхгүй ч гэсэн тэдний санал бодлыг хүндэтгэх, бусдын соёлыг хүлээн зөвшөөрөх, хамтран ажиллах, хүлээцтэй байх зэрэг иргэний ардчилсан нийгмийн үнэт чадваруудыг төлөвшүүлэхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулдаг.
- Хүний эрхийн боловсрол нь хүүхдэд тухайн хичээлээс гадна анги хамт олон, сургууль, гэр бүл, найз нөхөд зэрэг хүрээлэн буй нийгмийн бичил орчноор дамжин олгогддог.

Хүний эрхийн боловсролын агуулгын түүхээс

Ерөнхий боловсролын сургалтаар хүний эрхийн боловсролыг олгох гол хичээл нь эрх зүйн хичээл байлаа. Эрх зүйн сургалт нь манай улсын хувьд 1938 оноос судлагдаж байсан түүхэн уламжлалтай судлагдахуун юм.

Сургалт эхэлсэн хичээлийн жил	Хичээлийн нэр	Судлах анги	Судлах цаг
1938-1939	БНМАУ-ын үндсэн хууль	ҮII	70
1975-1976	БНМАУ-ын төр, эрх зүйн үндэс	ҮIII	70
1987-1988	Ёс зүй	IX	70
1992-1993	Эрх зүй	Ү	70
1994-1995	Эрх зүй	ҮI-ҮIII	105
1998	Эрх зүй	I-X	159

Уг хичээлийн зорилго, агуулга, арга зүй, үнэлгээ нь тухайн үеийнхээ нийгэм-түүхийн нөхцөл, шаардлагын дагуу тодорхойлогдож байсан нь ойлгомжтой. 1990-ээд оны сүүлч хүртэл эрх зүйн хичээлээр хүний эрхийн тухай авч үзэхдээ агуулга нь үндсэн хуулийн хүрээнд, хүний эрхийн холбогдолтой зүйл, заалтыг тусгаж, арга зүй нь тайлбарлах, цээжлүүлэх сургалтыг голлож ирсэн байна. Тухайлбал, 1998 оны стандарт: 14.2.3. . . . эрх зүйгээр

- Иргэний үндсэн эрхүүд (амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, эд хөрөнгө олж авах, эзэмших, өмчлөх, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, эрүүл мэндээ хамгаалуулах, эвлэлдэн нэгдэх, эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш эрх эдлэх, халдашгүй чөлөөтэй байх, шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх, чөлөөтэй зорчих, оршин суух гэх мэт)
- Иргэний үндсэн үүргүүд (Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх, хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хуулиар тогтоосон албан татвар төлөх, хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах гэх мэт)-ийг судлахаар заасан байна. /Түүх, нийгмийн ухааны боловсролын стандартыг хэрэгжүүлэх зөвлөмж. УБ. 1998. 13-р тал/

МННХ-ийн “Хууль бидний амьдралд” хөтөлбөрийн хүрээнд энэхүү хичээлийн хөтөлбөрийг сурах бичгийн хамт бүрэн шинэчилсэн явдал бол хүний эрхийн боловсролын салбарт гарсан том амжилт юм. Энэ ажлын хүрээнд хүний эрхийн хичээлийн сурах бичгийг шинэчлэн, 2003 оноос эхлэн ЕБС-д ашиглаж эхэлсэн байна.

2004 онд шинэчлэн баталсан “Түүх, нийгмийн ухааны боловсролын стандарт”-ын хүрээнд хүний эрхийн боловсролын агуулга, үнэлгээг тусгаж өгсөн нь хүний эрхийн боловсролыг шинэ шатанд гаргах ач холбогдолтой юм.

“Түүх, нийгмийн ухааны боловсролын стандарт”-д хүний эрхийн агуулга тусгагдсан нь

2002 оноос боловсруулагдаж 2004 онд шинэчлэгдэн батлагдсан “Түүх, нийгмийн ухааны боловсролын стандарт”-д дүн шинжилгээ хийж үзэхэд ерөнхий боловсролын сургуулийн бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшин бүрд хүний эрхийн боловсролын агуулга багтаж байна. Ерөнхий боловсролын сургуулиар олгох эрх зүйн боловсролын агуулга нь “дүрэм, журам, хууль”, “эрх үүрэг”, “төрийн байгуулал”, “салбар эрх зүй” гэсэн үндсэн 4 айгаас бүрдсэн байна.

Агуулгын ай нь тухайн боловсролын хувьд хамгийн үндсэн, тогтвортой, энгийнээс нарийн, хөнгөнөөс хүндэд шилжих мэдлэг, ухагдахууныг тээгч бөгөөд анхан, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд анхан шатны болон үндсэн ойлголт нь хэвээр хадгалагдаж, агуулгын хувьд гүнзгийрэн баяжиж байх мэдлэгийн цөм (хүрээ) юм. Агуулгын ай тус бүр нь тодорхой мэдлэгийн системийг агуулах бөгөөд тэрхүү мэдлэг нь зөвхөн тогтоох, цээжлэхийн тулд бус харин хэрэглэгдэх, ашиглагдах өөрөөр хэлбэл, суралцагчдад тодорхой төрлийн чадваруудыг тогтоох зорилгыг агуулсан байна.

Судлагдахууны агуулгыг тоочин тогтоодог байсан хуучин уламжлалаас татгалзаж агуулгын айг тогтоож өгсөн нь зөвхөн тоочсон агуулгыг дамжуулан заах “уйтгартай бөгөөд идэвхгүй” үүргээс багшийг чөлөөлж тухайн айн хүрээнд тодорхой мэдлэг, чадвар, хандлага бүхий цогц чадамжийг суралцагчдад төлөвшүүлэх тийм агуулгыг сонгох “эрх чөлөөг” багшид олгожээ.

Дээрх стандартаас үзэхэд нэг ангийн хүрээнд яригдаад өнгөрдөг байсан хүний эрхийн агуулгыг “эрх үүрэг” айгаар дамжуулан ерөнхий боловсролын бүх түвшинд судалж, сурагчдад хүний эрхийн мэдлэг, хандлага, чадварыг төлөвшүүлэхээр оруулсан байна. Энэхүү стандарт нь юуг, яаж шинэчилсэн бэ?

Зорилго, хүлээх үр дүнгийн хувьд; Хүний эрхийн хичээлээр дамжуулан суралцагчдад хүний эрхийн зохих мэдлэг, өөрийн эрхээ хэрэгжүүлж, зөрчигдсөн эрхээ хамгаалах чадвар суулгаж, хүний эрх, ялгаатай соёлыг хүндэтгэдэг “ЦОГЦ ЧАДАМЖ”-ийг төлөвшүүлэх нь хүний эрхийн боловсролын зорилго юм. Энэхүү зорилгыг хэрэгжүүлснээр түргэн хурдацтай өөрчлөгдөн хөгжиж, бас шийдвэрлэхийг шаардсан бэрхшээлтэй асуудал улам бүр тулгарч байгаа өнөөгийн XXI зуунд ажиллаж, амьдрах, шийдвэр гаргах арга барил, технологийг эзэмшүүлж, бусадтай хамтран ажилладаг, тэдний соёлыг ойлгон хүндэтгэдэг иргэн болгон төлөвшүүлэх үр дүнд хүрэх билээ.

Агуулгын хувьд; Түүх, нийгмийн ухааны боловсролын Эрх зүйн боловсролын агуулгын стандарт нь “Дүрэм, журам, хууль”, “Эрх,

үүрэг”, “Төрийн байгуулал”, “Салбар эрх зүй” гэсэн агуулгын айтай. Агуулгын ай нь үндсэн, тогтвортой, энгийнээс нарийн, хөнгөнөөс хүндэд шилжих мэдлэг, ухагдахууныг тээгч бөгөөд анхан, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд анхан шатны болон үндсэн ойлголт нь хэвээр хадгалагдаж, агуулгын хувьд гүнзгийрэн баяжиж байх мэдлэгийн цөм (хүрээ) юм. Энэ нь судлагдахууны агуулгыг шинжлэх ухааны түүхэн мэдлэгт тулгуурлан сонгон боловсруулж байсан хандлагыг өөрчилж аль болох шинэ зууны иргэнд төлөвшсөн байвал зохих хүний эрхийн мэдлэг бүтээх (K1), хүний эрхийн мэдлэгээ ашиглан хийж сурах (K2), амьдарч сурах (K3), нийгэмшин иргэншиж сурах (K4) зэрэг цогц чадамжид баримжаалан сонгосноороо боловсролын стандартад орсон цоо шинэ үзэл хандлага билээ.

“Эрх, үүрэг” агуулгын айн залгамж холбоо, гүнзгийрэлт


Шатлал	K ₁ -ийг эзэмшүүлэх агуулга	K ₂ -ийг эзэмшүүлэх агуулга	K ₃ -ийг эзэмшүүлэх агуулга	K ₄ -ийг эзэмшүүлэх агуулга
Бага боловсрол	Хүүхэд ямар эрх, үүрэгтэй вэ Хүүхдийн эрхийг яаж хамгаалж, баталгаажуулсан байдаг вэ Дүрмийг биелүүлэхгүй байж болох уу	Хүүхдийн эрх хэрхэн хэрэгжиж байгаа талаар мэдээлэл цуглуулах, өөрийн цуглуулсан мэдээ, баримтыг нэгтгэн дүгнэх, танилцуулах Хүүхдийн эрхийн зөрчлийг ялган таниж, түүнийг арилгах, таслан зогсооход хэн, юу хийж болох талаар ярилцах		Өөрийн үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаад ажиглалт, дүгнэлт хийлгэх
Суурь боловсрол	Хүний эрх, эрх чөлөө Хувийн, нийгэм, соёлын болон эдийн засгийн, улс төрийн эрх Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, Хүний эрхийг хамгаалах олон улсын механизмын талаарх ойлголт, МУ-ын Үндсэн хууль	Хүний эрх хэрхэн хэрэгжиж байгаа талаар мэдээлэл цуглуулах, өөрийн нэгтгэн дүгнэх, танилцуулах Хүний эрхийн зөрчлийг ялган таньж, түүнийг арилгах арга замыг дэвшүүлэх, таслан зогсооход хэн, юу хийж болох талаар ярилцах	Зөрчигдсөн эрхийг сэргээхэд хуулийг болон олон улсын механизмыг ашиглах дадлага хийх материалыг бэлтгэх	Бусдын эрхийг хүндэтгэж, өөр үзэл бодлыг /соёлыг/ хүлээн зөвшөөрөх, хүлээцтэй хандагыг төлөвшүүлэхүйц дадлага ажил бэлтгэх
Бүрэн дунд боловсрол	Эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх, үүрэг	Эрх зүйн харилцаанд оролцогчдын эрхээ эдлэх боломж, үүргийг биелүүлж байгаад үнэлэлт, дүгнэлт өгөх, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар өөрийн санал, дүгнэлттэй болох боломжийг бүрдүүлэх		Хариуцлага хүлээх чадвартай болж байгаа эсэхийг ажиглах

Арга зүйн хувьд: Эрх зүйн сургалтын зарчим, зорилго, агуулгын өөрчлөлт нь энэ хичээлийн арга, аргачлалыг шинэчлэхийг шаардана. Энэхүү стандартын арга зүйн хөгжлийн үндсээр сургалтын арга зүйн хөгжлийн шинэлэг хандлагыг уламжлалт арга зүйтэй хослуулан бүтээлчээр хэрэгжүүлэхийг багш нарт зөвлөмжилсөн болно. Хүний эрхийн сургалтын аргын тухай бид дараагийн хэсэгт авч үзэх болно.


Үнэлгээний хувьд; Сургалтын зорилго, хүлээх үр дүн нь “ЦОГЦ ЧАДАМЖ” төлөвшүүлэхэд баримжаалсантай холбоотойгоор мэдлэгийг баримжаалж үнэлдэг байсан практикийг өөрчлөх арга замыг эрж хайсан нь энэ стандартын нэгэн шинэлэг тал юм. Энэ хүрээнд:

- ◆ “ЦОГЦ ЧАДАМЖ”-ийг үнэлэх шалгуурыг боловсруулж жишиг даалгавар оруулсан болно.

Ерөнхий боловсролын сургуулийн хүний эрхийн сургалтын гол зорилго нь дээрх стандартыг хангахад чиглэгдэх учиртай. Сургалтаар зөвхөн хүний эрхийн мэдлэг олгоод зогсохгүй хүний эрх, эрх чөлөөнд хүндэтгэлтэй ханддаг, эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн тохиолдолд ямар арга замыг ашиглан хаана, хэнд, хэрхэн хандахыг мэддэг, түүнийгээ хэрэглэх чадвар бүхий цогц чадамжийг суралцагчдад эзэмшүүлэх нь хүний эрхийн боловсролын стандартын гол зорилго билээ. Уг стандартыг хүний эрхийн сургалтад хэрхэн тусгаж болохыг дараах бүдүүвчээс харна уу.



Үйл ажиллагааны идэвхтэй стратеги гэж юу вэ?




Хэрвээ та сургалтаа явуулах идэвхтэй стратегийг сонгосон бол таны сургалт сурагчдынхаа оролцоонд тулгуурлан явагдах боллоо гэсэн үг. Ийм тохиолдолд Блумын таксномоор танин мэдэхүйн 6 түвшинд сурагчид юу хийх вэ?, та ямар үйл ажиллагааг зохион байгуулах менежментийг хийх вэ? гэдгийг дараагийн бүдүүвчээс харж болох юм.

Ерөнхий боловсролын сургуулийн хүний эрхийн сургалт



Хүний эрхийн хичээлийн менежментэд нөлөөлж байдаг гол хүчин зүйлсийг дараах бүдүүвчээр харууллаа.



Хүний эрхийн хичээлийн менежментийг хийхдээ багш дараах үйл ажиллагааг зохистой харьцаагаар хийж байдаг.

<p><i>ЗОХИОН БАЙГУУЛАГЧ- Багш</i></p>	<p>Зохион байгуулагч багш бол мэдээлэл цуглуулах, түүнийгээ боловсруулах аргын загвар гаргаж, материал эмхлэн цэгцлэх ахицтай аргууд, гол утга санаа агуулсан картын тусламжтайгаар хэлхээ холбоо бий болгох талаар сурагчдыг дэмжих, цаашдаа өөрийн сэтгэн бодох явцыг жолоодох арга боловсруулахад нь тэдэнд туслах учиртай.</p>
<p><i>ТУСЛАГЧ, ХАМТРАГЧ- Багш</i></p>	<p>Багш-зохион байгуулагч нь багш-дамжуулагчийг бодвол сурагчдад илүү идэвхтэй үүрэг гүйцэтгэх боломж олгодог. Багш-туслагчийн үүрэг нь сурагчдыг оюуны тэнцвэрээс нь гаргаж ямар нэг долгисол хөдөлгөөнд оруулахуйц асуудлыг дэвшүүлэн тавихад оршино. Ийм агшинд хүрсэн тохиолдолд сурагчид үзэгдэл, үйл явдалыг янз бүрээр авч үзэх, асуудлыг шийдвэрлэхээр хамтран ажиллаж, бодит байдлыг өөрийн туршлагаар танин мэдэхийн хэрээр бие даан илрүүлж авсан шинж чанарын талаар бясалган бодож хэлэлцэх боломжийг тэдэнд багш олгох ёстой.</p>

Хүний эрхийн боловсрол нь бусад боловсролоос илүү сургалтын орчныг шаарддаг. Ялангуяа анги, сургуулийн ардчилсан уур амьсгал, хичээлийн соёл зэрэг орчин нь өөрөө хүүхдэд хүний эрхийн боловсрол олгож байдаг. Иймээс зөвхөн хүний эрхийн сургалт явуулж байгаа багш төдийгүй, сургуулийн удирдах ажилтан, бусад мэргэжлийн багш нарын хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх нь хүний эрхийн боловсролын үр дүнд шууд нөлөөлнө. Өнөөдрийн байдлаар манай улсын ерөнхий боловсролын сургуулиудын удирдлага, багш нарын зүгээс сургуулийн хүний эрхийн орчныг материаллаг талаас нь илүүтэй харж байгаа нь нууц биш юм. Гэтэл хүний эрхийн орчин гэдэг нь материаллаг орчноос гадна сэтгэл зүйн буюу ардчилсан орчин байдаг. Сургуулийн хүний эрхийн орчин сайн байх тусам төдий чинээ хүний эрхийн боловсрол, мэдрэмжтэй болно гэсэн үг.

Хүний эрхийн боловсролыг хичээл хоорондын интеграцаар олгодог бусад орны туршлагыг судлах, үүний үндсэн дээр хүний эрхийн боловсролыг зөвхөн эрх зүйн хичээлээр бус түүх, уран зохиол, эх хэл зэрэг холбогдох хичээлээр интеграцчилан олгох нь илүү үр дүнтэй болно.

Ном зүй:

1. Монгол Улсын стандарт, Бага, дунд боловсрол, Түүх нийгмийн ухааны боловсрол. MNS5420-14:2004. СХЗҮТ. УБ хот
2. О.Пүрэв, Түүх, нийгмийн ухааны боловсрол УБ, 2001
3. НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр болон МУ-ын Хүний эрхийн Үндэсний комиссоос хийсэн “Ерөнхий боловсролын дунд сургуульд хҮний эрхийн боловсрол олгож байгаа өнөөгийн төлөв байдал”, “Хүний эрхийн боловсрол-ерөнхий боловсролын сургуульд” судалгааны тайлан. 2004, 2005 он.
4. Street law /sixth edition, student’s book and teacher’s manuel/ 1999.
5. Human rights for all

ОРШИН СУУХ ГАЗРАА СОНГОХ ЭРХ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ҮНДСИЙГ ШИНЭТГЭХ АСУУДАЛ

/Монгол Улсын иргэн улсынхаа нутаг дэвсгэрт
оршин суух газраа сонгох нь/

Ц.Цэрэнням
ХЗҮТ-н ажилтан

*Чөлөөтэй зорчих ба оршин суух газраа сонгох эрх¹
Право свободно передвигаться и выбирать место жительства
Right to freedom of movement and residence*

НЭГ. ОРШИН СУУХ ГАЗРАА СОНГОХ ЭРХИЙН ОЙЛГОЛТ

Орчин үед аливаа ардчилсан төр нь иргэнийхээ эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг нь сэргээн тогтоох, баталгаажуулах үүргийг хүлээдэг. Хүн бүр эрх зүйн этгээд болохын хувьд хүсэл зоригоо биелүүлэхийн тулд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны боломж, хэмжээ хязгаарыг хүний эрх, эрх чөлөө² гэнэ. Хүний эрх, эрх чөлөө нь хүний төрөлхийн заяагдмал эрхийг илэрхийлэхээс гадна эрх зүйн зохицуулалтаар хамгаалагдсан нийгмийн бодит байдлыг харуулдаг. Хүн тодорхой төр улсад харьяалагдаж, түүний ивээл хамгаалалтад багтахын хирээр өөрсдийн эрх чөлөөний боломж, нөхцөлийг ямагт эрэлхийлж, түүнийгээ бүрэн дүүрэн, зохистойгоор хангахын төлөө тэмцсээр ирсэн. Энэ тэмцэл нь хүний эрхийн үзэл санааны илэрхийлэл болж, Үндсэн хуулийн болон олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд агуулагдан, тусгагдаж иржээ. Хүний эрхийн үзэл санаа **олон улсын эрх зүйн хэм хэмжээнд** тусгалаа олж хожим Үндсэн хуулийн хэм хэмжээ болон хөгжсөн байна.

Хүний эрх, эрх чөлөө хэдий чинээ найдвартай хангагдаж, түүний баталгаа бүрэн хэрэгжинэ, төдий чинээ нийгмийн зорилго нь улам бүр хүмүүнлэг, ардчилсан шинжтэй болдог. Иргэний үндсэн эрх, эрх чөлөө

¹ НҮБ-ын Хүний эрхийн төв. Хүний эрхийн нэр томъёоны товч тайлбар толь. УБ., 1996 он. 53 дахь тал
² “Эрх”, “эрх чөлөө” гэдэг ойлголтыг тайлбарлахдаа “...улс орнуудын Үндсэн хуулиудын судалгаанаас үзэхэд “эрх чөлөө” гэсэн нэр томъёо нь ямар нэгэн тодорхой үр дүнг харуулахгүйгээр тухайн хүнээс илүү өргөн хүрээтэй сонголт хийх боломжийг тодруулж өгөхөд оршиж байна. Харин “эрх” гэдэг нэр томъёо нь тухайн хүний тодорхой үйл ажиллагааг тодорхойлдог” гэжээ. (Хүний эрх. УБ., 1997 он. 23 дахь тал)

нь хуулиар тогтоож олгосон тухайн улсын иргэний харьяалал бүхий хүний эдлэх эрх, эрх чөлөөний нэгдэл юм. Иргэдийн үндсэн эрх гэдэг бол хүний чөлөөтэй аж төрөх, амьдрах, өөрийгөө хөгжүүлэх бүх боломжийн хууль зүйн баталгаа болдог.

Оршин суух эрх. Аль ч улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин сууж байгаа этгээд тухайн улсын нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох, тухайн орныг орхиж явах эрхтэй. Энэхүү эрхийг улсын аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахуун буюу бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах үүднээс хуулиар хязгаарлаж болно.³

Дээрх эрх олон улсын гэрээ болон гадаадын зарим орны хуульд дараах байдлаар тусгагдсан байна.

НҮБ-ын Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай Олон Улсын Пактийн⁴ 12 дугаар зүйлд:

Аль нэг улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин сууж буй хүн бүр тухайн улсын нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчин явах, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй, ...энэ эрх нь хуульд заасан бөгөөд улсын аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахуун буюу бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах ашиг сонирхлын үүднээс болон энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн бусад эрхэд нийцсэнээс өөр ямар нэгэн шалтгаанаар хязгаарлагдахгүй.

Италийн Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд:

Иргэдийн эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал зэрэг нийтийг хамарсан хязгаарлалтаас бусад тохиолдолд иргэн бүр чөлөөтэй амьдрах, нүүн шилжих эрхтэй. Улс төрийн шалтгаанаар хязгаарлалт хийхийг хориглоно. Иргэн бүр Итали улсаас чөлөөтэй гарч гадаадад зорчих, эргэн ирэх эрхтэй.

Испанийн Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд:

Испаничууд оршин суух газраа ба үндэснийхээ газар нутгаар чөлөөтэй шилжин суурьших эрхтэй. Мөн тогтоогдсон хуулийн дагуу Испани улс руу чөлөөтэй нэвтрэх ба гарах эрхтэй. Иргэд гадаадад зорчих эрхтэй.

Грек улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд:

Грекийн иргэн улсаас гарах, орох, улс орондоо оршин суугаа газраа чөлөөтэй сонгох, шилжих тохиолдолд ямар нэгэн захиргааны шинжтэй хориг тавихыг хориглоно. Иргэд гадаадад зорчих эрхтэй.

³ НҮБ-ын Хүний эрхийн төв. Хүний эрхийн нэр томьёоны товч тайлбар толь УБ 1996 он. 53 дахь тал

⁴ Энэхүү Олон улсын гэрээ нь 1966 онд батлагдаж 1974 онд Монгол улс уг гэрээнд нэгдэн орсон.

Японы Үндсэн хуулийн 22 дугаар зүйлд:

Хүн бүр амьдрах газраа сонгох, солих эрхтэй. Энэ эрхээ хэрэгжүүлэхдээ нийгмийн хэв журмыг зөрчихгүй байх ёстой. Иргэдийн гадаадад зорчих, иргэний харьяалаасаа татгалзах эрх зөрчигдөх ёсгүй.

АНУ-ын Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлд:

Эдүгээгийн муж улсуудын аль нэг нь шаардлагатай гэж үзсэн хувь хүмүүсийн шилжин нүүх, оруулахыг 1808 он хүртэл Конгресс хориглохгүй бөгөөд ийнхүү оруулахад хүн бүрт 10 доллараас хэтрэхгүй татвар буюу хураамж ногдуулж болно.

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлд:

Бүх Германчууд холбооны нийт нутагт чөлөөтэй зорчих эрхтэй. Энэхүү эрхийг гагцхүү хууль болон хуулийн заалтыг үндэслэн хязгаарлаж болох бөгөөд хувь хүнд амьдрах хангалттай нөхцөл байхгүйн улмаас эдгээр хүмүүсийн шилжилт хөдөлгөөн нийтэд үлэмж дарамт учруулж болзошгүй, эсхүл Холбооны буюу муж улсын оршин тогтнол, чөлөөт ардчилсан үндсэн журам учирч болзошгүй аюул заналаас сэргийлэх, тахал, байгалийн гамшиг буюу онц ноцтой осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мөн залуучуудыг тэнэмэл болгохоос хамгаалах тохиолдолд энэхүү эрхийг хязгаарлаж болно. Мөн хуулийн 11 дүгээр хэсэг /Шилжилтийн болон эцсийн заалтууд/ 117 дугаар зүйлд:

Орон байрны өнөөгийн гачаалыг харгалзан иргэдийн чөлөөтэй зорчих болон оршин суух газраа сонгох эрхийг хязгаарласан хууль тогтоомж холбооны хуулиар тэдгээрийн хүчингүй болтол мөрдөгдсөн хэвээр байна гэж тус тус гадаад орнуудын үндэсний хууль тогтоомжид заажээ.⁵

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 18 дахь хэсэгт:

Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга **оршин суух газраа сонгох**, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, **оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах**, нийгмийн хэв журмыг **хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.**" гэж заасан.

Энэхүү эрхийг "оршин байх" цаг хугацаагаар нь:

- **Байнгын оршин суух /бүрмөсөн/** Иргэн байнга оршин сууж байсан засаг захиргааны нэг нэгжээс нөгөөд 180 хоногоос дээш хугацаагаар оршин суухыг бүрмөсөн шилжин суурьших гэнэ.
- **Түр оршин суух** Иргэн байнга оршин буй газраасаа нөгөөд 31-180 хоногийн хугацаанд шилжин суухыг хэлнэ.

⁵ Конституционное право зарубежных стран 1998г

ХОЁР. ӨНӨӨГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын иргэн байнга оршин суухаар Нийслэл Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжих, хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод шилжих эсвэл нэг аймгаас нөгөө аймагт, нэг дүүрэг, сумаас өөр дүүрэг, суманд шилжихдээ доорх материалыг бүрдүүлснээр ямар нэгэн “саад, бэрхшээлгүй” оршин суух газраа сонгох боломжийг олгосон эрх зүйн орчин бүрдсэн билээ.

1992 оны Үндсэн хууль батлагдан гарснаас хойш хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбогдон дараах эрх зүйн актуудыг батлан гаргажээ. Үүнд:

Нийслэл хотод орон нутгаас шилжин ирэх асуудлыг Засгийн газрын 2002 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 214 дүгээр тогтоол, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 1995 оны 69 дугаар тогтоол, 2000 оны 46 дугаар тогтоол, 2001 оны 8 дугаар тогтоолын дагуу тус тус зохицуулан шийдвэрлэж байна.

Энэ эрхийг засаг захиргаа нутаг дэвсгэрт хэрэгжих байдлаар нь 3 ангилан авч үзэж болох юм.

Нэгдүгээрт. Аймаг, орон нутгаас нийслэлд шилжин ирэх:

Аймгаас Нийслэлд шилжин суурьших хүсэлтийг тухайн аймгийн Засаг даргын тамгын газарт тавьж тухайн иргэнийг Нийслэлд бүрмөсөн шилжин суурьшихыг зөвшөөрсөн тохиолдолд аймгийн засаг даргын тамгын газар тухайн иргэнийг бүртгэлээс хасаж /ХААТР-24/ маягтыг олгоно.

Энэ ХААТР-24 маягтыг авсны дараа оршин сууж буй хорооны өрхийн дэвтрээс давхар хасалт хийлгэнэ. Иргэний шилжин суурьших тухай хүсэлт өргөдөлд ам бүл хэд, хэн хэн хаана шилжиж байгаа, ямар ажил эрхлэх тухайгаа тодорхой бичсэн байна.

Нийслэл хотод оршин суух хүсэлт гаргасан иргэн Нийслэлийн Засаг даргын тамгын газарт шилжилт хөдөлгөөнтэй холбоотой иргэдийг хүлээж авах байранд дараах бичиг баримтыг бүрдүүлж өгнө. Үүнд:

1. Өргөдөл;
2. Иргэний үнэмлэх буюу паспорт. 16 нас хүрээгүй бол төрсний гэрчилгээ;
3. Хөдөө орон нутгийн хүн амын бүртгэлээс хасалт хийлгэсэн /ХААТР-24/ тухай тодорхойлолт;
4. Гэр бүлийн баталгаа, хүүхдийн төрсний гэрчилгээ.

2004 оноос өмнө үүнээс гадна төлбөр төлсөн тухай баримт шаарддаг байсан.

Хөдөө аймгаас нийслэл Улаанбаатар хотод шилжин ирэгсдээс Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1995 оны 69 тоот тогтоолоор /2000 оны 46, 2001 оны 08 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан/ баталсан журмын ёсоор хөдөөнөөс Улаанбаатар хотод суурьшихаар шилжин ирсэн насанд хүрэгчдээс “үйлчилгээний хөлс” нэрээр 50000 төгрөг, 18 хүртэлх насны хүүхдээс 25000 төгрөгийн хураамж авч байсан. Гэхдээ Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2001 оны 8 дугаар тогтоолоор Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1995 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэл хотод шилжин суурьших, түр оршин суух, нийслэлээс шилжин явах түр журам”-ын дагуу:

1. Нийслэлд байнга байрлаж ажил үйлчилгээ явуулдаг төр, захиргааны байгууллагад Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон УИХ-ын Тамгын газар, Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар, яамдын төрийн нарийн бичгийн дарга, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын даргын шийдвэрээр ажиллахаар томилогдсон, эсхүл сонгуулиар төрийн байгууллагад ажиллах болсон.

2. Амьдарч байсан орон нутагт нь асран хамгаалах, харгалзан дэмжих хүнгүй 18 хүртэлх насны иргэнийг нийслэл хотод байнга оршин суудаг, хууль ёсны асран хамгаалах, харгалзан дэмжих хүний асрамж, хамгаалалтад байлгахгаар шийдвэрлэсэн тухай Засаг даргын захирамж буюу шүүхийн шийдвэр гарсан.

3. Тухайн иргэн улсын үйлчилгээний төрөлжсөн эмнэлэг /Клиникийн 1, 2, 3 дугаар эмнэлэг, Хавдар судлалын төв, Халдвартын клиникийн эмнэлэг, Гэмтэл согог, сэргээн засах клиник, Эх нялхсын эрдэм шинжилгээний төв, Сэтгэцийн эмгэгийн клиник эмнэлэг, Сүрьеэний үндэсний төв/-ийн байнгын хяналтад байх шаардлагатай нь холбогдох эмнэлгийн эмч нарын зөвлөгөөний шийдвэрээр тогтоогдсон.

4. Эхнэр, нөхрийн хэн нэг нь нийслэл хотын үндсэн оршин суугч буюу 1995 оноос өмнө шилжин ирсэн иргэд болон 1, 3, 4 дүгээр заалтад заасан шалтгаанаар шилжин ирэгсдийн эхнэр, нөхөр, 18 хүртэлх насны хүүхдийг тус бүр нэг удаагийн үйлчилгээний хөлснөөс чөлөөлж байсан.

Тухайн иргэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2001 оны 08 дугаар тогтоолд заасны дагуу нэг удаагийн төлбөрөөс чөлөөлөгдөх бол түүнийг нотлох хүчин төгөлдөр бичиг баримттай байх ёстой байсан. Хүний Эрхийн Үндэсний Комиссоос хураамж авч байгаа нь иргэдийн оршин суух газраа сонгох эрхийг зөрчиж байна гэсэн үндэслэлээр шүүхэд нэхэмжлэл гаргасны дагуу төлбөр төлөхтэй холбоотой журмыг шүүхээс хүчингүй болгосон. Дээрх шийдвэр гарснаас хойш орон нутгаас Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн бүртгэлийг шуурхай болгох, иргэдийг чирэгдүүлэхгүй байх үүднээс хөдөө

орон нутгаас шилжин ирж буй хүмүүсийн шилжилт хөдөлгөөний бүртгэл хийх ажлыг дүүргүүдтэй хамтран зохион байгуулахаар шийдвэрлэж, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Иргэдийг хүлээн авах байранд Говь-Алтай, Завхан, Төв аймгаас шилжин ирэгсдийг, дүүргүүдийн Засаг даргын тамгын газрын иргэдийг хүлээн авах байранд дээрх гурван аймгаас бусад аймгаас болон өөр дүүргээс шилжин тухайн дүүрэгт байнга оршин суухаар ирсэн иргэдийг тус тус бүртгэж байна.

Одоо энэхүү нутаг дэвсгэрт иргэд шилжин суурьших хөдөлгөөнийг Засгийн газрын 2002 оны 214 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2004 оны 20 дугаар тогтоолоор “Иргэдийн шилжих хөдөлгөөнийг бүртгэх журам” зэргээр зохицуулж байна.

Харин иргэний үнэмлэхгүй иргэн тухайн оршин суух дүүргийнхээ иргэний гэр бүлийн бүртгэлийн байцаагчаас дахин олголтын өргөдөл анкетыг авч, оршин суух хорооны засаг даргаар бөглүүлж, иргэний үнэмлэх бүртгэлийн байцаагчдаа тэмдэглүүлнэ.

Нийслэлийн Засаг даргын тамгын газар тухайн иргэний өргөдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор Улаанбаатар хотын иргэн болгох эсэх асуудлыг шийдвэрлэж ХААТР-23 маягтыг бичиж олгоно.

ХААТР-23 маягтыг иргэн оршин суух хороондоо бүртгүүлсний дараа Нийслэлийн Иргэний бүртгэл мэдээллийн албанд нэг хувь зураг, төрсний гэрчилгээ, хамт шилжин ирсэн хүүхдийн гэрчилгээ гэх мэт бичиг баримтыг бүрдүүлэн бүртгэл хийлгэнэ. Хэрэв гэрчилгээгүй бол Иргэний бүртгэл мэдээллийн улсын төв архиваас гэрчилгээний магадалгааг авсан байх ёстой. Шилжиж ирсэн иргэн Нийслэлийн Иргэний бүртгэл мэдээллийн албанд дараах хураамжийг төлнө. Үүнд:

Иргэний үнэмлэхтэй бол 1200 төгрөг /шилжилт хөдөлгөөн 700, хаягийн хөдөлгөөн 500 төгрөг/ хурааж шилжилт хөдөлгөөний бүртгэлийг аймаг тус бүрээр бүртгэлд оруулна.

Хоёрдугаарт. Нийслэлээс аймагт шилжих

Нийслэлээс аймагт шилжин суурьших хүсэлтийг оршин суух дүүргийнхээ Засаг даргын тамгын газарт гаргана. Нийслэлээс аймагт шилжин суурьших иргэдэд дүүргийн Засаг даргын тамгын газар нь ХААТР-24 маягтыг дагалдах бичгийн хамт бичиж олгоно.

Уг бичгийг оршин суугаа хороодын өрхийн бүртгэлээс хассаны дараагаар Нийслэлийн Иргэний бүртгэл мэдээллийн албанд хандана.

Нийслэлээс аймагт шилжин суурьших иргэд иргэний үнэмлэх, ХААТР-24 маягтын хамт Иргэний бүртгэл мэдээллийн албанд бүртгүүлж хасалт

хийлгүүлж шилжинэ. Хөдөө орон нутагт шилжин суурьшихад 700 төгрөгийн хураамж төлнө.

Гуравдугаарт. Аймгаас аймагт, дүүргээс дүүрэгт шилжих

Нийслэл хотод нэг дүүргээс нөгөө дүүрэгт шилжин суурьших тухай хүсэлтээ оршин сууж буй хорооны Засаг даргад гаргана. Засаг дарга нь хүсэлтийг хүлээн авч аймаг, хот дотор бүрмөсөн шилжсэний тодорхойлолт, ХААТР-22 маягтыг бөглөн хороодын өрхийн бүртгэлээс хасалт хийнэ. Үүний дараагаар ХААТР-22 маягтын ар талыг шинээр оршин суух хорооны Засаг даргад бөглүүлж өрхийн дэвтэрт бүртгүүлнэ.

Улмаар суурьших дүүргийн иргэний гэр бүлийн бүртгэлийн байцаагчаар иргэний үнэмлэхэндээ хаягийн тэмдэглэл хийлгүүлнэ. Хаягийн тэмдэглэл хийлгэхэд 500 төгрөгийн хураамж төлдөг.

ДҮГНЭН ҮЗВЭЛ

Сүүлийн жилүүдэд нийслэл хотын хүн амын хэт бөөгнөрөл “төвлөрөл” нь эргээд хотын оршин суугчдадаа сөргөөр нөлөөлж цэвэр ус, цахилгаан дулааны хангамж хүрэлцэхгүй, дунд сургуулийн ачаалал хэт нэмэгдэж, гурван ээлжээр хичээллэж, нэг ангид дунджаар 50 гаруй сурагчтай болсон нь байвал зохих хэмжээнээс ихээхэн дээгүүр байгаа бөгөөд нийтийн үйлчилгээ, тээвэр, холбоо, ажил эрхлэлт гэх мэт үйлчилгээний бусад салбаруудад хүндрэл учруулж, хотын агаар жилээс жилд бохирдож байгаагийн зэрэгцээ хотын эдэлбэр газрын даацыг алдагдуулж байгалийн тэнцэл алдагдахад хүрээд байгаа тул шилжин суурьших асуудлыг нэг мөр цэгцлэх шаардлага тулгараад байна.

Сүүлд хийсэн судалгаагаар хүн өдөрт 16 кг хүчилтөрөгчөөр амьсгалдаг бол хотын иргэд энэ 16 кг-ийн үүний 3 кг нь утаа, нүүрстөрөгч байна гэсэн судалгаа гарчээ.⁶

Иймээс нэг эрхийг хангах гээд нөгөө бусад эрхийг нь зөрчих бус энэ харилцааг зохицуулах нэлээд боловсронгуй, нарийвчилсан “тусгайлсан” зохицуулалт нэн шаардлагатай байна.

Улсынхаа нутаг дэвсгэрт оршин суух газраа сонгох эрхийг хангах асуудлыг дан ганц гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага /захиргааны байгууллага/-ын хүрээнд шийдээд өнгөрөх бус үндэсний язгуур эрх ашигт⁷ хамаарсан эрх зүйн онол, практикийн ач холбогдол бүхий тулгамдсан асуудал гэдгийг сүүлийн жилүүдэд хийсэн судалгааны дүн харуулж байна.

⁶ MM today мэдээллийн хөтөлбөр. 2005 оны 1 дүгээр сар.

⁷ Үндэсний язгуур эрх ашиг гэдэг нь нийгмийн тогтвортой, аюулгүй байдал, үндэстэн, ард түмний эв нэгдэл, төр улсын тусгаар тогтнолыг хангахтай холбогдсон улс орны амин чухал асуудлууд юм.

Иймээс дээр өгүүлсэн /Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 18-д дурдсан⁸ хуулиа батлан гаргах цаг нь болжээ. Энэ хуулийг зөвхөн батлан гаргаад зогсохгүй амьдралд хэрэгждэг идэвхтэй “амьд” хууль болгохын тулд тал бүрээс нь бодолцон бүтээх шаардлага нэгэнт үүсжээ. Чухам юуны учир вэ? гэвэл энэхүү эрх зөвхөн оршин суух газраа сонгох эрхийн хүрээний бус хойно хойноосоо хүмүүсийн эдлэх бусад салшгүй эрхүүдийг дагуулж “хангаж, зөрчиж” байдагт оршино.

Оршин суух газраа сонгох эрх нь хувийн эрх, эрх чөлөөний салшгүй нэг хэсэг бөгөөд хүн бүр аятай таатай эрүүл аюулгүй орчинд амьдрах, соёл боловсролоо дээшлүүлэх, эрүүл мэнд, мэргэжил, авьяас чадавх, эдийн засгийн харилцаанд оролцох “хангагдах” болон хүний өөрийнх нь хөгжхүйд ач холбогдолтойгоороо бусад эрхээс ялгарах онцлогтой.

Оршин суух газраа сонгох эрхийн үүднээс хүн ам төвлөрсөн хот газар шилжин суурьших явц эрчимтэй өрнөж байгаа өнөө үед иргэдийн чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох эрхийг хангахад өнөөгийн нийгэмд зайлшгүй хэрэгцээтэй эрх зүйн зохицуулалт хууль тогтоомж шаардлагатай байгааг дахин илэрхийлж байна. Монгол Улс Хүний эрхийн түгээмэл тунхаглал, иргэний болон улс төрийн эрхийн тухай, эдийн засаг, нийгэм, соёлын тухай, олон улсын пакт зэрэг хүний эрхийн талаарх НҮБ-ын болон түүний төрөлжсөн байгууллагуудын гэрээнд хүлээсэн үүргийнхээ дагуу, хүн ам төвлөрсөн хот, суурин газарт шилжин суурьших явц эрчимтэй өрнөж байгаа өнөө үед иргэдийн чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох эрхийг хангахын зэрэгцээ баталгаажуулах шаардлага зайлшгүй бий болж байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн хоёрт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, гуравт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэсэн зарчмын заалтаар тусгалаа олжээ.

Өнөөдөр иргэд маань үр хүүхдийнхээ сурч боловсрох эрхийг хангах, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, боломжийн цалин хөлс авах, эрүүл мэндээ өндөр мэргэшил бүхий эмч, эмнэлгийн байгууллагаар хамгаалуулах, тэдний тусламжийг авах, соёл, шинжлэх ухааны үр шимийг хүртэх эрхээ эдлэх зорилго тэмүүллийн дор нийслэл хот руу, бүр цаашилбал гадаад улс руу хошуурч байгаа нь хэнд ч ойлгомжтой. Энэ нь хөдөө орон нутагт энэ бүх эрхээ баталгаатай эдлэх боломж нөхцөл боломж хэдийнэ бүрдсэнтэй холбоотой.

⁸ МУ-ын ҮХ-ийн 16 дугаар зүйлийн 18-д “Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.” хэмээн заасан байна.

Ийм учраас аймаг, сумаас Улаанбаатар хот, төвийн бүс рүү шилжин суурьших явдлыг хязгаарлах, алс хязгаар нутаг эзэнгүйдэх явдлаас сэрэмжлэх зорилгоор Монгол Улсын төрөөс боловсруулсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын дагуу “бүсчлэн хөгжүүлэх” бүсүүдийн төвүүд болон дагуул хотуудыг эрчимтэй хөгжүүлж төвийн бүс рүү чиглэсэн шилжих хөдөлгөөн их нүүдлийг хязгаарлах шаардлагатай. Тухайлбал, төрийн зүгээс бодлого зохицуулалттайгаар нийгэм эдийн засгийн хөшүүргийг бий болгох (барааны үнийн түвшинг хөдөө аймагт хотоос хямд байлгах /амьжиргааны баталгаажих түвшинд дүйцсэн үнийн зохистой бодлогыг барих/) иргэдийн дунд төвөөс зугтах хүчийг сааруулах үүднээс хот дахь хөгжлийн төвлөрлийг тараах, тархаан байрлуулах шаардлагатай.

Аймгийн төвд буюу бүсчилсэн хөгжлийн тулгуур төвүүдэд их дээд сургуулиудын салбарыг байгуулж, оюутны нийслэлд ирж суралцдаг их төвлөрлийг сааруулсан тохиолдолд механик шилжилт хөдөлгөөн багасаж, хотын төвөөс зайдуу оюутны хотхон байгуулах /Английн Кембриж/ Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу иргэн хүн оршин суух газраа өөрөө чөлөөтэй сонгох эрхтэй гэсэн заалт жинхэнэ утгаараа амьдралд хэрэгжих хууль эрх зүйн болон эдийн засаг, нийгмийн орчин бүрдэх болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д:

“Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж төрийн байгууллагуудын үндсэн үүрэг болгон оногуулжээ.

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөний нэг болсон “Монгол Улсын иргэн Оршин суух газраа чөлөөтэй сонгох” эрх нь хууль эрх зүйн хувьд баталгаатай гэх боловч тодорхой эрх зүйн актуудаар хязгаарлагдмал хэрэгжиж байсан байна. Гэвч энэ байдал хэдийн ард хоцорч бидний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх маань дээрх нөхцөлийн улмаас зөрчигдсөөр байгааг анхаарах цаг болжээ.

ХУРДАН МОРИНЫ УРАЛДААНЫ ЯВЦ ДАХЬ ХҮҮХДИЙН ЭРХИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, АНХААРАХ АСУУДАЛ*

Ж.Дашдорж
ХЭҮК-ын гишүүн

Монголын ард түмэн эрт дээр үеэс эхлэн баяр цэнгэл наадмыг хийхдээ хурдан морь уралдуулан баярлаж цэнгэдэг сайхан уламжлалтай. Энэхүү өв уламжлал нь Монголын зан заншил, өв уламжлалын өвөрмөц нэгэн хэлбэр мөн бөгөөд түүнийг цаашид улам боловсронгуй болгох, хөгжүүлэх нь манай ард түмний санаа тавих нэг чухал сэдэв болсоор байна.

Хурдан морины уралдааны зорилго, хамрах хүрээ, тоо хэмжээ, ихээхэн өөрчлөгдөж бизнесийн шинжтэй бооцоот тоглоомын өнгө аястай болж байгаа нь ажиглагдаж байна. Хурдан морины уралдаан нь өвөл зунгүй хот хөдөөгүй зохион байгуулагдаж, нэг нас нэг уралдаанд явж буй морьдын тоо хэдэн зуугаар тоологдож байна. Уламжлалт морин уралдааны энэхүү хэлбэрт төр засгийн зүгээс тодорхой зохицуулалтыг бий болгохыг амьдрал зүй ёсоор шаардсаар байна.

Ялангуяа хурдан морь унаж буй хүүхдийн эрх, түүний аюулгүй байдлын тухай асуудал онцгой зохицуулалт шаардсан эмзэг асуудал боллоо. Насанд хүрээгүй бүү хэл бага насны /14 хүртэлх/ хүүхдээ аргамаг хурдан хүлгийн нуруун дээр ямар ч хамгаалалтгүй шахам суулгаад хэдэн зуугаар нь уралдуулж нааддаг үндэстэн манайхаас өөр хаана ч байхгүй гэхэд хилсдэхгүй. Бага балчир, гэнэн томоогүй үр хүүхдээрээ хурдан морь унуулж, тэднийгээ харж өхөөрдөн, баярлаж цэнгэх нь үндэсний зан заншил, уламжлал, бахархал мэт санагдавч, хүүхдийн эрх, тэдний аюулгүй байдал, эрүүл саруул хөгжих, төрийн хамгаалалтад байх үүднээс авч үзвэл тийм ч бахархаад магтаад байх зүйл биш гэж хэлэхэд буруудахгүй. Хаана ч хэзээ ч зохион байгуулагдаж буй ямар ч уралдаанд бяцхан хүүхдүүд мориноосоо унахгүй, бэртэж гэмтэхгүй, амь насаа алдахгүй гэх баталгаа байхгүй.

Тиймээс наадамчин олон аливаа наадам цэнгэлийн дараа морь хүүхдийн эндэгдэлгүй, элдэв бүлхайгүй сайхан наадам боллоо хэмээн ярих нь элбэг байдаг. Энэ нь уяачид, наадамчид, ард түмэн морин

* Биеийн Тамир, Спортын Улсын Хороо, Хүүхдийн Төлөө Үндэсний Газар, Хүний Эрхийн Үндэсний Комиссоос 2006 оны 5 дугаар сарын 2-4 нд зохион байгуулсан “Хурдан морь унаач хүүхдийн эрхийг хамгаалах улсын нэгдсэн Чуулган”-д тавигдсан илтгэл,

уралдаан нь ямар эрсдэл дагуулж болохыг ухамсарлаж, сэтгэл нь зовниж байдгийн нэг илэрхийлэл мөн.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1999 оны 182-р конвенциор хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг тодорхойлж өгсөн ба ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажлыг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй элбэр гэж тодорхойлсон. Хэрвээ хүүхэд хурдан морь унах асуудлыг хүүхдийн хөдөлмөр гэж үзвэл энэ нь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт хамаарахаас өөр аргагүй.

Хурдан морины уралдааныг үндэсний уламжлалт спортынх нь хувьд зөв хөгжүүлэх, морин уралдааны явцад хүүхдийн эрүүл мэнд, амь насыг найдвартай хамгаалах, эрх зүйн зохицуулалтыг улам бүр боловсронгуй болгох нь шийдвэр гаргагчид, уяачид, тэдний сайн дурын байгууллагууд, хүний эрхийн байгууллагууд, нийт ард түмний санаа тавих асуудал мөн.

Хурдан морины уралдааны тухай асуудлыг эрх зүйн хүрээнд шийдвэрлэх, зохицуулах гэсэн зарим нэгэн алхмууд хийгдсэн нь сайшаалтай ч энэ нь амьдрал дээр хир нийцтэй, хэр оновчтой механизм болж байгаад дүгнэлт хийх шаардлагатай байна.

2003 оны 6-р сарын 19-нд Монгол улсын Их Хурлаас Үндэсний их баяр наадмын тухай хуулийг батлан гаргаж, энэ хуулиар баяр наадмын хурдан морьдыг 7-гоос дээш насны хүүхэд унах ба тэр нь ослын даатгалд даатгуулсан байна хэмээн тогтоож, хурдан морины уралдааны дүрмийг Засгийн газар батлахаар тогтоосон нь зарчмын ач холбогдолтой болсныг үгүйсгэхгүй. Энэ хууль гарснаар хэт бага насны хүүхдээр морь унуулахыг хуулиар хориглож, даатгалын асуудлыг хуульчилсан нь ач холбогдолтой болсон. Гэхдээ энэхүү хууль, дүрэм нь зөвхөн үндэсний их баяр наадам, Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулагдах хурдан морины уралдаан зохион байгуулахад мөрдөгдөхөөр байгаа нь улс даяар зохион байгуулагдаж байгаа бүх хэлбэрийн морин уралдаанд хамааруулж хариуцлага тооцох боломжгүй юм. Улсын баяр наадам, Засгийн шийдвэрээр зохион байгуулагдаж байгаа уралдаанаас гадна жил бүр олон зуун морин уралдаан зохион байгуулагдаж, түүний нилээд хүйтний улиралд хийгдэж байна. Хурдан морины уралдааны явцад хүүхдийн амь нас, эрүүл мэндэд хир их хохирол учирдаг, хир олон хүүхэд гэмтэж, бэртдэг, амь насаа алддаг болон түүний шалтгаан нөхцөлийн талаар улсын хэмжээнд тооцоо судалгаа хийсэн, баримт цуглуулсан тохиолдол бараг байхгүй шахам байна.

Энэхүү чуулганы бэлтгэл ажлын явцад ХЭҮК, ХТҮГ-аас АЙПЕК хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хурдан морины хүүхдийн эрхийн байдал тойм судалгаа хийж, зарим тоо баримт, цуглуулж дүгнэлт хийсэн болно. Энэхүү судалгаанаас харахад хурдан морины уралдааны явц дахь

хүүхдийн амь нас, эрүүл мэндийн асуудал хамгийн чухал гэдэг нь харагдсан бөгөөд аливаа морин уралдааны явцад гарсан осол, гэмтэл, зөрчлийн талаар хэн ч ямар ч байгууллага, албан тушаалтан мэдээлэл цуглуулж, тайлан мэдээ гаргадаггүй, тул энэ чиглэлээр баримт материал ховорхон үлддэг байна. Иймээс судалгаа дүгнэлт хийхэд ихээхэн бэрхшээлтэй байна. Судалгааны зарим тоо баримтаас үзэхэд морин уралдааны явцад хүүхдийн амь нас, эрүүл мэнд багагүй хохирдог болох нь харагдаж байна.

Хурдан морины уралдааны явцад хүүхэд мориноосоо унах явдал олон гардагч унасан болгон бэртэл аваад байдаггүй байна. Тухайлбал Төв аймагт гэхэд 2005 онд зохион байгуулагдсан морин уралдааны явцад 150 орчим хүүхэд мориноосоо унасан, тэднээс 15 хүүхэд бие эрхтэндээ гэмтэл авсан тухай Хүүхдийн төлөө төвийн тайланд тусгагдсан байна гэсэн судалгаа гарсан байна.

Гэсэн хэдий ч сүүлийн 8 жилийн дотор улсын хэмжээнд 11 аймагт зохион байгуулагдсан төрөл бүрийн морин уралдааны явцад 17 хүүхэд мориноосоо унаж амь насаа алдсан тохиолдол бүртгэгдсэн байна. Үүний 15 тохиолдол нь 2003-2006 онд сүүлийн 3 жилд гарсан байна. Энэ тоо нь тойм судалгаа бөгөөд бүх тохиолдлыг 100 хувь илрүүлсэн гэж үзэхгүй байна. Гэсэн хэдий ч энхийн цагт, баяр цэнгээний явцад ийм тооны гэм зэмгүй хүүхэд амь насаараа хохирсныг юугаар ч зөвтгөж хаацайлж болохгүй. Амь насаараа хохирсон хүүхдүүд 5-13 насны хүүхдүүд байсан бөгөөд янз бүрийн шалтгаантай болох нь харагдаж байна. Хамгийн ноцтой нь 2005 оны 2-р сард Сүхбаатар аймгийн Сүхбаатар суманд цасан шуургатай өдөр морин уралдаан зохион байгуулж, морь нь хадуурч, хүүхэд морьтойгоо төөрсний улмаас 13 настай эрэгтэй хүүхэд хөлдөж нас барсан бөгөөд түүнийг маргааш нь олж байсан байна. Судалгааны явцаас ажиглахад морин уралдааны явцад хүүхдийн амь нас хохирсон тохиолдлыг эрүүгийн хэрэг үүсгэн шалган нягталсан, гэм буруутай этгээдэд хариуцлага тооцсон тохиолдол огт байхгүй байна.

Энэхүү судалгааны явцад сүүлийн 3 жилд /2004-2006/ онуудад 206 хүүхэд мориноосоо унаж гэмтэл бэртэл авсан байна. Тэдний 39.8 хувь нь хөнгөн, 31.0 хувь нь хүндэвтэр, 20.8 хувь нь хүнд гэмтэл авсан байна. Хурдан мориноос унасан хүүхдүүд нь ихэвчлэн гар, хөл, тархи толгой, эгэмдээ гэмтэл бэртэл авдаг байна. Хүүхдэд учирсан гэмтэл бэртлийн 40.3 хувь нь гар, эгэм, мөрөндөө, 29.8 хувь нь тархи толгойдоо, 24.1 хувь нь хөл тулгуур эрхтэндээ гэмтэл авсан байна. Гар хөлөө хугалах гэмтэл ихээхэн гардаг байна. Тухайлбал Өвөрхангай аймагт 2004 онд зохион байгуулагдсан уралдаанд 12 настай эмэгтэй хүүхэд мориноосоо унаж, түнх, булууны яс нь хугарч, хөлгүй болж, байнгын тахир дутуу болсон байна. Төв аймагт 2005 оны их насны морины уралдаанд 8 настай хүүхэд мориноосоо унаж, тархи нуруундаа гэмтэл авч суумгай болсон,

мөн дааганы уралдаанд 10 настай эрэгтэй хүүхэд мориноосоо унаж, тархиндаа мэс засал хийлгэж явж чадахгүй болсон байна. Энэ мэтээр хүндээр бэртэж гэмтсэн тохиолдол бага бус гардаг ч иймэрхүү осол гэмтлийг тэр бүр мэдээлэх, шалгуулах сонирхол тун бага байдаг төдийгүй харин ч нуух сонирхол байдаг тухай судлаачид тэмдэглэсэн байна.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд өвөл цагт, хүйтэн сэрүүн нөхцөлд морь уралдах болсноос хүүхэд уралдааны явцад бие эрхтнээ хөлдөөх явдал гарах болсон байна. 2006оны 2-р сард Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд их нас, соёолон уралдуулсан ба энэ уралдааны явцад 2-р ангийн хүүхэд хөлөө хөлдөөж одоо удаан зогсож чадахаа болсон хөлдөц нь арилаагүй байна. Уяачдын холбооноос зохион байгуулсан 2006 оны шинийн 8-ны уралдааны үеэр 30 орчим хэмийн хүйтэнтэй байсан ба олон хүүхэд хөл, гар, хацраа хөлдөөсөн тухай мэдээлэл байна. Хурдан морины уралдааны үед эмнэлгийн түргэн тусламжийн машин явдаг хэдий ч уралдааны явцад гарсан осол гэмтлийг нарийвчлан бүртгэж баталгаажуулдаггүй, холбогдох газарт нь мэдээлдэггүй байна.

Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааны уралдааны дүрмээр хурдан морины хүүхэд нь хамгаалалтын малгай, цээживч, өвдөг тохойн хамгаалалт, тусгай эмээлтэй байна гэж заасан боловч хамгаалалтын хувцас хэрэглэж хэвших явдал маш хангалтгүй байгаа нь судалгааны явцад харагдсан байна. Ялангуяа энэ асуудал хөдөө орон нутагт ор нэрийн төдий байна. Хамгаалалтын хувцас хэмээн эдгээр зүйлүүдийг дүрэмд нэрлэсэн ч эдгээр хувцас нь ямар загвар стандарт, хэмжээтэй байх нь тодорхой биш байгаа учраас ямар зүйлийг хамгаалалтын хувцас гэж үзэх нь ч хүндрэлтэй байна. Иймд хамгаалалтын хувцасны талаар судалгаа явуулж, ямар төрлийн, ямар үзүүлэлттэй хамгаалалтын хувцас хэрэглэхийг ч нарийвчлан тогтоох хэрэгтэй. Сүүлийн жилүүдэд дотоодын үйлдвэрлэгчид өөрсдөө санаачилга гаргаж, эмээл, дөрөө, малгай зэрэг зүйлийг хийж, гаднаас зарим хэрэглэлийг оруулж ирж байгаа боловч үнийн хувьд харьцангуй өндөр байна. Иймд хамгаалалтын хувцас үйлдвэрлэх, нийлүүлэх асуудлыг төрөөс дэмжих хөгжүүлэх асуудал шаардлагатай байна.

Хурдан морины хүүхдийг гэнэтийн ослын даатгалд даатгуулсан байхаар хуульд тусгайлан заасан ч хэрэгжилт нь төдийлөн сайн биш байна. Хурдан морины уралдаанд орох морьдыг бүртгэхдээ даатгалын баталгаа байхгүй тохиолдолд уг морийг бүртгэхээс татгалзах ёстой ч ингэж чаддаггүй байна. Хурдан морины хүүхдийг ихэвчлэн ихэвчлэн 500 мянган төгрөгөөр үнэлж, даатгалын хураамжид 3500 төгрөг төлдөг байна. Даатгалд хамрагдсан хүүхдүүдээс мориноосоо унаж бэртэж гэмтэл авсан хүүхдүүд ихэвчлэн 10-50, 60 мянган төгрөгийн нөхөн төлбөр авсан байна. Цөөн тохиолдолд 100 мянга орчим төгрөг авсан байна. Зарим орон нутагт хийгдсэн судалгааны явцад даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг олон

компани ажиллаж даатгалын гэрээ байгуулдаг хэдий ч эргээд нөхөн төлбөр авах болоход тэр даатгалын газар нь хаана байгаа нь мэдэгддэггүй, олддоггүй гэсэн шүүмжлэл гарч байсан байна. Даатгуулагч осол гэмтэлд орж нөхөн төлбөр авдаг хэдий ч тэр нь эрүүл мэндээ нөхөн сэргээхэд хүрэлцдэггүй байна.

Хурдан морины уралдаанд бэлтгэх, оролцоход хүүхэд ихээхэн цаг, хүч хөдөлмөр зарцуулдаг хэдий ч тэдний хөдөлмөрийг шударгаар үнэлэх, урамшуулах асуудал анхаарал татсан асуудал хэвээр байна. Сүүлийн жилүүдэд зарим алдартай уяачид хүний өөрийн олон тооны морь уяж, өвөл зунгүй отог, гал хэлбэрээр ажиллаж, ихэвчлэн амьжиргаа муутай айл өрхийн хүүхдийг цуглуулж, гол зогоох төдий хоол өгч, элдэв ажил төрөлдөө зарж, дорвитой хөлс хөдөлмөр өгдөггүй, хурдан морины уралдааны явцад уралдаан зохион байгуулагчид хүүхдүүдтэй хатуу ширүүн харьцдаг, чулуу модоор цохидог гэсэн мэдээлэл ч гарах болсон байна. Эдгээр гал, отог нь хөндлөнгийн хяналт оролцооноос ч хол хөндий байдаг гэсэн байна. Хурдан морины дүрэмд зааснаар уралдаанд байр эзэлсэн морины байгальны 20 хувийг унасан хүүхдэд олгоно гэсэн ч энэ нь биелдэг эсэх нь тодорхой бус байна. Үүний зэрэгцээгээр уралдаанд бэлтгэж олон хоног хөдөлмөрлөдөг ч барианд ороогүй нөхцөлд хүүхдэд ямар урамшуулал хөлс олгох нь ч тодорхой биш байна. Иймд морин уралдааны явц дахь хүүхдийн эрхтэй холбоотой анхаарал татсан олон асуудал байна.

Үүнтэй холбоотойгоор дараах зүйлүүдэд анхаарлаа хандуулах, шийдвэрлэх шаардлага байна.

1. Монгол улс хурдан морь уралдуулдаг эрт дээр үеийн уламжлалтай төдийгүй морин уралдааныг үндэсний баяр наадмаар төдийгүй олон тохиолдолд янз бүрийн зорилгоор зохион байгуулж байгаад дүгнэлт хийж, морин уралдаан зохион байгуулах журмын тухай нэгдсэн хууль гаргах нь зүйтэй. Энэ хуулиар аливаа морин уралдаан зохион байгуулахдаа тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллагаас зохих зөвшөөрлийг авдаг байх,
2. Хурдан морины уралдаан зохион байгуулж үл болох цаг хугацааны болон байгаль цаг уурын үзэгдлийн үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлох.
3. Хурдан морь унаж болох хүүхдийн нас, бие, эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтийг бий болгох.
4. Морь уралдуулах зам харгүйд тавигдах шаардлага үзүүлэлтийг боловсруулж мөрдөх. Үлийтэй, хадтай, жалгатай, гол горхитой, мөстэй газар морь уралдуулахыг хориглох.
5. Хурдан морины уралдааны явцад зохион байгуулагдах эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээний журам, стандартыг батлан гаргаж,

ийм үйлчилгээг хангаагүй уралдааныг хориглох, уралдааны явцад гарсан осол зөрчлийг судлан бүртгэх хянах тогтолцоо бий болгох.

6. Хурдан морины хүүхдийн бие хамгаалах хэрэгслийн жагсаалт, стандартыг бий болгох, ийм хэрэгслээр хангах, түүнийг үйлдвэрлэх нийлүүлэх ажлыг төрөөс дэмжих.
7. Хурдан морь унаач хүүхдийг ослын даатгалд даатгуулах, нөхөн төлбөр олгох харилцааг боловсронгуй болгох, шаардлагыг өндөржүүлэх, эрүүл мэндийг нь нөхөн сэргээхэд шаардагдах зардлыг гэм буруутай этгээдээр бүрэн нөхөн төлүүлэх тогтолцоог бий болгох.
8. Хурдан морь унаач хүүхдүүдэд ур чадварыг нь дээшлүүлэх, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулдаг болох.

Монгол хүн уламжлалт хурдан морины уралдаанаа харж, баясаж цэнгэхийн гол утга учир нь бидний ирээдүй болсон хүүхэд багачуудаа хайрлан хамгаалж, шат шатандаа анхаарал халамж тавьж, нэг ч хүүхдийг хурдан морины уралдааны золиос болгохгүй байх, аливаа гарч болох эрсдэлээс дээд зэргээр урьдчилан сэргийлэхэд оршино. Хурдан морины уралдаанд хүүхэд оролцуулахыг бүрмөсөн хориглох, хурдан морины уралдааны үндэсний хэв маяг, уламжлалыг устгах гэсэн бодлогыг тус Комисс агуулаагүй болно. Харин энэхүү арга хэмжээний эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох, хүүхдийн амь нас, эрүүл мэнд,, эрх ашгийг сайтар хамгаалахад бид хамтран ажиллах ёстой, бүх нийтийн анхаарлыг хандуулах ёстой гэсэн байр суурийг баримталж байна. Хамтран ажиллаж зохих үр дүн гарна гэдэгт итгэж байна.

ХУРДАН МОРЬ УНААЧ ХҮҮХДИЙН ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНЫ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Хурдан морины уралдаан нь Монголын ард түмний ёс, заншил, соёл иргэншлийг харуулсан дэлхийд хосгүй үндэсний спортын нэг хэлбэр бөгөөд Монгол хүн аргамаг хурдан хүлгээ, авхаалж сэргэлэн багачуудаа харан баясан цэнгэж ирсэн уламжлалтай.

Сүүлийн жилүүдэд морин уралдаан нь аль ч улиралд зохион байгуулагдаж, хэлбэр агуулга нь өргөжин тэлж байна. Үүнтэй уялдан хурдан морины уралдааны явцад хүүхдийн эрхийг хангах тухай асуудал тавигдах болов.

Хурдан морины уралдааныг зохицуулах, хүүхдийн эрхийг хамгаалах зорилгоор зарим арга хэмжээг авч байгаа нь сайшаалтай ч хүүхдийн эрүүл мэнд, амь нас хохирох аливаа илрэлийг арилгах, морин уралдааныг улам боловсронгуй болгох нь нэн чухал асуудал хэвээр байна.

Морин уралдааны явцад хүүхдийн эрх ашиг, аюулгүй байдлыг хангах, тэдний оролцоог нэмэгдүүлэх бодлого боловсруулж, системтэй арга хэмээг авч хэрэгжүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагууд, орон нутгийн төлөөлөл, хурдан морины уралдааны холбоод, уяачдыг хамруулсан “Хурдан морь унаач хүүхдийн Үндэсний чуулган”-ыг зохион байгуулав. Энэхүү чуулганаас хурдан морины уралдааныг үндэсний уламжлалтайгаа зөв хослуулан хөгжүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах үүднээс дараах санал зөвлөмжийг гаргаж байна.

Нэг. Хурдан морь унаач хүүхдийг хамгаалах хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар:

1. Хурдан морины уралдааныг зохицуулж буй хууль, эрх зүйн өнөөгийн нөхцөл байдалд судалгаа хийж, “Хурдан морины уралдааныг зохион байгуулах тухай” хуулийн төсөл шинээр боловсруулах
2. Аливаа морин уралдааныг зохион байгуулахдаа тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллагаас зөвшөөрөл авдаг, тэдний хяналтын дор зохион байгуулдаг журамд шилжүүлэх
3. Хурдан морины уралдааныг зохицуулсан хууль, эрх зүйн актыг чанд мөрдөх, хүүхдийн эрүүл аюулгүй байдлыг хангахад төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ажиллах
4. Хурдан морь унаач хүүхдийн даатгалын тогтолцоог сайжруулах, нөхөн олгох үйлчилгээг боловсронгуй болгоход даатгалын байгууллага, даатгуулагчдын хариуцлагыг нэмэгдүүлэх

Хоёр. Хурдан морь унаач хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах, уралдааны зохион байгуулалтыг сайжруулахад олон нийт, хурдан морины уралдааны холбоодын оролцоог нэмэгдүүлэх талаар:

1. Хурдан морины уралдааныг зохион байгуулахдаа хүүхдийн эрхийг хамгаалах болон хууль, тогтоомжийг хэрэгжилтийг хангах үүднээс хүүхдийн эрхийн ажилтныг тодорхой чиг үүрэгтэйгээр оролцуулдаг байх
2. Хурдан морины уралдааныг зохион байгуулахдаа хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүднээс гараа, уралдааны замын нөхцөл байдалд онцгой анхаарч, урьдчилан шалгаж, аюул осол гарахаас сэргийлэх арга хэмжээг авах
3. Хурдан морь унах хүүхдийн ур чадвар, эрүүл мэндэд онцгой анхаарч, эрсдэл гарч болзошгүй тохиолдолд зөвшөөрөл олгохоос татгалзах, уралдааны өмнө унаач хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулдаг байх, 7 нас хүрээгүй хүүхдийг хурдан морины уралдаанд оролцуулахыг хатуу хориглох
4. Хурдан морины уралдаанд бэлтгэх, зохион байгуулах явцад хүүхдэд хүч хэрэглэх, хатуу ширүүн харьцахыг хориглох, тэднийг шийтгэхгүй байх
5. Хурдан морь унаач хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор уралдааны зам, хүүхдийн хамгаалах хэрэгслийн үндэсний стандартыг боловсруулж мөрдүүлэх, хамгаалах хэрэгсэл үйлдвэрлэх үүсгэл санаачилгыг төрөөс дэмжих
6. “Үндэсний их баяр наадмын тухай” Монгол Улсын хууль заасан болон Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулагдахаас бусад /бооцоот, хүйтний улирлын гэх мэт/ морин уралдаанд хүүхдээр морь унуулахгүй байх

Гурав. Хурдан морь унаач хүүхдийн эрхийн асуудлаар үнэн бодит мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх талаар:

1. Морин уралдаан зохион байгуулж үл болох байгаль, цаг уурын нөхцөл байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зөв тогтоох
2. Хурдан морины уралдааны үед ажиллах хүн, мал эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээний журам, стандартыг боловсруулан гаргаж, уралдааны явцад хүүхэд мориноос унаж бэртэл, гэмтэл авсан тохиолдол бүрийг судлах, бүртгэлийн нэгдсэн загвар гаргаж хөтлөх, мэдээллийн тогтолцоог бий болгох
3. Хурдан морь унаач хүүхдэд болзошгүй аливаа осол гэмтлээс урьдчилан сэргийлж, зохих хамгаалах хэрэгсэл хэрэглэж, аюулгүйн арга барилд суралцуулж байх, уралдааны бэлтгэлийн үеэр техникийн зөвлөлгөө хийдэг болгох

4. Хурдан морь унаач хүүхдийн ур чадварыг дээшлүүлэх, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах талаар сургалт, сурталчилгааг зохион байгуулж, гарын авлага, сургалтын материалыг боловсруулж түгээх

Дөрөв. Хурдан морь унаач хүүхдийн оролцоог хангах талаар:

1. Хүүхдээр морь унуулахдаа албан ёсны асран хамгаалагчаас зөвшөөрөл заавал авч, хүүхдийн өөрийн санаа бодлыг хүндэтгэж, хүчээр морь унуулахаас татгалздаг байх
2. Хүүхдээрээ морь унуулах зөвшөөрөл олгохдоо хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах баталгааг анхаарч, хүүхдийн оролцоог үнэлж урьдчилан тохиролцох, хүүхдийн бодол санааг хүндэтгэх, өөрийн үзэл бодлыг тулган шаардахгүй байх
3. Хурдан морь унаач хүүхдийн үндэсний спортын хөгжилд оруулж буй хувь нэмрийг үнэлэх, цол, хэргэм олгох, шагнах журмыг боловсруулан мөрдүүлэх
4. Хурдан морь унаач хүүхдүүд өөрсдийн эрх ашгийг хамгаалах, үзэл бодлоо илэрхийлэх, оролцоогоо хангах байгууллагатай байх

Энэхүү санал зөвлөмжийг хүндэтгэн үзэж хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээ авна гэдэгт чуулганд оролцогчид итгэж байна.

Чуулганы төлөөлөгчид

Улаанбаатар хот
2006 оны 05 дугаар сарын 04

ХҮНИЙ ОРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИТЕД,
ЗҮҮХДИЙН ТАЛАН ҮНДЭСНИЙ ГАЗАР,
БИНЭНН ТАМЫР СПОРТЫН УГСЫН КОРСО,
ҮНДЭСНИЙ СЛИМПЛИЙН КОРСО,
ҮНДЭСНИЙ ИХ БАЛР НААДМЫН ХУРДАН МОРНИЙ
УРАЛДААНЫГ ЭСХЭНН БАЙГУУЛАХ КОРСО,
МОРНИ СПОРТЫН ҮНДЭСНИЙ ХОЛВООДЫН
ХӨӨРСӨНД БАЙГУУЛСАН ХАМТЫН
АЖИЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ

Утас/факс

№

2006.05.04

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДСЭЛЭЛ

Нагддаар гүйл. Оршил

Өнөөгү өдөрхи бэлтгэ Хурдн морйн Үндэсний комитет (хурал) ХХҮК (тн), Хүүхдийн талан Үндэсний газар (хурал) ХТҮГ (тн), Бинэйн тамыр спортын угсын корсо (хурал) БТСОХ (тн), Монголын үндэсний олимпын хороо (хурал) МНОХ (тн), Үндэсний их бэлр таанамын гүрдэл спортын уралдаанын корсо Байгуулын корсо (хурал) УИ-ОИМУЭНХ (тн) Монголын морин спорт, уулзалт холбоо (хурал) ММОХ (тн), Монголын морин уралдааны холбоо (хурал) ММУХ (тн), Монголын үндэсний морин уралдааны холбоо (хурал) МНМУХ (тн), Морин спортын үндэсний холбоо (хурал) МСХ (тн) нь Хүүхдийн талан комитетийн Тусгай Монгол улсын хурал, Үндэсний их бэлр наадмын тусгай Монгол улсын хурал болон холбоодын хурал тогтоомжтой баримтлан харгалзан хамтран ажлахаар тааралдаан бэлтгэ олонхи бэлтгэ байгуулан.

Хайрдуулар гүйл. Хамтын ажлахааны корсо

ХХҮК, ХТҮГ, БТСОХ, МНОХ, УИ-ОИМУЭНХ, ММОХ, ММУХ, МНМУХ, МСХ нь Хүүхдн морь унаач хүүхдийн гурал манд, мэдлгүй байдал, бэлтгэрал, таанам, спортоор хамтын таанам Хурдан морь унаач хүүхдийн үндэсний чуулганы санал зөвлөмжөөр хамтын ажлахааны корсогүрдэл адилтай хамтран ажлахааны корсог.

ХӨӨРСӨНД ГҮЙЛГ. ХАМТРАН АЖИЛАА ТИГДЭН ЧИГЛӨГҮГЭД

Гүрдэлдуулар гүйл. Талуудын хамтран ажлахааны үндэсний чиглэлүүд

Талууд нь дараах үндэсний чиглэлээр хамтран ажлахааны гүйлг.

1. Хүүхдийн талан комитетийн тусгай Монгол улсын хурал, Үндэсний их бэлр наадмын тусгай Монгол улсын хурал болон таанамтай ажлахааны гуралын хурал, таанамнуудын харгалзгалд амалат таанам, хамтгэрлэл амалат ажлахааны үндэсний гүйлг.
2. Хүүхдн морин уралдааны гүйл гүйлг амалатгэрлэлг болонгэрлэлг болонг.
3. Хүүхдн морь унаач хүүхдийн гурал манд, мэдлгүй байдал амалатгэрлэлг.
4. Хүүхдн морин уралдааны, үндэсний хүүхдийн таанам гуралгэрлэлг хөнгө, мэдлгэрлэлг таанамгэрлэлг бай болонг.
5. Үндэсний хүүхдийн талан таанам амалатгэрлэлг, харгалзгалг таанамгэрлэлг.



«МОНГОЛ УЛС ДАХЬ УУЛ УУРХАЙ БА ХҮНИЙ ЭРХ» СЭДЭВТ ҮНДЭСТНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГИЙН БАРИМТ БИЧИГ

ОРШИЛ

Монгол улс 2000 оны 9 сард “Мянганы Тунхаглал”-ыг баталсан 189 улс үндэстний нэг болсон юм, Мянганы Тунхаглал нь Мянганы Хөгжлийн 8 Зорилгыг агуулдаг. Монгол улсын хувьд Мянганы Хөгжлийн 9 дэх шинэ зорилгыг Улсын Их Хурлын 2005 оны чуулганаар баталсан билээ. Мянганы Хөгжлийн 7 дахь зорилго нь “байгаль орчны тогтвортой байдлыг баталгаажуулах” ба 9 дөх зорилго нь “хүний эрхийг бэхжүүлж, ардчилсан засаглалыг хөгжүүлэх” гэж тодорхойлжээ. Энэ хоёр зорилго нь хамтдаа Монгол улсад хүний эрх, ардчилал, уул уурхайг хөгжүүлэхтэй холбоотой. Долоо дох зорилгын, 10 дахь зорилт “тогтвортой хөгжлийн зарчмыг улсын бодлого, хөтөлбөрт тусган, байгалийн нөөцийн алдагдлыг нөхөн сэргээх”, 9 дөх зорилгын 20 дахь зорилт нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалыг хүндэтгэн бүрэн хэрэгжүүлж, хэвлэл мэдээллийн эрх чөлөө болон олон нийтийн мэдээлэл авах эрхийг хангах”, мөн зорилгын 21 дэх зорилт нь ардчиллын зарчмыг амьдралд нэвтрүүлэх”, 22 дох зорилтод “нийгмийн бүх салбарт авилгалыг үл тэвчих орчинг бүрдүүлэх” гэж заажээ.

НҮБ-ын Хүний Эрхийн Бүлэг (ХЭБ)-ийн сүүлийн (2005 оны 10 сарын 21) хуралд оролцогчид уул уурхайн салбар сүүлийн арван жилд эрчимтэй хөгжиж, Монгол улсын эдийн засгийн өсөлтийг хангахад чухал үүрэг гүйцэтгэсэн боловч энэхүү эдийн засгийн өсөлт нь Монгол улсад “байгаль орчны тогтвортой байдлыг хангах” гэсэн Мянганы Хөгжлийн 7 дох зорилго, эсхүл “хүний эрхийг бэхжүүлэх” гэсэн Мянганы Хөгжлийн 9 дэх зорилготой нийцсэнгүй. Оролцогчид байгаль орчинд учруулсан хохирол болон Монгол улсын Мянганы Хөгжлийн Зорилгыг биелүүлэхэд улам их бэрхшээл үзүүлэх болсон уул уурхайн үйл ажиллагаанаас зөрчигдсөн орон нутгийн иргэдийн хүний эрхийн асуудлыг хэлэлцсэн. Эдгээр бэрхшээл, хүндрэлийг шууд, нээлттэй хэлэлцсэнээр Монгол улс олон улсын норм, стандартын дагуу байгаль орчин болон иргэдээ хамгаалж, эдийн засгийн тогтвортой хөгжлөө хангах чадвартай болоход нэмэр болно гэж үзжээ.

Иймээс НҮБ-ын ХЭБ “Монгол улс дахь Уул Уурхай ба Хүний Эрх” сэдэвт үндэстний хэлэлцүүлгийг зохион байгуулах шийдвэр гаргасан юм. Энэ хэлэлцүүлгийн гол зорилго нь Монгол улсын уул уурхайн тогтвортой хөгжлийг хангах хүрээнд байгаль орчин, хүний эрхийг сахин хамгаалах чиглэлээр үр дүнтэй хамтын ажиллагаа, түншлэлийг бий болгох, уул уурхайн хөгжлийг цаашид тогтвортой хангахад тулгарч байгаа олон зангилаа асуудлаар уул уурхайн салбар, төр засаг, иргэний нийгмийн

байгууллагууд мэдээлэл солилцох, ойлголцлыг бий болгоход оршино хэмээн тодорхойлсон билээ.

Энэхүү хурлын шийдвэрийн дагуу НҮБ-ын Суурин Төлөөлөгчийн Газар, НҮБ-ын ХЭБ хамтран уул уурхайн салбарт гарч байгаа хүний эрхийн асуудлыг судлах, үндэсний хэлэлцүүлэгт зориулсан баримт бичиг бэлтгэх ажлыг Хүний Эрх Хөгжил Төвөөр гүйцэтгүүлсэн юм. Хэлэлцүүлгийн баримт бичгийн гол зорилго нь уул уурхай ба хүний эрхтэй холбоотой зангилаа асуудлуудыг тодорхойлоход оршиж байв.

Энэ дагуу судалгаанд уул уурхайн компаниуд, хувиараа алт олзворлогчид, уул уурхайн сөрөг үр дагавраас нутаг усаа хамгаалах гэсэн иргэдийн хөдөлгөөнүүд, Хүний Эрхийн үндэсний Комисс, шүүх, прокурор, цагдаагийн байгууллага, НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын төлөөлөгчид, нийтийн эрүүл мэнд, байгаль орчны асуудлаар ажилладаг шинжлэх ухааны байгууллагуудын төлөөлөгчид, Архангай аймгийн Цэнхэр сум, Дорнод аймгийн Баяндун сум, Өмнөговь аймгийн Мандал Овоо сум, Төв аймгийн Заамар сумын малчид, иргэд, баг, сум, аймгийн түвшний удирдлага, хувиараа алт олборлогч нартай ганцаарчлан уулзах, бүлгийн ярилцлага зохион байгуулах замаар мэдээлэл авч боловсруулав. Аймгуудад өрнөж байгаа ашигт малтмал олзворлох үйл ажиллагааны тухай ерөнхий мэдээллийг НҮБ-ын хүний эрхийн сайн дурын ажилтнуудын тусламжтайгаар 13 аймгаас авав.

Хэлэлцүүлгийн баримт бичгийг гаргахдаа оролцогч бүх талуудын ашиг сонирхлыг хүндэтгэж, хүний эрх ба байгаль орчныг хамгаалах зарчмыг уул уурхайн салбарын хөгжилтэй хэрхэн зохистойгоор уялдуулах тухай тэдний санаа бодлыг тусгах зарчмаар ажиллав.

Түүнчлэн уул уурхайн салбарт байгаль орчин ба хүний эрхийн талаар гарч буй зөрчлүүд, түүнд холбогдох талууд хэрхэн хандаж, шийдвэрлэж байгаа мэдээллийг цуглуулж, кейс анализ хийлээ.

Хэлэлцүүлгийн баримт бичигт дээрх чиглэлээр цуглуулсан мэдээлэлд хийсэн дүн шинжилгээнээс гадна уул уурхайн салбарт оролцогч олон талын бүтээлч хамтын ажиллагааг бий болгох замаар энэ салбар дахь байгаль орчин ба хүний эрхийн асуудлыг амжилттай шийдвэрлэж байгаа бусад орны туршлагыг харуулах, мөн Монгол улсад уул уурхайн хөгжлийг хэрхэн байгаль орчин, хүний эрхийн асуудалтай зохицуулж болох талаар зөвлөмж боловсруулан тусгав.

УУЛ УУРХАЙН САЛБАРААС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛСЭН СӨРӨГ ҮР ДАГАВАР

Монгол орон өргөн дэлгэр нутагтай, цөөн хүн амтай, олон төрлийн ашигт малтмалын баялаг орд газруудтай. 1997 оноос ашигт малтмалын тухай хууль

батлагдан, Засгийн Газрын “Алт” хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн. үүний дүнд уул уурхайн салбар өргөжин улсын эдийн засгийн тэргүүлэх секторын нэг болсон. Улсын хэмжээгээр хүчин төгөлдөр байгаа лицензийн тоо 6171 бөгөөд нийт талбайн хэмжээ нь 71107888,66 га болж байгаа нь Монгол орны нутаг дэвсгэрийн 45-аас дээш хувийг эзэлж байна. үүнээс 5172 хайгуулын лиценз 70901641,1 га, 999 ашиглалтын лиценз 206247.56 га газрыг хамарч байна.

Ашиглалтын лицензийг байгалийн үзэсгэлэнт газар, усны хагалбар газар, хамгаалбал зохих амьтан ургамалтай газар зэргийг харгалзахгүй олгож байгаагаас Монгол орон өнөө үеийн болон хойч ирээдүйнхээ өмнө нөхөж барахгүй хохирлыг бий болгосоор байна. Замбараагүй лиценз олголт, уурхайн, ялангуяа алтны уурхайн ядмаг, байгаль орчинд халтай технологи, байгаль орчны үнэлгээ, нөхөн сэргээлтийг хуулийн дагуу хийж хэрэгжүүлдэггүй, уурхайн үйл ажиллагаанд мэргэжлийн болон орон нутгийн иргэдийн хяналт сул, бараг байхгүй байгаагаас уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөө түүнээс үүссэн хүний эрхийн зөрчил нэн тулгамдсан асуудал болоод байна.

Уул уурхайн салбарт гарч буй хүний эрхийн зөрчил нь гол төлөв энэ салбараас байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөтэй холбоотой байна. Уул уурхайн үйл ажиллагаанаас Монгол орны байгаль орчин ихээхэн бохирдож, эвдэрч сүйтгэж байна.¹ Энэ чиглэлээр хийгдсэн судалгааны тайлан, мэргэжлийн хүмүүс, малчидтай уулзаж ярилцахад Монгол орны уур амьсгал, байгаль орчин ихээхэн өөрчлөгдөж, эвдэрч сүйрч байгаа бөгөөд үүний нэг гол шалтгаан нь уул уурхайн үйл ажиллагаа гэж дүгнэж байна. Байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөө юуны түрүүнд ус, бэлчээрийн хорогдол, элэгдэл, сүйтгэлээр илэрч байна.

Гол ус. Төв азийн өндөрлөг газар орших эрс, тэс уур амьсгалтай Монгол орон усны нөөцөөр баялаг бус бөгөөд жилдээ орох хур тунадасны хэмжээ түүний зарим нутагт ундны усны хэрэгцээ ч хангадаггүй байна. Нэгж талбайд ногдох усны нөөцөөр бусад орнуудтай харьцуулахад нэн бага, 1 км² талбайд ойролцоогоор 22 орчим мян.м³ ус ногддог ба дэлхийн 145 орноос усны бага нөөцтэй 23 орны өмнөхөн ордог байна². Түүний зэрэгцээ нүүдлийн мал аж ахуйн амин чухал хэрэгцээ нь гол, ус түүнээс тэтгэгдэж байдаг бэлчээр юм. Гэтэл Монгол оронд хэрэглэж байгаа уул уурхайн технологи нь ус их хэрэглэдэг онцлогтой. Уул уурхайнууд, ялангуяа алтны уурхайн үйл ажиллагаанаас олон гол мөрөн, булаг шанд, газрын гүний ус, нуур цөөрөм бохирдож, ус нь татарч, ширгэж үгүй болж байна. 2003 оны Улсын усны тооллогын дүнгээр гадаргын ус нэлээд хорогдож, ширгэсэн гол горхи, булаг шанд, рашаан, нуур тойрмын тоо

¹ Тус ярилцлагын баримт бичгийн хүрээнд 14 аймгаас уул уурхай хийгээд хүний эрхийн зөрчилтэй холбоотой асуудлаар мэдээлэл бэлтгэсэн юм. Үүний дэлгэрэнгүй Хавсралт 2-ээс үзнэ үү.

² Г. Даваа нар., “Хөдөөгийн хүн амын усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуй” УБ., 2005

ХҮНИЙ ЭРХ 2006/2

3000 дөхөж байна. Ийнхүү ус хомсдож байгаагаас орон нутгийн иргэд хүндхэн асуудлуудтай тулгараад байна. Үүний цорын ганц шалтгаан нь уул уурхай биш боловч байгаль орчинг шаардлагын дагуу хамгаалдаггүй уул уурхай эрчимтэй хөгжсөн нь гол хүчин зүйл болсон.

Хүснэгт 1. Монгол орны гадаргын усны тооллогын нэгдсэн дүн

Гол горхи		Булаг шанд		Рашаан		Нуур, тойром	
Нийт	Ширгэсэн	Нийт	Ширгэсэн	Нийт	Ширгэсэн	Нийт	Ширгэсэн
5565	683	9600	1484	374	10	4193	760

Бэлчээр. Монгол орон 1.3 сая орчим хавтгай дөрвөлжин км бэлчээрийн талбайтай бөгөөд энэ нь бүх газар нутгийн 82 хувьтай тэнцдэг. Гэвч алтны уурхайн үйл ажиллагаанаас нэлээд их сүйтгэгдэж байна. Алт олзворлох үйл ажиллагаа усны эх үүсвэр бараадаж явагддаг болохоор гол, худаг, гүний ус хорогдож бэлчээрийн болон хадлангийн талбайн нөхөн сэргээлтэд харшилж байна. Учир нь уул уурхайн аливаа үйл ажиллагааны дараах байгаль орчны нөхөн сэргээлтийг шаардлагын дагуу хэрэгжүүлэхгүй байна. Мөн усны хомсдолтой холбоотой бэлчээрийн хорогдлоос гадна малчдын өвөлжөө, хаваржаа, бэлчээрийн хамт ашиглалтын лицензийн талбайтай давхцах, уурхайн том машин механизмын зам, замын шороонд дарагдаж бэлчээр талхлагдах нь түгээмэл байна.

Хүснэгт 2. Хайгуулын болон ашиглалтын лиценз, сүйтгэгдсэн бэлчээр, гол усны тоо /бүрэн бүс мэдээ³

№	Аймгийн нэр	Олгогдсон лиценз			Сүйтгэгдсэн бэлчээр (га)	Бохирдсон, ширгэсэн гол, горхи, нуур цөөрөм, рашаан, худаг (тоогоор)
		Х	А	Нийт		
1	Архангай	-	19		4	10 гаруй
2	Баян-Хонгор	550	66	616	436.800	40 гаруй
3	Баян-өлгий	7	4	12	1.6	-
4	Булган	-	-	15	8000	10
5	Говь-Сүмбэр	14	2	16	-	45
6	Дорноговь	577	55	632		-
7	Дорнод	-	-	25 ⁶	2113.4	2
8	Дундговь	420	20	440	-	-
9	Завхан	61	-		-	-
10	Хэнтий	525	53	571	-	44
11	Өвөрхангай	87	16	103	-	2
12	Өмнөговь	340	22	362	24156	3
13	Увс	32	133	165	9437.8	4

³ НҮБ-ын орон нутагт ажилладаг хүний эрхийн сайн дурын ажилтнуудын бэлтгэн ирүүлсэн мэдээлэлд тулгуурлан бэлтгэв.

⁴ Өвөлжөө 11, Хаваржаа 12, Зуслан 20, намаржаа 15 нэрвэгдсэн, 10 га-ийн ой мод сүйтгэгдсэн, 2500 га-ийн ургамал, амьтан устаж үгүй болсон

⁵ Дорноговь аймагт одоогоор энэ талаар тодорхой мэдээлэл байхгүй байна.

⁶ Энэ тоо нь тогтмол үйл ажиллагаа явуулдаг компаниудын тоо юм. Одоогоор 350 аж ахуйн нэгж, иргэнд хайгуул, олборлолтын лицензийг олгожээ.

УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ

Уул уурхайн салбарын хүрээнд гарч буй хүний эрхийн зөрчлүүдийг оролцогч талуудын үзэл бодлоор авч үзвэл дараах байдалтай байна.

Малчдын бүлэг. Монгол улсын хүн амын бараг 30 орчим хувь нь мал аж ахуй эрхэлж амьдардаг билээ. Энэ бүлэг нь Монгол орны нүүдлийн мал аж ахуйд суурилсан соёл, амьдралын өвөрмөц хэв маягийг хадгалж байгаа хүн амын бүлэг юм. Гэвч тэд уул уурхайн үйл ажиллагаанаас хамгийн их хохирч байгаа нийгмийн бүлэг болсон. Орон нутгийн иргэд, малчид тэдний амьдарч байгаа орон нутагт өсөн хөгжиж байгаа уул уурхайн салбараас, ялангуяа тухайн нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын үйл ажиллагаанаас ямар ч ашиг тус байхгүй байна хэмээн санал нэгтэй дүгнэж байна. Ийм учраас тэд орон нутагтаа алтны уурхайг ажиллуулах ямар ч сонирхолгүй ажээ.

Хайрцаг 1. Уул уурхайн үйл ажиллагаанд өртсөн нутгийн малчдын ярианаас⁷

...Манай нутагт ажиллаж байгаа алтны компаниудаас бид ямар ч ашиг олж харахгүй байна ...нутаг орон, гол усыг маань сүйтгэж, биднийг амьдрах аргагүй болгох юм.

...Засаг даргадаа за манай суманд л алт гарвал битгий өгч үзээрэй гэж хэлдэг. Гэтэл байдлаас харахад харин ч бидний хүсэлтийн эсрэг. Алт гарлаа бид авна гээд компанийнхан ирвэл тэгээ ав гээд л гарын үсгээ зурдаг юм байна. Тэгээд ингэдэг юм байхдаа л гэж бодох юм байна шүү дээ. Дарга нар л мэддэг, өгдөг, шийддэг юм байлгүй гэж л боддог шүү дээ.

...Бэлчээрийн даац, мал маллагааны асуудал их хүнд байна даа. Манай Орхон багийн алтны уурхай орсон нутгаас 40 гаруй өрх, 20000 гаруй толгой мал нүүхээс өөр аргагүйд хүрсэн. Алтны уурхай нутгийн малчин бидэнд үнэхээр муу үр дагавартай юм байна лээ л гэж хэлэх байна. Тэгээд байгаль орчин, бидний амьдрах орчны тухай ярих ч үг алга. Одоо би бодож байх нээ бидний тэмцэл хууль дүрмээ мэдэхгүйгээс л их алдаж гэж бодож байна. Эхлээд алтны компанийнхан бидний нутагт ирээд алт ухаж авч байхдаа их л олон зүйл амлаж байсан. Эсгий, эсгийн гутал, эсвэл мужааны үйлдвэр барьж өгч ажлын байраар хангана, эмнэлэг барьж өгнө гээд л гэтэл одоо бид нүүхээс л өөр замгүй болж хохирч байх шив дээ. ...Малчин бидэнд хамгийн гол зүйл бол ус л байдаг. Одоо нөхөн сэргээлт хийлээ ч гэсэн тэр булаг, ус дахин гарна гэж бодохгүй л байна. Миний мэдэхийн дээрхтэй нийлээд лав л 5 булаг ширгээд байгаа. ...Нэг л мэдэхэд ямар нэг компани манай лицензтэй газар гээд л ороод ирдэг. Нутгийн бид нар юу ч мэдээгүй байхад хүрч ирээд л ухаад унахаар нүүхээс өөр аргагүй болдог.

... Бид нар юу ч мэдэх боломжгүй. Бид ямар газраа өгөхгүй гэж хэлж болох юм биш. Хамгийн сайхан ус, бэлчээртэй газруудад алт ухаж байна шүү дэг. Бид нар алтныханд шахагдаж нүүсээр байгаад нүүх суух газаргүй болж байна.

⁷ Архангай аймгийн Цэнхэр сум, Дорнод аймгийн Баяндун сум, Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын малчидтай хийсэн ярилцлагаас

...Манай сумынхан сүүлийн тав, зургаан жил отроор нүүдэллэж байна. Бид сумаасаа 200-500 км алс орших зэргэлдээх аймаг, сумын нутагт оторлодог. Үүнээс болж манай сумын нэлээд өрх өөр аймаг, сум руу шилжсэн. Шилжих хүсэлтэй өөр олон айл өрх байгаа боловч шилжүүлэхгүй байгаа. Хүүхдийн сургууль, эмнэлгийн үйлчилгээ, тэтгэвэр тэтгэмжээ авах зэрэгт их чирэгдэл гарах болсон. ...Одоо надад тэвчиж суух арга алга, нүүх ч газар алга, хэрвээ одоо энэ нутагт маань алтны компани орж ирвэл буу зэвсгээ бариад тэмцэнэ дээ...

Тэдэнд тохиоллож буй хүний эрхийн асуудлууд. Хэдийгээр иргэний, улс төрийн, эдийн засаг, нийгэм соёлын хүний эрхийн олон төрлийн зөрчлийг дурдаж болох боловч дээрх ярилцлагаас тод харагдаж байгаа дараах хэдэн төрлийг дурдъя.

- Бэлчээр, ус нь сүйтгэгдэж мал аж ахуйгаа эрхлэн амьжиргаагаа авч явах эрх нь зөрчигдөхөд хүрч байна.
- Иймээс тухайн орон нутгийн ард иргэдийн эдийн засгийн боломж хумигдаж байхад оронд нь өөр боломж бий болгож амьжиргаагаа зохистой түвшинд байлгаж улмаар сайжруулах эрхийг зөрчиж байна.
- Хөрс, ус нь бохирдох, газрын гадаргууг эвдсэнээс эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх
- Ашиглалтын лицензийн үйл ажиллагаа эхлэх гэж байгаа тухай мэдээлэл авах эрх,
- Ашиглалтын лицензийн үйл ажиллагааг эхлэх зөвшөөрөл олгох тухай шийдвэр гаргахад оролцох эрх
- Алсын отор хийснээр сурч боловсрох, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ авах эрхийн хэрэгжилт хүндрэх,
- Уул уурхайн үйл ажиллагаанаас сүйрсэн газар, усаа нөхөн сэргээх, хянахад оролцох эрх,
- Уламжлалт мал аж ахуйн аргаа орхиход хүрч байгаа нь хөгжлийн замаа өөрөө сонгож хөгжих эрх зэргийг хэрэгжихгүй байгааг дурдаж болно.

Малчдын хүний эрх ийнхүү зөрчигдөж байгаа нь Монгол улсын хууль байгаль орчин, орон нутгийн иргэд, малчдыг зохих ёсоор хамгаалж чадахгүй байгаатай холбоотой юм.

Албан бус алт олборлогчид⁸. Албан бус алт олборлогчдын талаар олон жил ярьж, олон судалгааны тайлан бичигдсэн. 2003 оны байдлаар Монгол улсад 100.000⁹ гаруй хүн гар аргаар алт олборлож байна. Гар аргаар алт олборлогчидтой холбоотой асуудлууд нь шийдвэрлэвэл зохих асуудал болоод байгааг ярилцлагад оролцогч бүх талууд өгүүлж байна. Учир нь

⁸ Төв аймгийн Заамарын Сов буюу өгөөмөр /хуучнаар Хайлаастай/ баг, Гео, 26 гэдэг нэртэй 3 газрын гар аргаар алт олборлогчид болон тэнд амьдарч буй оршин суугчидтай ярилцлага хийж мэдээллийг цуглуулав.

⁹ Grayson Robin, Ninja Gold Minets of Mongolia 2003, p.23

- Гар аргаар алт олборлогчдын эрх зүйн орчин өнөөг хүртэл шийдэгдээгүй, энэ төрлийн үйл ажиллагааг албан ёсоор хүлээн зөвшөөрөөгүй гэж үзэж болно.
- Одоогоор зохицуулж байгаа “гал унтраах” буюу түр зуурын шинжтэй дүрэм журам энэ төрлийн үйл ажиллагааны бүх төрлийн харилцааг зохицуулахад хангалтгүй нь илэрхий юм. Хувиараа алт олборлогчид нь алтны уурхай, лиценз эзэмшигч, цагдаа, орон нутгийн захиргаа, нутгийн иргэдтэй тогтмол зөрчилтэй байдаг ба тэдний зүгээс үргэлж дарамттай тулгардаг байна. Нэгэнт хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдөөгүй болохоор тэдний эрхийг хамгаалах, баталгаажуулах ямар ч боломжгүй ажээ.
- Эрүүл мэнд болон аюулгүй байдлыг хангах ямар ч дүрэм байхгүй болохоор албан бус аргаар алт олборлох нь маш аюултай үйл ажиллагаа юм. Тэдний нэгний хэлснээр: “...Энэ бол амь өрссөн хөдөлмөр. Өглөө гарсан хүн амьд ирнэ гэсэн ямар ч баталгаа байхгүй...”
- Гар аргаар алт олборлогчдын ажиллаж байгаа орчинд хүний эрхийн бүх зөрчил оршиж байна. Эрүүл аюулгүй орчинд амьдрах, амьд явах, эрүүл хоол хүнсээр хангагдах, эрүүл мэндээ хамгаалах, сурч боловсрох, сонгох, сонгогдох эрх зэрэг.
- Гэхдээ тэдэнтэй хийсэн ярилцлагаас үзэхэд тэднийг эрхээ хэрхэн хамгаалах тухай мэдээллээр хангах нь хамгийн чухал байна. Учир нь ийм мэдээлэлгүйгээр тэд өөрсдийнхөө байдлыг сайжруулах юу ч хийж чадахгүй.
- **Хүүхдийн хөдөлмөр.** “Сургууль завсардсан хүүхдүүд маш олон. Насанд хүрээгүй хүүхдүүд алтанд гарч энэ хүнд хүчир хөдөлмөрийг бусдын адил хийж, шороонд дарагдаж үхэж байна. Хэн энэ болгоныг хайхарч байгаа юм?” гэж тэд асууж байна.
- **Байгаль орчны сүйтгэл бохирдолт:** Тар аргаар алт олборлогчид, алтны компани хоёрын хэн нь илүү байгаль орчныг сүйтгэж байна? гэж асуухад - “Хоёулаа” хэмээн хариулж байна. Тэдний хариултаар аль нь ч байгаль орчны нөхөн сэргээлт хийдэггүй байна. Түүнээс гадна гар аргаар алт олборлогчдын дунд мөнгөн ус хэрэглэх үзэгдэл түгээмэл, энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэгчид эрүүл шинэ газар үйл ажиллагаагаа өргөжүүлэх болсон нь анхаарал татсан асуудал болоод байна.
- **Эдийн засгийн зохицуулалтгүй байгаа нь** энэ төрлийн үйл ажиллагаанаас орох эдийн засгийн үр өгөөжийг сайжруулах шаардлагатай болжээ. Тэд олборлосон алтаа улсад тушаан, зохих татвараа төлөн үйл ажиллагаагаа албан болгох хүсэлтэй байна.

Гар аргаар алт олборлогчид: Нийтлэг зөрчлүүд .

- **Цагдаа нинжа нарын хоорондох зөрчил:** “Алтын ордыг ашиглаж дуусаад компани болон газар түрээслэгчид нинжа нарыг оруулна. Учир нь зарим тохиолдолд том техникээр биш гар ажиллагаа шаардагддаг байна. Тийм үед нинжа нарыг зөвшөөрч оруулаад алт илрэнгүүт хэн нэг нь газрын зөвшөөрөл, лицензийг аваад нөгөө нинжа нарыгаа цагдаа нарын тусламжтайгаар хөөж гаргана. Энэ бол хамгийн сонгодог арга. Цагдаагийн байгууллагын дарга нарт нь авилга өгдөг, цагдаа нар тушаал биелүүлдэг. Гэхдээ цагдаа нар бас зүгээр нэг хөөхгүй, баривчилна, зодно бороохойдно. Тийм байж болох уу?” гэж судалгаанд хамрагсад ярьж байна.
- Компани, нинжа нар: байнга зөрчил тэмцэлтэй байдаг. Энэ ч ойлгомжтой. Алтны төлөө өрсөлдөж, хүч сорин тэмцэлгээж байна. Компаниуд хөрөнгө мөнгө, техник хэрэгсэл, эрх дархтай. Дээр нь хууль, засаг захиргаа бүгдийг өөрийн ашигт нийцүүлж чадаж байна. Иймээс хууль бусаар гэсэн нэрийн дор хувиараа алт олборлогчид байнга хохирол амсаж байдаг. Гар аргаар алт олборлогчдын хэлснээр: “Ашигласан газартаа гар аргаар алт олборлогчдыг оруулдаг учир нь гэвэл 1 цаг бульдозер ажиллуулахад 10000₮, экскаватор - 30000₮ үнэтэй байдаг. Иймээс тэд өөрийн газар дээр зөвшөөрсөн болж алт олборлогчдыг ажиллуулж, ямар ч үнэ төлбөргүй алтаа нээлгэхэд дараа нь цагдаагийн хүчээр хөөлгөдөг бас л хүний хөдөлмөрийг цэвэрхэн ашиглачихдаг сонгодог аргын нэг байгаа биз...”
- **Лиценз эзэмшигч нинжа нарын хоорондох зөрчил:** мөн дээрхтэй адил. Хэрэв энэ асуудлыг шийдэх эрчимтэй арга хэмжээ авахгүй ба үр дагаврыг нь урьдчилж хэлэхэд хэцүү. Нэгэн нинжагийн хэлснээр “...Цагаан жилтэй Геологийн нэг дарга хүн ноднин 4 сарын дундуур гар буу гаргаж нинжа руу буудсан. Тийм л юм дахин бүү болоосой...”
- **Нутгийн иргэд ба нинжа нар:** Малтай байсан нутгийн ардын амьдрал хэцүү болж байна. Олон газраас ирсэн хүмүүс мал хулгайлна. Өвөлжөө, бууц, түлээ түлш, малыг нь хулгайлна. Наад зах нь усны голдрил өөрчлөгдөөд нөгөө хүмүүс суурьшсан нутаг усаа орхиод шинэ газар нүүх болно. Өвөлжөө бууцных нь ойролцоо газар нүх ухна. Хажуугийнх нь хад чулуунаас хөдөө аймгуудаас ирээд бутлаад аваад явчихна. Бүх л бурууг нинжа нарт тохно.
- **Орон нутгийн засаг захиргаа ба нинжа нар:** Хувиараа алт олборлогчдыг хөөж туух үеэр л төр засгаас хэдэн хүн ирж харагддаг. Бусад цагт хүн ирдэггүй. Алт олборлогчид ирж бидний ажлыг хүндрүүлж амьдралыг маань доройтуулж байна гэсэн үзлээр ханддаг. Компаниудаар татвар авна. Түүгээр барахгүй лиценз зөвшөөрлийг авахад ихээхэн хэмжээний авилгал авч л байгаа. Одоогоос 5 жилийн өмнө Цэнхэр, Улаан хад, Гурван гэр гэдэг газрууд ашиглагдчихсан газар байсан. Нинжа нар очоод дахиад алт илрүүлэхэд дахин Лиценз олгож түрээсэлсэн. “Хэн, яаж, ямар замаар авч өгч байгааг хэн мэдэж байгаа юм. Ядаж Заамараа хөгжүүлэх хэрэгтэй, тийм ч юм байхгүй. Ядахдаа замаа засуулчхаж болно доо. Монголын хэдэн иргэдээ хамгаалж чадахгүй гадныханд ашиглуулаад байх юм”.

Гар аргаар алт олборлогчдын эрх зүйн орчныг боловсронгуй болгож эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлж, гар аргаар алт олборлогчдын нийгмийн асуудлыг шийдэх, байгаль орчны нөхөн сэргээлт, хүний эрхийг зөрчлүүдийг арилгах зэрэг арга хэмжээ авах шаардлагатай болжээ. Учир нь энэ төрлийн үйл ажиллагааг зохицуулж байгаа түр зуурын дүрэм журам, улс төрчдийн сонгуулийн амлалт зэрэг нь гар аргаар алт олборлогчдын нөхцөл байдлыг улам бүр муутгаж байна.

ОРОЛЦОГЧ ТАЛУУД

Орон нутгийн удирдлага

2002 оны 1 сард батлагдсан Тусгай Зөвшөөрлийн Хуулийн тодорхой заалтуудаар аж ахуйн нэгжүүд нь лицензийн бүртгэлийн эцсийн зөвшөөрлийг засгийн газраас хүлээн авахаас өмнө бүс нутагт явуулах үйл ажиллагааныхаа талаар холбогдох орон нутгийн засаг даргатай зөвшилцөхийг шаардсан байдаг. Мөн Ашигт Малтмалын хуульд лиценз эзэмшигчийг уурхайн үйл ажиллагаагаа эхлүүлэхэд сумын засаг даргад хууль тогтоомжоор ашигт малтмал хайх, ашиглахыг хязгаарласан эсхүл хориглосноос бусад тохиолдолд лицензийн тухай мэдээлэл авч тухайн газрыг уг лицензэд заасан зориулалтаар ашиглуулах үүрэгтэйг хуульчилсан байна.

Бодит байдал: Орон нутагт уурхайн үйлдвэрлэл явуулахад орон нутгийн удирдлага ямар үүрэг, хариуцлагатай байдаг тухай өгүүлэхэд дараах зөрчилт байдал ажиглагдаж байна.

Хайрцаг 3. Аймгийн захиргааны албан тушаалтны яриа

Анх манай аймагт алтны компанийг үйл ажиллагаагаа явуулж эхлэхэд олон хүн аймаг орны маань хөгжилд их зүйл оруулна гэж хүлээж байсан. Харин одоо бодит байдал дээр орон нутгийн иргэдэд ямар ч ашиг шим хүртэхгүйгээр үл барам байгаль орчноо сүйтгүүлж амьдрах аргагүй болж нүүхээс өөр аргагүй байдалд орж байгааг л бид хараад сууж байна шүү дээ. Үүнд би их харамсдаг. Энэ үйлдвэрлэлээс Улсад юу ордгийг нь би ч тодорхой мэдэхгүй.

Миний бодлоор орон нутгийн удирдлагад ямар ч эрх мэдэл байдаггүй юм. Тухайн аймагт алт олборлох үйл ажиллагааг дээгүүрээ том дарга нар шийддэг. Үүнийг бүүр хариуцдаг тусгай хүмүүс бий болчихсон, сүлжээ үүсчихсэн, тэгээд хэнийг хаана ажиллуулахаа тэд л шийддэг юм шүү дээ. Тэднээс ямар их дарамт ирдэг гэж бодож байна. Хэрвээ би аймаг орон нутагтаа ямар нэгэн юм гуйвал компанийн шаардлагатай баримт бичиг дээр гарын үсэг зурахаас өөр аргагүй болдог.

Би аймгийн даргаар ажиллаж байхдаа нэгэн алтны компани үйл ажиллагаа явуулж буй сумын тамгын газрын ажилтнуудын цалингийн 50%-ийг төлүүлдэг байсныг болиулсан. Тийм завхарсан байдлаар дур зоргоороо ажиллах нөхцөлөө хангаж байдаг юм энэ алтны компаниуд.

Манай аймагт ажиллаж байгаа алтны компанийн үйл ажиллагаанаас харахад ашигт малтмалын тухай хуулийг өөрчлөхөөс өөр аргагүй юм байна гэж боддог. Яагаад? Учир нь лицензээ авчихсан, зардал гаргачихсан алтны компаниуд ажлаа олборлолтоо хийнэ гээд ирчихдэг, энэ уурхайн төсөл нь нутаг оронд маань ямар ч ашиггүй байдаг, гэтэл одоо үйлчилж байгаа хуулиар орон нутгийн удирдлагад ямар ч эрх мэдэл байдаггүй их хэцүү л юм байна лээ.

...Намгүйгээр албан тушаалтан ажиллах боломжгүй байдаг юм. Намаас ямар үүрэг даалгавар өгнө түүнийг л бид хэрэгжүүлдэг бодит байдал нэгэнт тогтоод байна шүү дээ. ... Намын хурал дээр зарчмын санал чангахан хэлбэл, "чамаас аяархан ярьдаг хүн байдаг юм шүү" гэж тухайн хүнд сануулдаг.

- үүнээс үзэхэд орон нутгийн түвшинд дээрээс лицензээ хуулийн дагуу аваад ирсэн компаниудад хориг саад тавих чадамжгүй бөгөөд харин ч тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулах боломжийг нь хангаж өгөх үүрэг хүлээдэг.
- Бүх татвар нэгдсэн төсөвт ордгоос тухайн аймаг орон нутагт хэрэгжиж буй уул уурхайн төслүүдээс тус орон нутагт бодит үр ашиг байхгүй.
- Орон нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулах нь ихээхэн улс төржсөн, улс төрийн намын бүлгээс ихээхэн дарамттай учирдаг байна.
- Энэ нь орон нутгийн удирдлагын бие даасан байдлыг бүрэн алдагдуулж, орон нутгийн эрх ашгийг хамгаалах ажиллах зарчмыг хөсөрдүүлж байгаа юм.
- Хуулийн хэрэгжилтийг хянах, эрчимжүүлэх чиглэлээр аймгийн удирдлага тодорхой ажил төлөвлөн ажилладаг боловч түүний үр дүн тодорхой харагдахгүй байна.
- Уул уурхайгаас аймгийн газар нутгаа хамгаалах цорын ганц арга нь тодорхой нутаг дэвсгэрийг аймгийн болон сумын тусгай хэрэгцээнд авах арга хэмжээ болдог байна.

Тиймээс орон нутгийн удирдлагууд уул уурхайн салбартай холбоотой холбогдох хууль, дүрэм, журам заалтыг өөрчлөх, аймаг орон нутагт эдийн засгийн хувьд үр өгөөжтэй, нутгийн иргэдийн эрх ашгийг хөндөхөөс сэргийлсэн, улс төр, ашиг сонирхлын бүлгийн дарамтаас ангид байх байдлаар өөрчлөхийг хүсэж байна.

Хайрцаг 4: Сумын захиргааны албан тушаалтны ярианаас

Сумын засаг даргын хувьд хамгийн хүндрэлтэй асуудал нь Геологи, Уул Уурхай, Кадастрын Алба (ГУУКА) орон нутагтай ямар ч харьцаагүй байдаг. Орон нутаг хууль зүйн хувьд ямар ч эрх мэдэлгүй. Гэнэт л лиценз авсан, ордыг шилжүүлж авсан гээд л ороод ирдэг. Бидэнд мэдэгдэж байгаа юм гэвэл Зууны мэдээ сониноос тэрний лицензийг тэр шилжүүлж авжээ гэдгийг хайчилж авдаг. Аймаг сум, ерөөсөө мэдэхгүй, хотоос л шийдсэн байдаг. Улсын хөрөнгө оруулалтаар хайгуул хийсэн ордыг улс мэднэ, хувийн хөрөнгөөр асар олон хайгуул хийгдэж байна. Нэг мэдэхэд

Л ашиглалт хийх компанид худалдсан байдаг. Орон нутагт юу үлддэг вэ гэхээр усны төлбөр л авна. Алтаа Монгол банканд тушаадаг хэдэн кг алт тушаасан нь ч мэдэгдэхгүй. Лицензийн наймаа малын наймаа шиг болж, өөр компани ороод ирдэг. Үүнээс болоод өмнөх компани нь энэ жил хийх ёстой төлбөрөө хийхгүй явчихна. Тэгээд шүүхэд өгөх гэхээр нэрээ сольчихсон, хотод байдаг юм байна тэнд нь өг гэдэг тэгээд л өнгөрдөг. Байгаль орчны хуулиар олгосон эрх хэмжээ байгаа боловч хөөцөлдөх гэхээр хууль тогтоомжийн талаар бидэнд туслах газар байдаггүй. Арга яахдаа л аймгийн мэргэжлийн хяналтын газрыг дууддаг. Тэд нар ирээд акт бичээд битүүмжлээд явдаг. Дандаа сахиад зогсоод байх биш яваад өгсөн хойно нь ажиллаад эхэлдэг. Алтны компаниуд үүнийгээ их нууц хийнэ. Засаг даргаар захирамж гаргуулахдаа хуулиар хориотой үйл ажиллагаа явуулахгүй гэж хэлдэг. Нүүснийх нь дараа очиход л мөнгөн ус үлдсэн байдаг. Хувиараа алт олборлож байгаа нинжа нар мөнгөн усыг нь тогоон дээрээ буцалгаад байж байдаг. Сум одоо яахав сайндаа мөнгөн усны хорын тухай гарын авлага гаргаж ард иргэддээ тараасан. Гэтэл хүмүүс өнөөдрийн хэдэн төгрөгийг бодоод хор уршгийг нь ойлгохгүй байна. Бүх хуулиуд байгаа хэрнээ -ямар ч арга хэмжээ авах боломжгүй байна. Бидний шийдэх юмыг дээш нь яам агентлаг руу заасан байдаг. Орон нутгаас зөвшөөрөл авсны дараа лиценз олгооч гэсэн шаардлагыг хэд хэдэн удаа тавьсан. Одоогоор ур дүнгүй л сууж байна.

Бодит байдалд алтны компаниуд сумын захиргааны ажилчдын цалингийн тавин хувийг олгох нь тохиолддог байна; Энэ нь өөрийн компанийн үйл ажиллагааг засаг захиргааны зүгээс ямар нэгэн саад бэрхшээлгүй, зарим үед хууль бусаар явуулах нөхцөлөө бүрдүүлэхэд хэрэглэдэг арга хэмээн үзэж болох юм. Тухайлбал, алтны компаниуд байгалийн нөхөн сэргээлт хийх мөнгөний 50 хувьтай тэнцэх мөнгийг сумын дансанд байрлуулахгүй байх, ашигт малтмал эрхлэх газар, усны зөвшөөрлийг нутгийн иргэдийн эсэргүүцлийг үл харгалзан гаргуулах зэргээр ашигладаг практик тогтжээ.

Дээрх байдлыг сумын удирдлагууд тайлбарлахдаа: “дээрээс лицензээ аваад ирчихсэн компанийг яаж ч эсэргүүцэх, нутаг оронд ашигтай үйл ажиллагаа явуулах талаар хэлэлцээ хийх эрх зүйн боломж бидэнд байдаггүй юм шүү дээ” хэмээн тайлбарлаж байна. Энэ байдлаас үзэхэд сумын удирдлага нутгийн иргэдийн оролцоог хангах, нутгийн иргэдийн эрх ашгийг зохих ёсоор хамгаалахгүй байна.

Багийн удирдлага нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор багийн иргэдийн хурлаа зохион байгуулж асуудлыг авч хэлэлцэх, багийн нутгаа сумын тусгай хэрэгцээ, аймгийн тусгай хэрэгцээнд авахуулах арга хэмжээг зохион байгуулах, мөн сүүлийн үед нутаг ус, байгалиа хамгаалах зорилготой иргэдийн хөдөлгөөнийг зохион байгуулах, хамтран ажиллах зэрэг идэвхтэй ажиллах болсон байна. Гэвч эдгээр хүмүүсийн хүний эрх, эрх зүйн мэдлэг хомс, хамгийн гол нь уул уурхайн үйл ажиллагаа, компаниуд, төрийн захиргааны дээд шатны байгууллагуудын бодлого,

үйл ажиллагааны талаар мэдээлэл авах бололцоо, механизм байхгүй байгаа нь хамгийн том бэрхшээл болдог байна.

Уул уурхайн компаниуд. Тус ярилцлагын баримт бичгийг бэлтгэх хүрээнд Геологи Уул Уурхайн Кадастрын албанаас гаргасан компаниудын жагсаалтыг ашиглаж компаниудтай утсаар холбоо барьж мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулсан юм. Ашиглалтын лицензтэй аж ахуйн жагсаалтад орсон нийт 588 нэгжид 1077 удаа утсаар залгахад 506 нэгжээс ямар нэг шалтгаанаар мэдээлэл авч чадаагүй бөгөөд 82 аж ахуйн нэгжээс авсан мэдээллийг дор сийрүүлэв.

Уул уурхайн ашиглалтын лиценз эзэмшиж буй компаниудын удирдлагуудаас дараах асуудлуудыг дэвшүүлэн гаргаж байна.

- Байгаль орчны асуудал, үүнээс улбаалсан орон нутгийн иргэд, малчдын эсэргүүцэл ихээхэн тулгарах болсон нь бэрхшээл үүсгэж байна.
- Өөрсдөө ч Монгол орныхоо байгаль орчны эвдрэл сүйтгэл, гол усны хомсдолд санаа зовдог бөгөөд энэ асуудлыг уул уурхайн салбартай оновчтой уялдуулах шинэ зарчим, механизм хэрэгтэй байгааг юуны түрүүнд илэрхийлж байв.
- Түүнээс гадна татварын дарамт их, төрийн байгууллагын хүнд суртал, орон нутгийн засаг захиргааны дэмжлэг байхгүй, технологи, хөрөнгө оруулалтын дутагдал голлох хүндрэлүүд юм.
- Дотоодын үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих бодлого сул: ашигт малтмалын хуульд оруулсан уурхайн ашиглалтын лицензийг дуудлагаар худалдах зарчим нь гадаадын компаниудад илүү боломжийг олгож байгаа, мөн гадаад, дотоодын компаниудад ялгаатай оноосон татварыг эсэргүүцэж байгаагаа илэрхийлсэн байна.
- Мөн гар аргаар алт олборлогчид алтны компаниудын үйл ажиллагаанд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байгааг өгүүлээд үүнийг зогсоох арга хэмжээ авахгүй бол олборлолт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг зүй зохистойгоор хийх нөхцөлийг алдагдуулж байна хэмээн үзэж байна.

Гэхдээ хамгийн гол тэмдэглэвэл зохих нэг асуудал нь алтны компаниудын удирдлагууд уул уурхайн салбарын үйл ажиллагаа хүний эрхийг зөрчинө гэж байхгүй, учир нь энэ салбар манай улсын эдийн засгийн өсөлтийг хангах хамгийн гол үйлдвэрлэл хэмээх үзэл нийтлэг байна /...Эдийн засгийн өсөлтийг хангаж байгаа гол салбарыг хүний эрх зөрчинө гэж юугаа яриад байгаа юм (компанийн захирал)/. Тэд байгаль орчны нөхөн сэргээлтийг хийлгүй, олон га газрыг эвдэн сүйтгэх, гол усыг бохирдуулах, ширгээх нь хүний эрхийн зөрчилд хүргэнэ гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй байна.

Байгаль орчныг хамгаалах төрийн яам, албан тушаалтнуудын үзэл боллоос. Уул уурхайн салбарын өмнө тулгамдаад байгаа олон асуудлууд, түүний дотор байгаль орчны нөхөн сэргээлтийг бодитой хэрэгжүүлэх, хүний эрхийн асуудлуудыг шийдвэрлэхэд төрийн холбогдох яамд, албад дараах саналыг боловсруулан холбогдох хууль тогтоомжид тусгах хэрэгтэй хэмээн үзэж байна.

Юуны түрүүнд ашигт малтмалын хайгуул, ашиглалтын лицензийн олголтод дараах өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай ажээ. Үүнд:

- **Хайгуулын лицензийн хувьд түүнийг олгоход** Сумын засаг захиргааны эрх мэдэл, оролцоог нэмэгдүүлэх, хайгуулын явц дахь байгаль хамгаалах арга хэмжээг сайжруулах, сумын байгаль хамгаалагчийн үүрэг, статусыг нэмэгдүүлэх, хайгуулын лицензийг шинээр нэмж авах, сунгах, бусдад шилжүүлэх тохиолдолд байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилтэд тулгуурладаг байх, Лиценз хүсэх өргөдөл, түүнийг олгох процессыг нийтэд мэдээлэх, тэдний саналыг авах, саналаа өгөх оролцоон хангах, байгаль орчны шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянахад оролцоог нэмэгдүүлэх
- **Ашиглалтын лицензтэй холбоотойгоор** орон нутгийн засаг захиргааны эрх мэдлийг нэмэгдүүлэх, тухайлбал ашиглалтын лицензийг баг, сумын засаг даргын зөвшөөрөл дээр тулгуурлан олгодог байх, гэхдээ байгаль орчны нөхөн сэргээлтийг хийх эдийн засгийн чадавхыг харгалзах, эдийн засгийн хувьд ашиггүй буюу нөхөн сэргээлт, уурхайн ашиглалт зэрэгт зарцуулах өртгөөс ашиг нь илүү гарахгүй ордуудад лиценз олгохгүй байх, лиценз олгож болохгүй газруудыг хуульчлах үүнд: экологийн эмзэг газар буюу гол мөрний эх, нуурын ай сав газар, нэн ховор амьтан, ургамлын байршил газар болон төв суурин, түүх соёлын дурсгалт газруудад г.м. Ашиглалтын явц дахь байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа, хариуцлагын тогтолцоог сайжруулах тухайлбал тухайн жилийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан ажлын 50 хүртэл хувийг хэрэгжүүлээгүй тохиолдолд ашиглалтын лицензийг цуцлах, хохирлыг барагдуулах хариуцлагаас чөлөөлөхгүй байх, ашиглалтын лицензийг сунгах, шинээр нэмж авах, шилжүүлэх тохиолдолд байгаль орчны нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд заавал тулгуурладаг байх механизмыг чангатгах, байгаль орчныг нөхөн сэргээх болон түүнд хор хохирол учруулсан этгээдийн ашиглалтын лицензийг цуцлах, олгохгүй байх, эрүүгийн хариуцлагад татах зэргээр өөрчлөх. Хөндлөнгийн хяналт, ил тод байдлыг нэмэгдүүлэх, нууцад холбоогүй бүх мэдээллийг ил тод болгох, авах боломжоор хангах. Тогтвортой байдлын гэрээ хийвэл түүнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой тодорхой заалтууд болон өргөдөл гомдлыг хянах, арга хэмжээг хэрэгжүүлэх зохих ёсны санхүүжилттэй механизмыг тусгах. Уул

уурхайн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, нөхөн сэргээлтийн чанарыг сайжруулах арга зам, техник технологийг хөгжүүлэх эсхүл бусад орны туршлагыг нэвтрүүлэх, байгаль орчинд уул уурхайн үйл ажиллагаанаас учирч буй сөрөг нөлөөний тухай мэдээлэл, судалгааг сайжруулах, экологийн хохирол, газрын болон экосистемийн нөхөн сэргээлтийн үнийг тодорхойлох аргачлал боловсруулах эсхүл нэвтрүүлэх, байгаль орчны нөлөөллийн үнэлгээг усны ай сав газарт бүхэлд нь хуримтлагдах нөлөөллийг оролцуулан хийх. Иргэдийн саналыг авдаг болох, үнэлгээг нийтэд ил тод болгох зарчмыг хуульчлах, энэ үйл ажиллагаанд гаргах зардлыг нэмэгдүүлэх зэргийг дурдаж болно.

Хүний Эрхийн үндэсний Комисс. Уул уурхайн салбар дахь хүний эрхийн асуудал, уурхайн хөдөлмөрийн нөхцөлд анхаарч ажилладаг ба энэ чиглэлд үйл ажиллагаагаа өргөтгөн уурхайн эргэн тойронд байгаа нутгийн иргэдийн хүний эрхийн асуудалд анхаарал хандуулан ажиллах зорилготой байна.

Шүүгчдийн бүлэг. Хүний эрх, эрх чөлөө нь Монгол улсын үндсэн хууль, Мянганы Хөгжлийн Зорилтын хамгийн чухал, суурь үнэлэмжүүд бөгөөд тэдгээрийг төр засаг хуулиар дамжуулан хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. Төр засгийн энэ үүрэг амьдралд шүүхийн шийдвэрээр хэрэгждэг. Иймээс уул уурхайн салбарын хүрээнд гарч буй хууль бус үйл ажиллагаа, хүний эрхийн зөрчлүүдийг шийдэхэд шүүхийн байгууллага онцгой үүрэгтэй билээ. Иймд өнөөгийн шүүхийн систем нь дээрхтэй холбоотой асуудлыг хэрхэн шийдэж байгаа тухай шүүхийн байгууллагын ажилтнуудын саналыг тусгасан.

2005 оны байдлаар анхан шатны шүүхүүд иргэний нийт 24492 хэргийг хянан шийдвэрлэжээ. үүнээс Ашигт малтмал тухай хуулиар нийт 4 хэрэг шийдвэрлэгдсэн байна. Нийслэл, Төв аймгийн шүүхээр хайгуулын болон ашиглалтын лицензтэй холбоотой маргааныг Архангай, Хэнтий аймгуудад ашигт малтмалын тухай хуулийн бусад асуудлаар нийт 4 хэрэг маргаан шийдвэрлэсэн байна. Захиргааны хэргийн шүүхүүд 2005 онд 386 хэргийг хянан шийдвэрлэжээ. үүнээс газрын тухай хуулиар 73, ашигт малтмалын тухай хуулиар 19 хэрэг тус тус хянан шийдвэрлэсэн байна.

Шүүгчидтэй хийсэн уулзалтаас гарч ирсэн асуудлыг доор сийрүүлбэл: Уул уурхайн салбарт лиценз олголт, татвар, хөдөлмөрийн нөхцөл, байгаль орчин, нутгийн иргэд, малчдын эрхийн зөрчил зэрэг хууль бус үйлдлүүд, гарч байна. Үнэндээ орон нутгийн иргэд, малчдын хүний эрхийн зөрчил түгээмэл байгаа боловч түүнийг шүүхээр шийдвэрлэх нь ховор байна. үүнд хэд хэдэн шалтгаан байна. Энэ асуудал хөдөө орон нутагт их гарах бөгөөд нутгийн малчин иргэд компаниуд хууль зөрчиж байгааг мэддэггүй. Мэдсэн ч шүүхэд яаж хандахаа мэддэггүй. Мөн шүүхэд хандах процесс түвэгтэй байгаа тул иргэд шүүхээр шударга ёсыг тогтоож чадахгүйд хүрч байна. Хөдөөний хүмүүст шүүхээс болгоомжлох, шүүхэд итгэхгүй байх

хандлага ажиглагдаж байна. Эдгээр нь дараах хүчин зүйлээс хамаарч байж болох юм.

- Шүүхийн байгууллагын ажиллагсдын цалин, хангамж муу, иймээс гадны нөлөөнд автах боломж өндөр
- Шүүхийн байгууллагын ажилтнуудын хүний эрхийн мэдлэг сайн биш. Үндсэн хуулийн заалт болон Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцуудыг барин шийдвэр гаргах практик байхгүй.
- Амьдралд гардаг олон хэрэгт хуулийн зарчим, нотлох баримт зөрчилдөж байдаг бөгөөд шүүгч маш чухал үүрэг гүйцэтгэдгийг олон нийт ойлгохгүй байх.
- Удирдлагаар нь дамжуулан шүүгчид нөлөөлж болно, эсхүл шүүх шүүгч, түүний талын хүмүүсийн эрх ашгийг хамгаалдаг гэсэн ойлголт тархсан
- Оролцогч аль нэг талтай холбоотой эсхүл тухайн хэргээс гарах үр дүнтэй хувийн сонирхолтой шүүгчид хэргийг оноодог гэж хүмүүс боддог
- Шүүгчийн мэргэжлийн ёс зүйг дээшлүүлэх, тэдэнд нотлох баримтыг зөв шударгаар үнэлэх, шийдвэр гаргахдаа хуулийн зарчимд тулгуурлах, хувийн үзэл бодолдоо хөтлөгдөхгүй байх

Ярилцлага өгсөн бүх шүүгчид Ашигт малтмалын хуулийг бүхэлд нь өөрчлөх хэрэгтэй ба түүнийг сайжруулахаар өгч байгаа саналыг бүгдийг нь хэлэлцүүлж, хянуур шинжлэх шаардлагатай гэж үзэж байв. Тэдний үзэж байгаагаар уул уурхайн салбарт хамаатай олон хууль байгаа боловч тэдгээр нь бүрхэг, бие биетэйгээ уялдаагүй, зөрчилдөх нь элбэг байна. Мөн хуулийн зөрчилтэй асуудалд анализ хийн түүнийг шийдвэрлэх няхуур арга боловсруулах үүрэгтэй Хууль Хянах Зөвлөл гэдгийг байгуулах санал гаргаж байв.

Тэд мөн шүүхийн удирдах байгууллага сайн ажиллахгүй байна. Иймээс өөрчлөлт хийх хэрэгтэй. Одоогийн системээр шүүгчийн хариуцлага, үйл ажиллагааных нь гүйцэтгэлээр зөвхөн нэг л хүн бүх шийдвэр гаргадаг. Үүнд илүү олон хүн, олон хүний санаа бодол оролцох ёстой гэж хэлж байв. .

НҮБ-ЫН СУУРИН Төлөөлөгчид

Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлснээс болж иргэдийн хүний эрх зөрчигдөж байгаад НҮБ-ын Монгол салбар агентлагууд анхааран өөрсдийн үйл ажиллагааны чиглэлд тодорхой асуудлаар ажиллаж байна.

НҮБ-ын Хүн Амын Сан албан бус алт олборлогчдын нийгэм эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах чиглэлээр сургууль, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, хүчирхийлэл, хүйсийн тэгш бус байдлыг багасгах, нөхөн үржхүйн

эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх, тухайн орон нутагт эдгээр хүмүүст үзүүлэх үйлчилгээг сайжруулах чадавх бүрдүүлэх төслийг хэрэгжүүлнэ.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага Монголд дахь уул уурхайн практикийн хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөнд сэтгэл зовж гурван чиглэлд төвлөрөн ажиллаж байна. Нэгдүгээрт, орон даяар сонгосон газарт усны чанарыг шалгах хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулсан. Хоёрдугаарт, уурхайн эргэн тойронд биеэ үнэлэх явдал дэлгэрч байгаад анхаарч эдгээр газарт бэлгэвчийг хэрэглэдэг дадлыг нэвтрүүлэх зорилго тавин ажиллаж байна. Гуравдугаарт уул уурхайн эргэн тойронд агаарын тоосжилт ихэссэнээс үүсдэг силикоз өвчний эсрэг хөтөлбөр хэрэгжүүлсэн байна. Эдгээрээс гадна мөнгөн усны хордлого болон албан бус алт олборлогчдын асуудлаар ЖАЙКА-тай хамтарч ажилласан ба олон уурхайд үйл ажиллагаагаа эхлэхээс нь өмнө эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах талаар зөвлөгөө өгчээ.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага Уул уурхайн үйл ажиллагаанаас үүссэн хүний эрхийн зөрчил нь гол анхаарч ажилладаг асуудал. Уул уурхайн салбарт байдаг хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр, уул уурхайн компани, албан бус алт олборлогчдын хоорондох хэлэлцээг урагшлуулах, албан бус алт олборлогчдын асуудлаар хуулийн төсөл боловсруулах, тэдний хөдөлмөрийн аюулгүй байдал, тэргүүн туршлагаар гарын авлага тараах, хөдөлмөр эрхлэх өөр арга зам, мөнгөн усны хор уршгийн талаар сургалт хийх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлжээ. Уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин, иргэдийн эрүүл мэндэд үзүүлж байгаа сөрөг нөлөөнд ихэд санаа зовдог байна. Харин 2000 оноос хойш энэ чиглэлээрх хүмүүсийн мэдлэг мэдээлэл сайжирсныг тэмдэглэж байна. Энэ оны 6 сард Албан бус алт олборлогчдын талаар тайлан гаргах юм байна.

НҮБ-ын Хүүхдийн Сан Уул уурхайн үйл ажиллагаанаас эмэгтэйчүүд хүүхдийн эрх зөрчигдөж, албан бус алт олборлогчдын хүүхдүүд сургуульд сурах, хөгжих боломжгүй байгаад их санаа зовнидог байна. Хэдийгээр энэ асуудлаар тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлээгүй байгаа боловч ОУХБ-ын энэ чиглэлийн хөтөлбөрт тэдний хүсэлтээр тусламж үзүүлдэг байна.

УУЛ УУРХАЙ, БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАР ДАХЬ ОЛОН УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ТУРШЛАГЫГ МОНГОЛ УЛСЫН ПРАКТИКТАЙ ХАРЬЦУУЛСАН НЬ

Доорхи хүснэгтээр Монгол улсын уул уурхайн хөгжлийн зохицуулалт олон улсын шилдэг туршлагатай хэрхэн нийцэхгүй байгааг үзүүлэв. Энэ нь мэдээллийн эрх чөлөө, шийдвэр гаргахад холбогдох орон нутгийн иргэдийн оролцоо, шүүхэд хандах боломж зэрэг олон салбарт ажиглагдаж байна. Мөн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийх, лиценз эзэмшигчийн санхүү, техникийн чадвартай холбоотой процедур, хэрэглэж болох

шилдэг технологи, агаар усны чанар, газрыг нөхөн сэргээх, барьцаа хөрөнгө, уурхайг хэрхэн хаах шаардлагуудтай ч нийцэхгүй байгаа ажээ. Түүнчлэн лицензийг шилжүүлэх, хүчингүй болгох монгол улсын хууль дүрэм нь байгаль орчинд ээлтэй биш байна. Эцэст нь хамгийн гол асуудал бол Монгол орны одоогийн шаардлагууд нь тогтмол, шударгаар хэрэгжихгүй байгаа явдал юм.¹⁰

		Олон улсын шилдэг туршлага	Монгол улсын өнөөгийн туршлага
1. Лицензтэй холбоотой шийдвэр гаргалт			
1.1.	Мэдээллийн эрх чөлөө	Аливаа төрлийн лицензийн өргөдөл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлан, гарсан шийдвэр зэргийг вэб сайтуудад байрлуулж олон нийтэд ил тод байлгадаг, шалгах, хувиан авахад хямд үнээр албан ёсоор чөлөөтэй өгөх	Лицензийн өргөдлүүд, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны төлөвлөгөө зэрэг холбогдох баримт бичгүүд нууц, харин эцсийн шийдвэр нь олон нийтийн мэдээлэл болдог
1.2.	Олон нийтийн оролцоо	Лицензийн өргөдлийн талаар олон нийтэд зарлаж, олон нийтэд, иргэдэд уг өргөдөлтэй холбоотой саналаа өгөх боломжийг бүрдүүлэх, олон нийтийн хэлэлцүүлгийг ихээхэн хэмжээний байгаль орчны нөлөөлөл үзүүлэх, шинэ бодлого явуулах уул уурхайн төслүүдийг хэрэгжүүлэхэд зорион байгуулах үйлдвэр, ажлаа олон нийтийн хэлэлцүүлгийн үед гарсан өргөдлийн санал, шийдлэх ухааны үндэслэл, зэргийг шийдвэр гаргахад заавал анхаарах	Өргөдөлтэй холбоотой олон нийтэд зарлах, мэдэгдэх, олон нийт, иргэд саналаа өгөх боломж, олон нийтийн хэлэлцүүлэг байхгүй. Лиценз олгох шийдвэрийг олон нийтийн оролцоогүйгээр гаргадаг
1.3.	Шүүхэд хандах боломж	Хохирсон иргэд, тухайн асуудлаар ажилладаг ТББ лиценз олгох үйл явцад оролцох, хэрвээ хууль зөрчсөн үйлдэл илэрвэл шүүхэд гомдол гаргах эрх зүйн боломжтой,	Хохирсон иргэд лицензтэй холбоотой шүүхэд гомдол гаргаж болно. Гэхдээ энэ нь маш ховор байна. Энэ боломж ТББ-уудад байхгүй

¹⁰ Уг харьцуулалтад зорион байгуулах үйлдвэр, ажлаа олон нийтийн хэлэлцүүлгийн үед гарсан өргөдлийн санал, шийдлэх ухааны үндэслэл, зэргийг шийдвэр гаргахад заавал анхаарах

Zillman et al., "Global Mining Trends, 2002: A Great Ground: Mining, Minerals, and Sustainable Development: An International Institute for Mining and Development, Earthscan Publications Ltd., London and Sterling, VA; "Hard Rock Mining: State Approaches to Environmental Protection", J. McElfish Jr. et al., Environmental Law Institute, 1996; "Mineral Exploration, Mining and Aboriginal Community Engagement: A Guidebook Report of the Workshop on Indigenous Peoples and Mining Minerals and Sustainable Development", World Business Council for Sustainable Development and I.T.E.D., Perth, Australia

1.4	Орон нутгийн иргэдийн оролцоо	Канад, Австрали зэрэг орнуудад уугуул иргэд уул уурхайн компаниудтай оролцооны /үр ашгийн/ гэрээг хийх хэлэлцээ хийдэг. Уг гэрээнд тухайн уурхайд ажиллах орон нутгийн иргэдийн тоо, сурч боловсрох, хөгжих боломжууд, хамт олныг хөгжүүлэх, сан, байгаль орчны хяналт, уг гэрээг байгуулах хэлэлцээг хийх, мониторинг хийх, гэрээг хэрэгжүүлэх зардлыг компани хэрхэн гаргах зэргийг тусгадаг.	Орон нутгийн хамт олны оролцоо нь сумын засаг даргын байгаль орчны төлөвлөгөөг хэлэлцэх, ус, газар ашиглах зөвшөөрлөөр хязгаарлагдана.
2.	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ (БОНУ)	БОНУ-г лиценз олгох процессын хэсэг болгон бэлтгэж, батлуулдаг. Энэ процесст иргэд оролцон саналаа хэлэх боломжтой. БОНУ-ний үнэн зөвийг шүүхээр тогтоодог.	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг уул уурхайн компаниуд өөрийн сонгож авсан компаниг хөлслөн хийлгэх бөгөөд уг үнэлгээнд олон нийтийн санал, зөвлөмж, оролцоо байхгүй, үнэн зөв байдлыг шүүх хянан үздэггүй.
3. Холбогдох хууль, дүрэм			
3.1	Техник, санхүүгийн чадавх үзүүлэх	Лиценз авахаар өргөдөл гаргагчаас байгаль орчны хуулийг зөрчихгүй, нөхөн сэргээлтийг шаардлагын дагуу явуулах техник, санхүүгийн чадавх харуулахыг шаарддаг	Уг асуудалтай холбоотойгоор өргөдөл гаргагч нь техник, санхүүгийн чадавх үзүүлэх шаардлагагүй
3.2	Хамгийн шилдэг технологи хэрэглэх	Лицензийг олгохдоо уул уурхайн компаниудаас байгаль орчны нөлөөллийг хянах, хамгийн үр ашигтай практик, шилдэг технологийг шаарддаг	Лиценз эзэмшигч нь шилдэг технологийг хэрэглэх шаардлагагүй
3.3	Агаар усны чанарыг хадгалах	Уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа орчны усны чанарыг хадгалах, бохирдлоос сэргийлэх зорилготой усны хүчиллэг, булингар, ууссан хүчил төрөгч гэх мэт үзүүлэлтийг хангах стандарт гарган уул уурхайн компаниудад мөрдүүлдэг. Мөн тухайн орчны агаарт үүнтэй ижил төрлийн стандарт мөрдүүлнэ	Агаар, усны чанарын стандарт мөрддөггүй
4.	Нөхөн сэргээх үйл ажиллагаа	Уурхайн үйл ажиллагаа явуулж байх үед, хар шороон хучлага, ургамалжуулалт зэрэг биологийн нөхөн сэргээлтийг зэрэг хийх, түүнчлэн ургамалжилт, биологийн нөхөн сэргээлтийг ургамлын ургах чадварт мониторинг хийх байдлаар хянахыг шаарддаг.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө шаарддаг боловч хэрэгжих нь ховор; нөхөн сэргээлтийг хар шороон хөрс, биологийн нөхөн сэргээлтгүй зөвхөн техникийн нөхөн сэргээлтээр хязгаарлаж байна.

5.	Барьцаа шаардах	Нөхөн сэргээлтийн нарийн тооцоолсон бүх зардлыг төлөх барьцаа болон бусад аюулгүй байдлыг хангахыг шаарддаг.	Нөхөн сэргээлтийн зардлын 50%-тай тэнцэх хөрөнгийг барьцаалахыг хуулиар шаардана. Гэвч амьдралд нөхөн сэргээлтийн зардлыг багаар тооцдог бөгөөд үүний 50%-аас бага хөрөнгийг холбогдох дансанд байршуулдаг ба зарим тохиолдолд хийгдэхгүй
6.	Уурхайг хаах	Уурхайг түр болон бүрмөсөн хаахдаа бохирдсон хөрс, уснаас урсан гадаргын болон гүний усыг бохирдуулахаас урьдчилан сэргийлэхийг хатуу шаарддаг.	Түр зуурын болон улирлын шинжтэй уурхайг хаахад хэрэгжүүлэх хатуу шаардлага байхгүй, бүрмөсөн хаасан тохиолдолд ч хатуу мөрдөх шаардлага байхгүй.
7	Лиценз хүчингүй болгох	Лиценз хүчингүй болгох нөхцөлд байгаль орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх хангалттай хамгаалалт хийгээгүй, байгаль орчны дүрэм журмыг дагаж мөрдөөгүй, шаардлагатай нөхөн сэргээлтийг хийгээгүй зэрэг орно	Лиценз хүчингүй болгох нөхцөлд хангалттай хамгаалалт хийгээгүй, байгаль орчны дүрэм журмыг дагаж мөрдөөгүй, шаардлагатай нөхөн сэргээлтийг хийгээгүй зэрэг орохгүй
8	Лиценз шилжүүлэх	Лицензийг байгаль орчин, нөхөн сэргээлтийн шаардлагыг хангаагүй нөхцөлд шилжүүлж болохгүй	Лицензийг байгаль орчин, нөхөн сэргээлтийн шаардлагыг хангаагүй нөхцөлд ч шилжүүлж болно

ДүГНЭЛТ, САНАЛ Зөвлөмж

Орон нутгийн иргэд, малчид өөрсдийнх нь газар нутаг дахь уурхайн үйл ажиллагаанаас тодорхой үр шим хүртэхгүй байна. Монгол дахь алтны уурхайн үр ашиг муутай техник, технологи, байгаль орчны нөхөн сэргээлтийг шаардлагын дагуу хийхгүй байгаагаас бэлчээр сүйтгэх, гол мөрөн, горхи шандны ус бохирдох, ширгэх зэргээр байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байна.

Байгаль орчинд учирсан сөрөг нөлөөнөөс малчдын иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгэм,соёлын олон эрх зөрчигдөж байна. Уул уурхайн хайгуулын болон ашиглалтын лиценз авах, газар, усны зөвшөөрөл олгох, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг хянахад нутгийн иргэдийн оролцоо хангагдахгүй байна. Монгол улсын хууль тогтоомжоор малчдын эрхийг зохих ёсоор хамгаалаагүй бөгөөд Засгийн Газрын ашигт малтмалын салбарыг хөгжүүлэх бодлогод тэдний эрх ашгийг анхаарсангүй. Монгол улсад байгаль орчинд учирсан хохирлыг үнэлэх, хохирогчдод нөхөн төлбөр олгох туршлага алга. Түүнчлэн хүний эрхийн зөрчлийг шүүхээр шийдэх практик тогтоогүй бөгөөд хохирсон хүмүүс ихэнхдээ хууль эрх зүйн мэдлэггүй бөгөөд шүүхэд итгэх итгэлээр муу байна.

Малчид орон нутгийн иргэд эрхээ хамгаалахаар Монгол улсын янз бүрийн хэсэгт иргэний хөдөлгөөн байгуулжээ. Гэвч тэд зохион байгуулалтаар сул, хууль эрхийн мэдлэггүй, уул уурхайн компани, орон нутгийн удирдлагатай үр ашигтай ажиллах туршлагагүй байна. Иймээс эдгээр төрийн бус байгууллагын хүний эрх, тогтвортой хөгжлийн зарчмыг хэрэгжүүлэх чадавхыг сайжруулахад нэн тэргүүнд анхаарах хэрэгтэй.

Гар аргаар алт олборлогчдын үйл ажиллагааг албан ёсны болгох эрх зүйн статустай болгоогүй учраас тэдний хүний эрх онцгой ихээр зөрчигдөж байна. Тэд алтны компани, цагдаа, орон нутгийн захиргаа, нутгийн иргэд зэрэг олон талын дарамтан доор, зөрчлөөр дүүрэн, хүний эрхэм чанараа хадгалж чадахгүй нөхцөлд амьжиргаагаа залгуулж байна.

Лицензийн асуудлаар шийдвэр гаргах, байгаль орчны шаардлагын биелүүлэлт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг хянах асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох эрхийг хамгаалах, эдгээр эрхийг зөрчсөн тохиолдолд шүүхээр шийдүүлэх эрхийг баталгаажуулахын тулд олон улсын тэргүүний туршлагыг нэвтрүүлэх хэрэгтэй.

Монгол улсын уул уурхайн үйл ажиллагаанд хэрэглэж байгаа хуулийн доголдлыг арилгахын тулд байгаль орчны асуудлаар тавигддаг шаардлагыг чангаруулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх тухай өөрчлөлтийг Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хуульд хийх. Ялангуяа, ил тод байдлыг нэмэгдүүлэх өөрчлөлт нь лицензийн өргөдөл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон холбогдох бусад материалд онцгой хамаатай юм. Ач холбогдлоороо чухал лиценз олгох асуудлаар олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулан, санал сэтгэгдлээ хэлэх боломжоор хангах замаар олон нийтийн оролцоог зөвшөөрдөг, дэмждэг практикийг нэвтрүүлэх хэрэгтэй. Орон нутгийн удирдлага лицензийн үйл ажиллагаанд шаардлагатай зөвшөөрлийг иргэдийн нийтийн болон төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлсний дараа олгодог, иргэд, уурхайн компанийн хооронд оролцооны/үр ашгийн гэрээ хийх эрхийг олгодог байх шаардлагатай.

Асуудлыг шүүхээр шийдвэрлэх боломжийг сайжруулахын тулд шинжлэх ухааны үнэлгээ, дүгнэлтийг нотлох баримтаар хэрэглэх, түүнийг шүүхийн шийдвэр гаргахдаа хэрэглэх явдлыг сайжруулах нь чухал байна.

Сонирхсон төрийн бус байгууллагууд, иргэдэд лиценз олгох шийдвэр гаргахад оролцох, эсрэг шийдвэр гаргуулахаар дээд байгууллага болон шүүхэд хандах эрх олгох хэрэгтэй. Байгаль орчныг хамгаалах, газар болон экосистемийг нөхөн сэргээх зориулалтын хуулийн хэрэгжилтийг сайжруулах. Уурхайн үйл ажиллагаа явуулах лицензийг гол мөрөн, булаг шандны эх, ховордсон ан амьтан, ургамалтай газар, түүх дурсгалын болон уугуул иргэд олноороо суурьшдаг газар эсхүл тахиж шүтдэг газар олгохгүй байх.

Байгаль орчны шаардлагыг биелүүлээгүй, байгаль орчныг нөхөн сэргээх техникийн болон санхүүгийн чадавх байхгүй тохиолдолд лиценз олгодоггүй, хугацааг сунгадаггүй, хэн нэгэнд шилжүүлдэггүй байх. Түүнчлэн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг хангаагүй бол лицензийг цуцалдаг байх.

Энэхүү баримт бичгийн явцад Монгол улсын Ашигт малтмалын тухай хууль болон Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хуулийг лицензийн асуудлаар гаргах шийдвэрт иргэдийн оролцоог хангах, байгаль хамгаалах зэрэг асуудлаарх олон улсын тэргүүний туршлагатай зохицуулан өөрчлөх саналыг боловсруулсан. Энэ өөрчлөлтийн саналыг Улсын Их Хурлын Санхүү эдийн засгийн байнгын хороо, улсын их хурлын бусад гишүүдэд гардуулна.

Монгол улсын уул уурхайн салбарын урт хугацааны тогтвортой хөгжлийг хангахын тулд бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид байгаль орчин болон хүний эрх хамгаалах зарчмыг Монгол улсын уул уурхай, ашигт малтмалын хөгжилтэй холбоотой хууль, бодлого, хөтөлбөрт нэвтрүүлж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Эс тэгвээс Монгол улс үндсэн хуулийн ардчиллыг хөгжүүлэх заалтыг хэрэгжүүлэх, Мянганы хөгжлийн зорилтыг биелүүлэх боломжгүй болно.

ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ, БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛАХ, ХАМТЫН ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭР ХИЙХ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2005 онд ХЭҮК-оос МҮЭ-үүдийн, салбарын болон аймгуудын ҮЭ-ийн холбоод, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо (МАОЭНХ)-той хамтран 20 аймгийн 42 сум /Увс аймаг ороогүй/, нийслэлийн 9 дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй 315 аж ахуйн нэгж, байгууллагад эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах, хамтын гэрээ, хэлэлцээр хийх эрхийн төлөв байдлыг шалгаж судалсан юм.

Энэхүү шалгалт судалгааны явцад төрийн захиргаа, эрүүл мэнд, соёл, боловсрол, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын нийт 1085 хүнээс тодорхой асуудлаар асуумж авч, дүгнэлт хийв.

Эдгээр судалгаанд хамрагдсан хүмүүсийн 65,5 хувь нь аймгийн төвд, 14.3 хувь нь суманд, үлдсэн 20.2 хувь нь нийслэлийн 9 дүүрэгт оршин сууж ажилладаг байршилтай байв.

Дээрх шалгалт-судалгаанд хамрагдсан 315 аж ахуйн нэгж, байгууллагын 80 нь буюу 25.4 хувь нь нийслэлд, үлдэх 235 нь буюу 74.6 хувь нь аймгуудад үйл ажиллагаа явуулдаг. Энэхүү 315 аж ахуйн нэгж, байгууллагын 70928 ажиллагчдын 29243 нь буюу 41.2 хувь нь ҮЭ-ийн гишүүн байгаа бөгөөд ҮЭ-ийн хороотой 202 аж ахуйн нэгж, байгууллага байна. Өөрөөр хэлбэл, шалгалт судалгаанд хамрагдсан дээрх аж ахуйн нэгж, байгууллагын 64.1 хувь нь ҮЭ-ийн анхан шатны байгууллагатай байв.

НЭГ. ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ, БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛАХ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛСАН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦИ БА ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТЭДГЭЭРИЙН УЯЛДАА

1.1. Хөдөлмөр эрхлэлтийн салбарт ажилчид, ажил олгогчдын эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулах болон хамтын гэрээ хэлэлцээр хийх эрх чөлөөг олон улсын эрх зүйгээр хамгаалан баталгаажуулсан байдаг.

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал (ХЭТТ)-ын 20 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт (ИУТЭОУП)-ын 22 дугаар зүйл, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт (ЭЗНСЭОУП)-ын 8 дугаар зүйлүүдэд эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулах эрхийн талаар тодорхой тусгагдсан.

Хөдөлмөрийн салбарт хүний үндсэн эрхийг хамгаалахад Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-аас батлан гаргасан гэрээ, конвенцууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулах, хамтын

гэрээ, хэлэлцээр хийх эрх чөлөөг ОУХБ-ын дараах гэрээ конвенциор баталгаажуулжээ. Үүнд:

- Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай 1948 оны 87 дугаар конвенци
- Зохион байгуулах, хамтын хэлэлцээ хийх эрхийн тухай 1949 оны 98 дугаар конвенци
- Үйлдвэрийн газарт ажилчдын төлөөлөгчдийн эрхийг хамгаалах болон тэдэнд олгогдох бололцооны тухай 1971 оны 135 дугаар конвенци
- Төрийн албан дахь хөдөлмөрийн харилцааны тухай 1978 оны 151 дүгээр конвенци
- Хамтын хэлэлцээний тухай 1981 оны 163 дугаар конвенци
- Мөн дээрх гэрээ, конвенцийн заалттай холбоотой дараах зөвлөмжийг гаргасан байна. Үүнд:
- Хамтын хэлэлцээрийн тухай 1951 оны 91 дүгээр зөвлөмж
- Үйлдвэрийн газарт ажилчдын төлөөлөгчдийн эрхийг хамгаалах болон тэдэнд олгогдох бололцооны тухай 1971 оны 143 дугаар зөвлөмж
- Төрийн албан дахь хөдөлмөрийн харилцааны тухай 1978 оны 159 дүгээр зөвлөмж
- Хамтын хэлэлцээний тухай 1981 оны 163 дугаар зөвлөмж зэрэг болно.

1.2. Монгол улсын Үндсэн хууль /1992 он/ болон Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль /1991 он/, Төрийн бус байгууллагын тухай хууль /1997 он/, Хөдөлмөрийн тухай хууль /1999 он/, Иргэний хууль /2002 он/, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /2003 он/ болон бусад холбогдох хууль тогтоомжоор ажилчид, ажил олгогчдын үүсгэл санаачилгын байгууллагыг байгуулах болон үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож өгсөн. Тухайлбал, Үндсэн хуулиар иргэний нийгмийн болон өөрийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс байгууллага байгуулах, эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулсан. Мөн Төрийн бус байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлд: “Монгол улсын иргэн, төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд, төрийн байгууллагаас зөвшөөрөл авахгүйгээр өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс дангаараа буюу хамтран төрийн бус байгууллага байгуулах эрхтэй. Төрийн бус байгууллага байгуулах иргэдийн эрхийг хууль бусаар хязгаарлахыг хориглоно. Төрийн бус байгууллагад албадан оруулахыг хориглоно” гэж заасан байна. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлд: “Иргэд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор аливаа зөвшөөрөл авалгүй, гагцхүү өөрсдийн сайн дурын үндсэн дээр ямар нэг ялгаваргүйгээр ҮЭ-д чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхтэй. ҮЭ-д гишүүнээр элсэх буюу гишүүнээс гарахыг тулган шаардаж болохгүй” гэжээ. Хууль тогтоомжоор хөдөлмөрийн харилцаанд оролцогчид эвлэлдэн нэгдэх, байгууллага байгуулах эрхээ ҮЭ,

ТББ байгуулах замаар эдлэх боломжийг баталгаажуулж өгсөн. Өнөөгийн практикт ихэвчлэн ажил олгогчдын хувьд ТББ байгуулах, ажилчдын хувьд ҮЭ байгуулах замаар эвлэлдэн нэгдэж, эрх ашгаа хамгаалах үйл ажиллагаа явуулж байна. Ажилчид, ажил олгогчдын эвлэлдэн нэгдэх эрхийн хүрээнд дараах асуудал анхаарал татаж байна. Үүнд:

- Төрийн зарим албаны албан хаагчдын ҮЭ-д эвлэлдэн нэгдэх эрх
- Төрийн байгууллагын удирдах албан тушаалтны эвлэлдэн нэгдэх эрх
- ҮЭ байгуулах, гишүүнээр элсэх боломжгүй субъектийн асуудал

1.3. ОУХБ-ын 87 дугаар конвенци нь тухайн улсад ажиллаж буй гадаадын харьяат ажилчид, ажил олгогчдын хувьд ч хамаарах юм. Төрийн бус байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6-д: “Монгол улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор байнга оршин суугаа гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүс Монгол улсын хууль, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуульд заасан журмын дагуу төрийн бус байгууллага байгуулах буюу төрийн бус байгууллагад эвлэлдэн нэгдэж болно” гэж заасан. Түүнчлэн МАОЭНХ-ны дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1-д: тус байгууллагын дүрмийг хүлээн зөвшөөрсөн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн ажил олгогч, хөрөнгө оруулагчид гишүүнээр элсэж болохыг заажээ.

1.4. 87 дугаар конвенцийн хүрээнд баталгаажигдсан ҮЭ-ийн байгууллагын үндсэн эрхийн нэг бол үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс оролцохоос хамгаалагдах эрх юм. Үндэсний хууль тогтоомжийн хүрээнд энэ эрхийг баталгаажуулж, хамгаалах үр дүнтэй механизм, хариуцлагын тогтолцоо бий болгох үүргийг конвенцид оролцогч улсууд хүлээсэн. Үйлдвэрчний эвлэлийн эрхийн тухай хуульд заасан ҮЭ-үүдийг захиргааны журмаар тараах, үйл ажиллагааг нь зогсоох, мөшгөн хавчих зэргээр үйл ажиллагаанд нь саад учруулах болон байгууллагын захиргааны удирдах албан тушаалтан ҮЭ-ийн сонгуульд ажил гүйцэтгэхийг хориглосон, мөн ҮЭ-ийн өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах тухай заалт нь ҮЭ-ийн үйл ажиллагаанд ажил олгогч хөндлөнгөөс оролцохоос хамгаалах зорилготой юм. Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-д заасан төрөөс хараат бус байх зарчим ч дээрх эрхтэй нягт уялдаатай билээ. Байгууллагын энэхүү эрхэд халдсан этгээдэд хариуцлага ноогдуулах тухай заалт Хөдөлмөрийн тухай хуульд бий. Мөн уг хуулийн 141 дүгээр зүйлийн 141.1.10-д хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, ажил хаялт зохион байгуулах, ажлын байрыг түр хаах, санал зөрүүтэй асуудлаараа талууд санал солилцох, чөлөөтэй сонголт хийхэд нь хөндлөнгөөс оролцсон иргэн, албан тушаалтанд Байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох хэлбэр нь энэ зүйлд заасан тохиолдлоос хавьгүй олон төрөл хэлбэртэй байж болох юм. Тэрчлэн байгууллагын ялангуяа, ҮЭ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ажил олгогчийн зүгээс хөндлөнгөөс оролцох тохиолдол практикт нилээдгүй байдаг боловч

байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохоос хамгаалагдах эрхийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар Монгол улсын хууль тогтоомжид заасан хариуцлагын тогтолцоо хангалттай биш байна.

1.5. Эвлэлдэн нэгдэхийн эсрэг алагчлах үйлдлээс хамгаалуулах эрх хангагдахад ҮЭ-ийн сонгуульт ажилтны хувьд эрхээ эдлэх нэмэлт баталгааг үндэсний хууль тогтоомжоор тогтоосон байх нь чухал. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлд болон Хөдөлмөрийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8-д хэдийгээр ийнхүү ҮЭ-ийн сонгуульт ажилтны эрхээ эдлэх нэмэлт баталгааг зааж өгсөн боловч энэхүү эрхийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага тодорхой биш байна.

ХОЁР. ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛД ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ БА ҮЭ-ИЙН БАЙГУУЛАГА БАЙГУУЛАХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

2.1. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлд: Иргэд хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор аливаа зөвшөөрөл авалгүй гагцхүү өөрсдийн сайн дурын үндсэн дээр ямар нэг ялгаваргүйгээр ҮЭ-д чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхтэй.

- Үйлдвэрчний эвлэлд гишүүнээр элсэх буюу гишүүнээс гарахыг тулган шаардаж болохгүй
- ҮЭ-ийн гишүүн мөн эсэхтэй холбогдуулан иргэдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах буюу тэднийг ялгаварлан гадуурхахыг хориглоно гэж ҮЭ-д эвлэлдэн нэгдэх эрхийн үндсийг тодорхойлон заасан байдаг.

МҮЭХ-ны 2004 оны бүтэн жилийн мэдээгээр МҮЭ-ийн нийт 184118 гишүүн байгаагаас аймгуудад 103619 гишүүн, салбарын холбоодын дүнгээр 80499 гишүүн байна.

1990 онд МҮЭ-ийн гишүүдийн тоо 624800 байсан бол 15 жилийн дараа буюу 2004 онд 184118 болж 3.4 дахин багассан нь дараах үндсэн шалтгаантай.

- Өмнөх тогтолцооны үед ҮЭ-д эвлэлдэн нэгдэх эрх сайн дурын гэх боловч хэрэг дээрээ ажилчин, албан хаагч бүр ҮЭ-ийн гишүүн байх ёстой гэж тэднийг бүртгэн батлах олгож байсан.
- Монгол улс 1990-ээд оноос зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж дангаар ноёрхож байсан улсын үйлдвэрийн газруудыг эрчимтэй хувьчилж, тэнд ажиллаж байсан ихэнх ажиллагсад ажилгүй болж тэд аяндаа ҮЭ-ийн гишүүн биш болсон. Тэрчлэн үйлдвэр, үйлчилгээний байгууллагуудыг хувьчилж авсан ихэнх ажил олгогч эзэд ҮЭ-ийн байгууллага байхыг хүсээгүй буюу тэдгээрийн үйл ажиллагааг дэмжээгүйгээс ҮЭ-ийн байгууллага тарсан.

- Шинээр үүсэн байгуулагдаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсад ҮЭ-д эвлэлдэн нэгдэхийн ач холбогдлыг ойлгож, эрхээ хэрэгжүүлэх талаар санаачилга гаргадаггүй.

Судалгаанд хамрагдсан 1085 хүний 19,2 хувь нь буюу арван хүн тутмын хоёр нь ҮЭ-д элсэх хүсэлтэй гэж хариулсан, энэ бол бага тоо биш юм.

ҮЭ-д элсэх хүсэлтэй болон хүсэлгүй байгаа хүмүүсээс ҮЭ-д элсэхэд хэн саад болдгийг сонирхон судлахад тухайн хүн өөрөө санаа тавьдаггүй, ажил олгогч эзэд буюу дарга, захирал болон удирдлагаас шалтгаалж ҮЭ-д элсэхийг төдийлөн шамддаггүй гэжээ. Зарим албан байгууллага, хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн газар ҮЭ байхгүй тул гишүүнээр элсэх боломжгүй гэж цөөн тооны хариулагч үзсэн байна.

Үүнээс гадна МҮЭОХ-ноос ҮЭ-ийн гишүүдийн бүртгэлийг шинэчлэн нэрчилсэн бүртгэлийн сан байгуулах замаар ҮЭ-ийн гишүүнчлэлийг МҮЭ-үүдийн нийтлэг дүрмийг хүлээн зөвшөөрч татвараа төлсөн гишүүдээр тооцох, гишүүдийн тооны давхардлыг арилгах, гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн хэлбэр, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилах зэргээр мэдээллийн багтаамжийг өргөжүүлэх, боловсронгуй болгох, арга хэмжээнүүдийг авч байгаа нь ҮЭ-ийн гишүүдийн тоонд нөлөөлсөн байна /МҮЭХ-ноос 2000-2004 онд хийсэн ажлын тайлан, 2004 он, номын 1 дүгээр тал/.

2.2. МҮЭ-ийн нийт гишүүд 2004 оны байдлаар 184118 байхад Үндэсний статистикийн газрын 2004 оны бүтэн жилийн тайлан мэдээгээр улсын хэмжээнд 950.5 мянган ажиллагсад байна. Үүнээс үзэхэд МҮЭ-ийн нэг гишүүнд ҮЭ-ийн гишүүн бус 5 ажиллагч ноогдож байна.

Зах зээлийн өнөөгийн нөхцөлд ажиллагсад ҮЭ-д эвлэлдэн нэгдэх замаар хөдөлмөрийн харилцаанд оролцоходоо эрхээ хамгаалуулах явдал нэн чухал бөгөөд хөдөлмөрийн энэхүү харилцаанд хөдөлмөрлөх болон түүнтэй холбоотой бусад эрхээ ажилчид хамгаалуулах гол баталгааны нэг бол ҮЭ-д эвлэлдэн нэгдэх эрхээ сайн дураараа зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх явдал юм.

Одоо төрийн захиргааны төв, орон нутгийн ихэнх байгууллагын дэргэд ялангуяа, төрийн захиргааны төв байгууллага болох яамд, агентлагуудын дэргэд ҮЭ-ийн байгууллага үндсэндээ байхгүй байна.

Төрийн үйлчилгээний байгууллагуудын дэргэд ҮЭ-ийн байгууллагууд ажиллаж байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн сургууль, эмнэлэг, цэцэрлэг, соёл урлагийн байгууллагуудын дэргэд ҮЭ-ийн хороо, бүлгүүд бий.

2.3. Хэвийн сайн ажиллаж байгаа ҮЭ-ийн байгууллага цөөнгүй байна. Төр, засгийн үйлчилгээний авто баазын дэргэдэх ҮЭ-ийн хороо нь баазын нийт ажиллагсдын хөдөлмөрлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийг хангах талаар хамтын гэрээнд тодорхой асуудлыг тусган ажил олгогчтой хамтран муугүй ажилладаг нь шалгалт судалгааны үед ажиглагдсан.

Тэрчлэн нийслэлийн СХД-ийн 10 жилийн 42 дугаар дунд сургууль, Булган аймгийн Хишиг-Өндөр сумын 10 жилийн сургуулийн дэргэдэх ҮЭ-ийн хороо сургуулийн захиргаанаас багш, ажилчдын цалин хөлс, нэмэгдлийг бүрэн олгохгүй хохироосныг зохих тэмцэл хийж шаардлага тавьж байсны дүнд хохирлыг арилгуулж хамтын гэрээний заалтыг биелүүлэхийн төлөө анхаарч ажилладаг байна.

Ажиллагсад ҮЭ-ийн гишүүдийнхээ хөдөлмөрлөхтэй холбоотой эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахын төлөө уйгагүй тэмцдэг, санаачилгатай ажилладаг, хуульд заасан эрхээ бүрэн хэрэгжүүлж, ажил олгогчдод санал шаардлага тавьж хамтран үр бүтээлтэй ажилладаг ҮЭ-ийн байгууллага, сонгуультнууд цөөнгүй байна.

- Архангай аймгийн Нэгдсэн эмнэлгийн захиргаа ажиллагсдын цалин хөлсийг олгохгүй, 5-6 сараар саатуулж байсныг тэндхийн ҮЭ-ийн хороо, шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргаж 3.8 сая төгрөгийн алдангийг ажилчдын цалин дээр нөхөн олгуулж байжээ. Мөн Багануур дүүргийн дулааны цахилгаан станцын захиргаа 40 хүнийг цомхотголоор халах гэж байсныг ҮЭ-ийн хороо, Станцын захиргаатай хэлэлцээр хийж зөвшилцөн, 9 хүнийг зайлшгүй шалтгаанаар цомхотголоор зохих журмын дагуу хөдөлмөрийн гэрээг цуцалж, бусад 30 гаруй хүнийг хэвээр үргэлжлүүлэн ажиллуулж чаджээ.

2.4. Аж ахуйн нэгж, байгууллагууд, ажил олгогч эздийн зүгээс ажиллагсдын ҮЭ-д эвлэлдэн нэгдэх эрхээ эдэлж хэрэгжүүлэхэд аятай боломж олгох, дэмжлэг үзүүлэх хөдөлгөөн өрнүүлэхийг МҮЭХ, аймаг нийслэлийн ҮЭ-ийн холбоодоос дэмжиж, сургалт сурталчилгааны болон бусад зохион байгуулалтын үр нөлөөтэй арга хэмжээ авсан нь үр дүнгээ өгч байна.

- Архангай аймгийн ҮЭ-ийн холбооноос 2003 онд “Үйлдвэрчний эвлэл-Хувийн хэвшил” сэдэвт хөтөлбөр гарган хувийн хэвшилд ажиллагсдад хууль зүйн туслалцаа үзүүлэх замаар тэднийг ҮЭ-д эвлэлдэн нэгдэж, эрх ашгаа хамтран хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл боломжийг бүрдүүлэх, ҮЭ-ийн зохион байгуулалтад хамруулан тэдний сайн дурын үндсэн дээр ҮЭ-ийн анхан шатны хороо байгуулж ажиллахад дэмжлэг үзүүлэхийг зорилго, чиглэлээ болгон үр нөлөөтэй ажил зохиож байна.
- Завхан аймгийн Их-Уул сумын ҮЭ-ийн холбоо нь аймгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг холбоонд тооцогддог нийт 120 гишүүнтэй, малчин 15 өрхийг ҮЭ-ийн гишүүнээр элсүүлсэн.

2.5. Гэвч орон нутгийн төрийн захиргааны зарим байгууллага ҮЭ-ийн байгууллагатай хамтарч ажиллах, тэдний ажилд дэмжлэг үзүүлэхийн оронд тавьсан санал, шаардлагад нь хариу өгөхгүй байх, үйл ажиллагааг нь хааж боох, зогсоох хүртэл арга хэрэглэдэг байна.

- Зорчигч тээврийн үйл ажиллагаа явуулдаг 30 гаруй жолооч ажлын байргүй болсон асуудлыг шийдвэрлүүлэхээр Дундговь аймгийн ҮЭ-ийн холбооноос 2005 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр аймгийн ИТХ, ЗД-д шаардлага өгсөн боловч 3 сар болоход шаардлагын хариуг өгөөгүй, мөн аймгийн төрийн санд байрлах ҮЭ-ийн хороодын дансыг хааж үйл ажиллагаанд нь хүндрэл учруулж байжээ /Дундговь аймгийн шалгалт судалгааны материалаас/.
- Өмнөговь аймгийн ХАА-н газар, Шуудан холбооны газар, Завхан аймгийн “Амьд ус трейд” ХХК зэрэг байгууллагууд ҮЭ-ийн гишүүдийн татварын мөнгийг байгууллагынхаа дансанд байршуулдаг учир ҮЭ-ийн байгууллагаас мөнгөө тухай бүр авч зарцуулахад нь бэрхшээл учирдаг байна.

Төв, орон нутгийн ҮЭ-ийн анхан шатны 188 байгууллагын сонгуультаас асуулга авахад 23 байгууллага буюу 11.7 хувь нь ҮЭ-ийн байгууллагын үйл ажиллагаанд ажил олгогч болон зарим байгууллага хөндлөнгөөс оролцож элдэв дарамт шахалт үзүүлдэг гэж хариулжээ. Мөн санал асуулгад хамрагдсан 1085 хүний 44 хүн буюу 4.1 хувь нь ҮЭ-ийн байгууллагаас ажиллагчдын эрх ашгийг хамгаалахад байгууллагын захиргаа буюу ажил олгогч эздээс бэрхшээл учруулдаг гэж хариулсан ба үүнийгээ дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд:

- Байгууллагын захиргаанаас ажилчдын тавьсан асуудлыг хүлээж авдаггүй бөгөөд санал бодлыг ойлгодоггүй, ажилтнуудын дунд буруу суртал хийлээ гэж зэмлэх буюу ажлаас хална гэж дарамталж, эсхүл дотоод журамтай нийцэхгүй гэдэг.
- Хамтын гэрээ байгуулахад саад хийдэг, ялангуяа хувийн хэвшлийн байгууллагад эл байдал их байдаг, дарамт үзүүлдэг, илүү цаг ажилласны хөлс олгодоггүй.
- Амралт, сувилалд явуулдаггүй, тусламж дэмжлэг, хөнгөлөлт үзүүлдэггүй хэмээн тус тус үзсэн байна.
- “Мах импекс” ХК-ийн үйл ажиллагаа жигдэрсэн үед 2500 гаруй ажиллагсад байдаг. Одоогоор ҮЭ-ийн гишүүн 200 гаруй байна. Гэтэл компанийн захирал “П” гэгч 2004 оны сүүлчээр ажил хүлээж аваад ҮЭ-ийн хорооны даргад ажил өгөөгүйн зэрэгцээ ҮЭ-ийн гишүүдийн татварыг цалингаас суутгадаг байсныг болиулсан. Түүгээр ч барахгүй захиралд ҮЭ-ийн үйл ажиллагааны талаар санал тавихад огт хүлээж аваагүй бөгөөд тэрээр би ҮЭ-ийн байгууллагад дургүй, ҮЭ-ийн хороотой хамтарч ажиллахгүй, хэрэв ажиллах юм бол ҮЭ-ийн хорооны даргын өрөөнөөс 1м2-ийг 10 ам.доллараар бодож түрээсийн хөлс авна. Утас телефоныг өөрийн мөнгөөр тавиул гээд утсыг нь тасалсан байна. Тэрчлэн гишүүдийн татварыг бэлнээр өөрөө хурааж ав гэсэн шаардлага тавьсны улмаас гишүүд нь татвараа өгөхгүй болж сүүлийн 2-3 сард татвараа хурааж чадаагүй тул ҮЭ-ийн хорооны

дарга цалингүй байсаар цаашид ажиллах боломжгүй болжээ.

Тус компанийн ҮЭ-ийн гишүүн зарим хүмүүстэй уулзахад нядалгааны үед осол их гардаг, бруцеллёзын халдвартай 100 гаруй хүн эмнэлгийн хяналтад байдаг. Жилд дунджаар 5-6 хүнд уг өвчин шинээр илэрдэг. Ажиллагсдын эрх их зөрчигддөг, энэ талаар тавьсан шаардлагыг одоогийн захирал хүлээн авдаггүй, ҮЭ-ийн хорооны даргыг цалин ч үгүй, ажил ч үгүй болгосон. Тус компанийн хувьд ҮЭ-ийн хороо үнэхээр хэрэгтэй. Аммиак байнга алдагдаж, нэг хэсэг хүмүүс хордож байна. Сул зогсолтын үед нөхөн олговор өгдөггүй, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг сул зогсолтын үед дэвтэр дээр бөглөж өгдөггүйн зэрэгцээ ажилчдаас хураасан шимтгэлийг даатгалын байгууллагад шилжүүлэхгүй байгаагаас эмнэлэгт хэвтэж эмчлүүлж чадахгүй хохирч байна гэсэн утгатай гомдол мэдүүлж байв /Төвийн багийн шалгалт судалгааны материалаас/.

- “Эрэл цемент” компанийн хувьд ҮЭ байгуулахаас эхлэн шинээр гишүүн элсэхэд болон түүний үйл ажиллагаанд оролцохыг байгууллагын удирдлагаас удаа дараа хориглож байсан бөгөөд одоо ч энэ үйл ажиллагаа үргэлжилж байна. ҮЭ-ийн сонгууль хүлээлгэж гишүүдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа идэвхтэн сонгуультныг удирдлагаас зөвшөөрөл аваагүй бол үйл ажиллагаа явуулж болохгүй гэсэн шахалт үзүүлдэг. Энэ мэтээр ҮЭ-ийн байгууллагын үйл ажиллагааг зогсоосон байна /Дархан-Уул аймгийн шалгалт, судалгааны материалаас/.

2.6. Өнөөгийн шилжилтийн нөхцөлд ҮЭ-д эвлэлдэн нэгдэх болон байгууллага байгуулах эрхийг хэрэгжүүлэхэд багагүй бэрхшээл, дутагдал тохиолдож байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна. Ялангуяа, ҮЭ-ийн анхан шатны байгууллагуудын тоо цөөрч байгаа нь дараах үндсэн шалтгаантай байна гэж үзлээ. Үүнд:

- Шинээр үүсэн байгуулагдсан хувийн хэвшлийн болон хамтарсан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагуудад ажиллагсад ҮЭ-д эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэх талаар санаачилга муутай, мөн тэдэнд зохион байгуулалт дутагдаж буйн зэрэгцээ ҮЭ-д эвлэлдэн нэгдэхийн ач холбогдлыг ойлгохгүй байгаагаас гадна эрх зүйн зохицуулалт, баталгаа хангалтгүй байна. МҮЭХ-ны Эрдэм шинжилгээ, сургалтын төвөөс 2002 он болон 2004 онд нийслэл, 8 аймгийн хэмжээнд судалгаа хийж 2002 онд 600 гаруй, 2004 онд 500 гаруй хүнээс тус тус авсан санал асуулгаар: ажилчид ҮЭ-д чөлөөтэй эвлэлдэн нэгдэж, сайн дураараа ҮЭ-ийн байгууллага байгуулахад ямар саад бэрхшээл учирч байна вэ гэсэн асуултад, 2002 онд 23.0 хувь нь, 2004 онд 30.2 хувь нь хууль, эрх зүйн зохицуулалт, баталгаа хангалтгүй, 2002 онд 54.0 хувь, 2004 онд 48.5 хувь нь хууль хэрэгжүүлэх явдал тааруу, 2002

онд 15 хувь нь, 2004 онд 12.0 хувь нь ажил олгогч эзэн таагүй ханддаг гэж тус тус хариулсан байна /Д.Цэндээ, “Хөдөлмөрлөх эрх, үйлдвэрчний эвлэл” 2005 он, 29 дэх тал/.

- Ажил олгогч эздийн зүгээс ажиллагсад ҮЭ-д эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэх боломж, нөхцөл олгохгүй байна. Канад улсын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Бороо гоулд” ХХК нь 500 шахам ажиллагсадтай, ажилчдын хөдөлмөрлөх эрхийг багагүй зөрчдөг тухай мэдээлэл байдаг. Тус компанийн хэсэг ажиллагсад ҮЭ-д эвлэлдэн нэгдэх эрхээ эдэлж, ҮЭ-ийн хороо байгуулах гэж хөөцөлдөж байсан ажилтныг ажлаас халсны улмаас ҮЭ-ийн хороо байгуулах боломжгүй болсон.
- Оросын хөрөнгө оруулалттай “Алтан Дорнод Монгол” ХХК 730 гаруй ажиллагсадтай бөгөөд үүний 300 шахам нь монгол ажилчид. Энд ажилчид ҮЭ-д эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэх боломж олгодоггүй байна. Жишээ нь: ... Бид эрхээ хамгаалахын тулд ҮЭ-д эвлэлдэн нэгдэж ҮЭ-ийн хороо байгуулах гэхээр дарга нар биднийг цугларч, хоорондоо уулзаж ярилцахыг зөвшөөрдөггүй ... гэж тэндхийн хэсэг ажилчид бүлгийн ярилцлагаар өгүүлэв /Төвийн багийн шалгалт судалгааны материалаас/.
- Нийслэлд үйл ажиллагаа явуулдаг “Магнай трейд”, “Өгөөж чихэр боов” зэрэг компаниудын удирдлагууд ажиллагсад ҮЭ-д эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэх бололцоо олгодоггүйн зэрэгцээ хяналт, шалгалтын байгууллагын болон МҮЭХ-ноос ажил танилцахаар ирсэн хүмүүсийг хүлээн авдаггүй байна /Төвийн бүсийн шалгалт судалгааны материалаас/
- Үйлдвэрийн ажилчид бидний эрх ашгийг хамгаалахад ҮЭ байгууллага үнэхээр хэрэгтэй байна. Хэрэв манай дарга нар ҮЭ-д эвлэлдэн нэгдэж ҮЭ-ийн хороо байгуулна гэвэл шууд ажлаас хөөнө. Өдөр бүр 12 цаг ажилладаг атлаа сард 30.000 төгрөгийн цалин авдаг /Налайх дүүрэг дэх Хятадын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Эрдэнийн хөгжил” ХХК-ийн ажиллагсадтай хийсэн бүлгийн ярилцлагаас/.
- МҮЭХ-ны Эрдэм шинжилгээ, сургалтын төвийн судалгаанд: “ҮЭ байгуулагдаагүй, зарим аж ахуйн нэгж, компанид ажиллагсдын дунд явуулсан судалгаанаас үзэхэд 58.0 хувь нь ҮЭ байгуулмаар байна гэж хариулсан нь ҮЭ хэрэгтэй гэдгийг ойлгосон нааштай үзүүлэлт юм” гэж тэмдэглэжээ /“Хөдөлмөрийн хүний эрхийг хүндэтгэе” номын 10 дугаар хуудас, 2003 он/.

2.7. Ажил олгогч нь ажиллагсдыг ҮЭ-д элссэн, ҮЭ-ийн байгууллага байгуулсан, түүний үйл ажиллагаанд оролцсон, захиргааны үйл ажиллагааг шүүмжилсэн гэдэг үндэслэлээр ажлаас халсан, сахилгын шийтгэл оногдуулах явдал байна.

- Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн удирдлага, ҮЭ-ийн хороо, зарим гишүүдээс гаргасан санал шаардлагад дургүйцэж ҮЭ-ийн

хорооны даргаа, зарим гишүүдийн хамт ажлаас хална гэж заналхийлж байсан бол Дорноговь аймгийн Ус цаг уурын орчны шинжилгээний төвийн удирдлага 2003 онд ҮЭ-ийн хорооны даргаа оролцуулан ҮЭ-ийн гишүүн 6 хүнийг эрхээ хамгаалахын төлөө тэмцсэн гэдэг шалтгаанаар ажлаас халж байжээ.

- Архангай аймгийн Хүнсний үйлдвэрийн захиргаа, 1 дүгээр 10 жилийн сургуулийн захиргаа, Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн захиргаа зэрэг байгууллагын албан тушаалтан ҮЭ-ийн хорооны дарга нараа ажлаас халсныг шүүхийн шийдвэрээр буцаан ажилд нь эргүүлэн тогтоосон байна.
- Говь-Алтай аймгийн “Тулга-Алтай” ХХК-ийн захиргаа ҮЭ-ийн хорооноос өгсөн шаардлагыг хүлээн авч биелүүлдэггүй атлаа ҮЭ-ийн хорооны сонгуультныг сонгосон хамт олных нь зөвшөөрөлгүй, үндэслэлгүйгээр ажлаас халсан байна.
- Нийслэлийн ХУД-ийн 63 дугаар сургуулийн захиргаа 2004 онд удирдлагын буруу үйл ажиллагааг шүүмжилж, шаардлага тавьж байсан багш, ҮЭ-ийн хорооныхоо даргыг халсныг шүүх ажилд нь эргүүлэн тогтоож байжээ.
- Нийслэлийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлдэг “Автобус-3” компанийг хувьчилж авсан эзэн нь 2004 онд 51 ажилтныг бөөнөөр үндэслэлгүй халсныг Монголын Тээвэр, Холбоо, Нефтийн ажилтны ҮЭ-ийн холбооноос шүүхэд нэхэмжлэл гарган уул 51 ажилтныг буцаан ажилд нь эргүүлэн тогтоолгосон байна /Төвийн багийн судлаачийн хийсэн судалгааны материалаас/.

2.8. ҮЭ-үүдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5-д: ... Үйлдвэрийн газар, байгууллагын захиргааны удирдах албан тушаалтан үйлдвэрчний сонгуульт ажлыг хавсран гүйцэтгэж болохгүй” гэж заасан байдаг. Зарим аж ахуйн нэгж, байгууллагад дэд захирал, менежер, боловсон хүчин зэрэг удирдах албан тушаалтан, ҮЭ-ийн хорооны дарга, сонгуультны ажлыг хавсран гүйцэтгэж байгаа нь ажиллагсдын эрх ашгийг хамгаалахаасаа илүү ажил олгогчийн эрх ашгийг илүүд үзэх хандлага давамгайлж байна. Судалгаанд хамрагдсан хот, хөдөөгийн 50 шахам газарт аж ахуйн нэгж, байгууллагын удирдах албан тушаалтан ҮЭ-ийн сонгуульт ажлыг хавсран гүйцэтгэж байв.

2.9. ҮЭ-үүдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4-т: “ҮЭ, түүний сонгуульт ажилтныг үйл ажиллагаагаа явуулах нөхцөл, бололцоогоор хангах асуудлыг хамтын гэрээнд тусгаж хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг.

Санал асуулгад хамрагдсан 1085 хүнээс ҮЭ болон түүний сонгуульт ажилтны ажиллах нөхцөлөөр хангасан гэж 593 хүн буюу 54.7 хувь нь үзсэн байхад 432 хүн буюу 39.8 хувь нь хангаагүй, 60 хүн буюу 5.5 хувь нь мэдэхгүй гэжээ.

2.10. ҮЭ-үүдийн эрхийн салшгүй нэг хэсэг бол ажиллагсдыг ажил хаяхад зохион байгуулах, хөдөлмөрлөх эрхээ хангуулахын төлөө жагсаал цуглаан хийх эрх юм. Энэ талаар Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дугаар зүйлд: Ажил хаях эрхийг хэрэгжүүлэх үндсийг зааж, мөн хуулийн 120 дугаар зүйлд: Ажил хаях тухай шийдвэрийг ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах байгууллагын гишүүдийн буюу нийт ажилтны хурлаас гаргана гэж заажээ.

Энэ эрхийг хэрэгжүүлэх асуудлыг МҮЭХ болон зарим мэргэжлийн болон нутаг дэвсгэрийн холбоодоос зохион байгуулж байна. Энэ оны эхээр гэхэд МҮЭХ-ноос улсын хэмжээнд хөдөлмөрлөх болон нийгэм, эдийн засгийн зарим эрхийг хангах асуудлаар тавьсан шаардлага, хамтын хэлэлцээрийг үр дүнд хүргэх зорилгоор ЗГ-т, аймаг, нийслэлийн ЗД нарт анхааруулж жагсаал цуглаан, ажил хаялт зохион байгуулахыг уриалсан алхмууд хийж байв.

Энэ судалгааны явцад ҮЭ-үүдээс жагсаал цуглаан, ажил хаялт зохион байгуулж байсан эсэхийг ҮЭ-ийн 170 байгууллагаас асуулга авахад 38 байгууллага дээр ажил хаялт, жагсаал цуглаан зохион байгуулж байжээ. Энэ нь судалгааны асуулгад хамрагдсан ҮЭ-ийн байгууллагуудын 22.4 хувийг эзэлж байна.

ГУРАВ. АЖИЛ ОЛГОГЧДЫН ЭВЛЭЛДЭН НЭГДЭЖ, БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛАХ ЭРХИЙН БАЙДАЛ

Ажил олгогч болох үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, захирал, эзэд эрх ашгаа хамгаалах, үйл ажиллагааныхаа зорилго, чиглэлийг хамтран тодорхойлж ажиллахын тулд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, байгууллага байгуулах эрхийг ОУХБ-ын 87, 98 дугаар конвенцууд болон Монгол улсын Үндсэн хууль, Төрийн бус байгууллагын тухай хуулиар баталгаажуулсан.

Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай ОУХБ-ын 87 дугаар конвенцийн 5 дугаар зүйлд: “Ажилчид ажил олгогчдын байгууллага нь эвсэл холбоо болон ийм төрлийн бусад байгууллага байгуулах, тэдгээрт нэгдэх эрхтэй” гэж заасан.

1990 оны 9 дүгээр сарын 29-нд эрх ашиг, сонирхлоо хангаж, хамгаалуулах гэсэн эрмэлзэлтэй хувийн үйлдвэрийн эзэд анх сайн дураараа эвлэлдэн нэгдэж өөрсдийн төлөөллийн байгууллага болох Монголын Хувийн Үйлдвэрийн Эздийн Холбоог байгуулан /1997 онд хуралдсан 3 дугаар Чуулганаараа МАОЭНХ гэж нэрээ өөрчилсөн/ ажилласан нь хөдөлмөрийн харилцааны нэг гол субъект болох Ажил олгогч эздийн эвлэлдэн нэгдэх эрхийн хэрэгжилтийн чухал асуудал байв.

МАОЭНХ хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн эзэд, захирлуудын санаачилгаар байгуулагдсан, гишүүнчлэл бүхий, ашгийн төлөө бус, төрийн

бус хувийн хэвшлийн ажил олгогчдыг төлөөлсөн үндэсний хэмжээний ажил олгогчдын байгууллага мөн гэж тодорхойлжээ.

МАОЭНХ-ны эрхэм зорилго нь бизнесийн тааламжтай орчин бий болгохын тулд төр, засгийн байгууллагуудын бодлого, үйл ажиллагаанд нөлөөлөх, ажил олгогч эзэд ба ажилтнуудын хоорондын харилцааны ойлголцолд түшиглэн хоёр ба гурван талт хамтын ажиллагааг дэмжих, гишүүдээ хөгжүүлэх, ялангуяа бизнесийн ур чадварыг дээшлүүлэхэд туслах замаар үндэсний эдийн засаг ба оюуны чадавхын өсөлт, нийгмийн /социал/ хөгжил, хөдөлмөрийн зохистой харилцааг хангахад хувийн хэвшлийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх явдал гэсэн нь ОУХБ-ын 87, 98-р конвенцийн агуулга, үзэл санааг бүрэн тусгасан байна.

МАОЭНХ нь нийслэл болон 21 аймагт бүгд 22 салбартай, нийтдээ 7900 гаруй гишүүн байгууллагатай, аймаг бүрт байгаа ажил олгогч эздийн холбоо нь мөн биеэ даан эвлэлдэн нэгдсэн гишүүнчлэлтэй байдаг. Аймгийн ажил олгогч эздийн холбоо нь МАОЭНХ-нд нэгдэн орсон гишүүн байгууллага юм.

Тус холбоо нь гишүүн байгууллагадаа үзүүлэх үйлчилгээний агуулга, чиглэлийг боловсронгуй болгож, сургалт сурталчилгаа, мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сүлжээнд холбох, гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах ажлыг эрчимжүүлсний дүнд 2000 онд 4900 байсан гишүүдийнхээ тоог 5 жилийн дараа 4000-аар нэмэгдүүлж 81.6 хувиар өсгөсөн байна.

ДӨРӨВ. АЛБАН БУС САЛБАРТ ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙН ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол улсад албан бус эдийн засгийн салбар бодитой оршин тогтнож байна. Албан бус эдийн засгийн салбарт ажиллагсдын талаарх тоо баримт урьд өмнө нь хийгдсэн нилээд олон төрлийн судалгаануудад авагдсан байна. Үндэсний статистикийн газраас 2002-2003 онд хийсэн “Ажиллах хүчний нэгдсэн судалгаа”-нд тусгагдсанаар Монгол улсад өнөөгийн байдлаар нийт 862500 хүн хөдөлмөр эрхэлж байгаагийн 126000 нь буюу нийт ажиллагсдын 14.6 хувь нь албан бус салбарт ажиллаж байна /Энд ХАА-н салбарын ажилчдыг албан бус салбарт хамруулдаггүй ОУХБ-ын жишгийн дагуу Монгол улсын ХАА-н салбарт ажиллаж байгаа 402200 хүнийг хамруулаагүй болно/. Эдгээрийн 89300 нь УБ хотод, 36700 нь хөдөө орон нутагт ажиллаж байгаа юм. Түүнчлэн эдгээр хүмүүсийн 11500 нь давхар ажил эрхэлж байна.

Албан бус салбарт ажиллагсдын эрх, ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах зорилготой ҮЭ байхгүй, харин сүүлийн үед зарим төрийн бус байгууллагууд үүсэж бий болж байна. Монголын хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн холбоо, Хувийн таксины үйлчилгээ эрхлэгчдийн холбоо, Ардын

аж ахуйтны холбоо, Жижиг бизнес эрхлэгчдэд зөвлөгөө өгөх төв, Түрээсийн байр эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах холбоо, гэрэл зурагчдын “Дурсамж” холбоо, хувиараа жонш олборлогчдын “Жаргалан” холбоо, Ганзагын наймаачдын эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид ажиллагсдын эрх ашгийг хамгаалах “Тэгш эрх” нийгэмлэг зэрэг ТББ байгуулагджээ. Эдгээр ТББ-ууд нь хэв шинжийн хувьд гишүүдээ үйлчилдэг ТББ-ын хэлбэртэй байна. Гэвч ихэнхийнх нь үйл ажиллагаа тогтвортой бус, үр дүн хязгаарлагдмал, санхүүгийн эх үүсвэргүйгээс олон улсын төсөл, хөтөлбөрөөс хараат байдалтай байна.

ХЭҮК-ын хийсэн судалгааны хүрээнд албан болон албан бус салбарын 1085 хүнээс авсан санал асуулгаар нийт хүмүүсийн 66.3 хувь нь эрх ашгаа хамгаалах зорилгоор эвлэлдэн нэгдэж, ҮЭ-ээс өөр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байгууллага байгуулах нь зүйтэй гэж үзсэн байна. Түүнчлэн хувиараа хөдөлмөр эрхлэгчидтэй хийсэн ярилцлагын үеэр УБ хотын дүүргүүд дэх томоохон захад лангуу түрээслэн ажиллуулдаг хүмүүсийн ихэнх нь эрх ашгаа хамгаалуулах байгууллага байгуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Албан бус салбарын ажиллагсдыг төлөөлсөн байгууллага төлөвшиж, үйл ажиллагаа нь тогтворжиж чадаагүйгээс засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулагддаг хамтын хэлэлцээрт тэдгээр хүмүүсийн эрх, нийтлэг ашиг сонирхлыг хөндсөн асуудлууд төдийлөн тусгагддаггүй байна. Гэхдээ ҮЭ-ийн холбоод энэ ажлыг албан бус салбарынхныг төлөөлөн гүйцэтгэж, тодорхой хүчин чармайлт гаргаж ирсэн нь сайшаалтай юм. Тухайлбал, Нийгмийн зөвшлийг хангах 2002-2003 оны улсын хэлэлцээрийн 16 дугаар зүйл: “МУ-ын Засгийн газар, эзэд, хоршоологчдын болон ҮЭ-үүдийн улсын хэмжээний байгууллагууд албан бус хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сүлжээг 2003 онд бий болгоно” гэсэн заалт оруулсан. Цаашид албан бус эдийн засгийн салбарт ажиллагсад өөрсдийн бие даасан ҮЭ-ийг байгуулж, одоо үйл ажиллагаа явуулж буй ҮЭ-үүдтэй хамтарсан төлөөлөгч томилох замаар эсхүл ҮЭ-ийн холбоодод гишүүн байгууллагаар элсэж, улмаар тэдгээр холбоодын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд багтах үндсэн дээр зохих түвшний хамтын хэлэлцээрт оролцох боломжтой байна.

ТАВ. ХАМТЫН ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭР БАЙГУУЛАХ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль: “Хамтын гэрээ гэж тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажилтны хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хуулиар тогтоосон баталгаанаас илүү нөхцөлөөр хангах болон энэ хуулиар шууд зохицуулаагүй асуудлаар ажил олгогч, ажилтны төлөөлөгчдийн хооронд байгуулсан тохиролцоог хэлнэ” /Хуулийн 3 дугаар зүйл/ гэж заасны дагуу аж ахуйн нэгж,

байгууллагын түвшинд хамтын гэрээг байгуулан хэрэгжүүлж байна.

Харин хамтын хэлэлцээр нь байгуулж буй түвшин, хугацаа, хэлбэр, оролцогч талууд, зохицуулж буй асуудал зэргээрээ хамтын гэрээнээс ялгаатай бөгөөд “Хөдөлмөрийн тухай хууль”-д хамтын хэлэлцээр гэж “Иргэний хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлын хамтран хамгаалах зорилгоор улсын хэмжээнд болон тодорхой бүс нутаг, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, салбар, мэргэжлийн хүрээнд ажил олгогч, ажилтны төлөөлөгчид, төрийн захиргааны байгууллагын хооронд байгуулсан тохиролцоог хэлнэ” гэж тодорхойлсон.

5.1. ОУХБ-ын 98 дугаар конвенци болон Хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжуудын заалтыг үндэслэн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагууд ҮЭ-ийн хороод хамтын гэрээ, хэлэлцээр байгуулж, биелэлтийн явцыг хянаж, дүгнэж байгаа болно.

2004 оны 12 дугаар сарын байдлаар улсын бүртгэлд 34218 хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллага бүртгэгдсэнээс 25356 хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагаагаа явуулж байгаагийн 1978 дээр нь ҮЭ-ийн хороо байгуулагдан ажиллаж байна /МҮЭХ-ны Нийгэм, эдийн засгийн хэлтсийн судалгааны материал/.

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгж, байгууллагуудын 7.3 хувь нь, ҮЭ-ийн хороотой нийт аж ахуйн нэгж, байгууллагуудын 93.4 хувь нь буюу 1847 хороо нь аж ахуйн нэгж, байгууллагын захиргаатай хамтын гэрээ байгуулсан байна /МҮЭХ-ны Нийгэм, эдийн засгийн хэлтсийн судалгааны материал/.

Энэ удаагийн шалгалт судалгаанд хамрагдсан 315 аж ахуйн нэгж, байгууллагаас 202 нь ҮЭ-ийн хороотойгоос 157 аж ахуйн нэгж, байгууллага ажил олгогчид нь ҮЭ-ийн хороотой хамтын гэрээ байгуулан ажиллаж байгаагийн гадна ОХУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Алтан Дорнод Монгол” ХХК болон “Монгол газар” ХХК гэх мэт 5 газар, байгууллагад ҮЭ-ийн хороогүй атлаа ажиллагсдын төлөөлөгчидтэй хамтын гэрээ байгуулан ажиллаж байна.

Хамтын гэрээ байгуулж ажиллах явдал бол хөдөлмөрийн харилцаанд оролцогч аж ахуйн нэгж, байгууллагын нэн чухал үүрэг юм. Энэ талаар Хөдөлмөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд: “Хамтын гэрээг аж ахуйн нэгж, байгууллагын бизнес төлөвлөгөө байгуулахаас өмнө байгуулна” гэж заасан.

Зарим ажил олгогч, захиргаа нь хамтын гэрээ байгуулах талаар ажилтны төлөөлөгч болон ҮЭ-ийн хорооноос тавьсан санал, мэдэгдлээс татгалзах, санаатай зайлсхийх, байгуулсан хамтын гэрээг хэрэгжүүлэхгүй байх зэрэг зөрчил, дутагдал байсаар байна. Жишээ нь: Шалгалт судалгаанд хамрагдсан ҮЭ-ийн хороотой 202 аж ахуйн нэгж,

байгууллагаас 45 нь буюу 22.3 хувь нь хамтын гэрээ байгуулаагүй байна. Тэдгээрээс хамтын гэрээ байгуулаагүй шалтгааныг 190 аж ахуйн нэгж, байгууллагаас тодруулахад 33 байгууллагын захиргаа, ажил олгогчид хамтын гэрээ байгуулахаас татгалзсан, санаатай зайлсхийсэн гэжээ /ХЭҮК, МҮЭХ-ны хамтарсан судалгааны материал, 2005 он/.

- Хамтын гэрээгээр ажиллагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тодорхой хэмжээний хөрөнгө шаардагддаг учир ажил олгогч хамтын гэрээ байгуулах сонирхолгүй буюу татгалздаг байна. Судалгаанд хамрагдсан 5 байгууллагаас 4 нь хамтын гэрээгүй байсан (Дундговь аймгийн шалгалт-судалгааны материалаас).
- Аймгийн эрүүл мэндийн газрын удирдлага хамтын гэрээгээр цалин, хөлс, урамшуулал олгоход төсөв хүрэлцэхгүй гэдэг шалтгаанаар хамтын гэрээ байгуулахаас татгалзсан байна /Баянхонгор аймгийн шалгалт-судалгааны материалаас/.

Дээр дурдсан баримтаас үзэхэд манай улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй зарим аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсад нь эвлэлдэн нэгдэж, хамтын зарчмаар эрх ашгаа хамгаалах, ажил олгогч, байгууллагын захиргаагаар хамтын гэрээ байгуулж, хөдөлмөр, нийгмийн асуудлуудаа шийдвэрлүүлэх зэрэг эрхийн хэрэгжилтийн байдал хангалтгүй байгаа нь харагдаж байна.

Хамтын гэрээ байгуулж ажиллахын ач холбогдол, мөн чанар нь Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар нийт ажилтны хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хуулиар тогтоосон баталгаанаас илүү нөхцөлөөр хангах болон энэ хуулиар шууд зохицуулаагүй асуудлыг хоёр тал гэрээгээр тохиролцдог явдал юм. Хэрэв үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага буюу ҮЭ-ийн хороо, тийм байгууллага байхгүй бол ажилтны төлөөлөгчийн аль нэг нь дангаараа хамтын гэрээ байгуулах эрхгүй бөгөөд ямар ч боломжгүй юм.

Хамтын гэрээгээр ямар харилцааг зохицуулж болохыг Хөдөлмөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлд тодорхой заасан. Зарим аж ахуйн нэгжүүд Хөдөлмөрийн тухай хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэхэд сайн анхаарч байна. Архангай аймгийн төвийн зарим нэг аж ахуйн нэгж, байгууллагын хамтын гэрээнд тухайлбал, “Илч” ХХК-ийн хамтын гэрээнд орон сууцанд амьдардаг ажиллагсдын халаалтын хөлсийг амьжиргааны чадавхаас нь хамааран 50-100 хувь хөнгөлөх, нийгмийн даатгалын хэлтэс ажилтныг эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх, эмчилгээ хийлгэхэд байгууллагын захиргаанаас 70-100 мянган төгрөгийн тусламж үзүүлэх, өндөр насны тэтгэвэрт гарахад нь ажилласан жилээс нь хамаарч 3-6 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгох, “Авто зам-Архангай” ХХК, “АЗЗА-Архангай” ХХК, Холбооны газар зэрэг байгууллагууд өндөр насны тэтгэвэртээ гарсан болон өрх толгойлсон эх /эцэг/ олон хүүхэдтэй, тахир

дутуугийн группт байгаа хүмүүст мөнгөн тэтгэмж, үнэгүй түлш олгох, хямдралтай үнээр малжуулах, Цахилгаан шугам сүлжээний газар, Нефть зэрэг газрууд нийгмийн даатгалын сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж авч буй эхэд цалингийн зөрүү 30 хувийг байгууллагаас нь олгох, Стандарт хэмжил зүйн төв, “Цагаан сүмбэр” ХХК зэрэг газрууд хүүхдээ асрах чөлөөтэй байгаа эхэд байгууллагаас 10-15 мянган төгрөгийн нэмэгдэл тэтгэмж олгох, ажилтны өдрийн хоолны үнийг тодорхой хувиар хөнгөлөх зэрэг асуудлыг хамтын гэрээгээр зохицуулсан байна.

Гэтэл хамтын гэрээнд тусгавал зохих асуудлыг бүрэн тусгахгүй байх буюу гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, эсхүл хагас дутуу биелүүлдэг үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагууд ч олон байна.

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2001 оны 3 дугаар 20-ний өдрийн 108 тоот тушаалд: “Хамтын гэрээ, хэлэлцээрийг төрийн захиргааны байгууллагаас бүртгэх, биелэлтэд нь хяналт тавих журам”-д заасны дагуу ажил олгогч нь өөрийн оршин байгаа сум, дүүргийн ЗДТГ-т хамтын гэрээг түүнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 10 хоногийн дотор хүргүүлэн бүртгүүлэх үүрэгтэй байдаг.

Гэтэл хамтын гэрээг дээр дурдсан журмын дагуу эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, түүнд хяналт тавих асуудал хангалтгүй байна. Өөрөөр хэлбэл, эрх бүхий байгууллагад бүртгүүлэн хуулийн хүчин төгөлдөр болоогүй хамтын гэрээтэй аж ахуйн нэгж, байгууллагууд цөөнгүй байна.

5.2. Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу Улсын хэлэлцээр, Бүсийн хэлэлцээр, Салбарын хэлэлцээр, Аймаг, нийслэлийн хэлэлцээр, Сум, дүүргийн хэлэлцээр, Мэргэжлийн тарифын хэлэлцээр гэсэн 6 төрлийн хамтын хэлэлцээр байгуулж байна.

1990 оноос хойш Монгол улсын ЗГ болон МҮЭ-үүдийн холбоо, МАОЭНХ нь 1992-1999 оны хооронд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт улсын хэлэлцээр /ХНЗГТУХ/-ийг жил бүр /“Монгол дахь нийгмийн түншлэл” судалгааны тайлан /2003/, Хөдөлмөрийн тухай хууль /1999 он/-д заасны дагуу 2000 оноос дээр дурьдсан байгууллагуудын хооронд ХНЗГТУХ-ийг (2000-2001, 2002-2003, 2005-2006) жилийн хугацаатайгаар байгуулж байна.

ХНЗГТУХ нь улс орны нийгэм, эдийн засаг, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн зах зээлийн төлөвшил, хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж иржээ.

ХНЗГТУХ-т улс орны нийгэм, эдийн засгийн тухайн үеийн төлөв байдал, цаашдын хөгжлийн чиг хандлага, иргэд, хөдөлмөрчдийн амьжиргаанд тулгамдаж буй асуудлууд тусгагдан, түүнийг хэрэгжүүлэхийн төлөө нийгмийн түншлэгч байгууллагууд болох Монгол улсын ЗГ, МҮЭХ, МАОЭНХ идэвхтэй хамтран ажилласан байна.

1992-2003 оны хооронд байгуулж хэрэгжүүлсэн ХНЗГТҮХ-ийн биелэлтийн байдлыг үзүүлбэл:

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт улсын хэлэлцээрүүдийн биелэлт /1992 - 2003/

		Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт улсын хэлэлцээрүүд (ХНЗГТҮХ-үүд)										
		1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000 - 2001	Нэмэлт	2002 - 2003
Нийт асуудал		27	29	34	18	34	47	31	27	46	38	53
Үүнээс:	Биелсэн	21	25	19	17	27	36	20	20	36	32	37
	Хагас биелсэн	1	1	17	1	3	11	4	-	4	4	15
	Тасарсан	5	3	3	-	4	-	7	7	6	2	1
Биелэлтийн хувь		77.7	86.2	86.2	94.4	88.0	76.5	64.5	74.0	78.2	84.2	93.5

Бүх аймаг, нийслэлийн хэмжээнд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн хоёр ба гурван талт аймаг, нийслэлийн хэлэлцээрүүд байгуулагдан, хэрэгжиж байна.

Дараах мэргэжил, үйлдвэрлэлийн 10 салбарт салбарын хэлэлцээр байгуулагдсан байна. Үүнд:

- 1) Боловсрол, соёл, шинжлэх ухаан
- 2) Барилга
- 3) Хүнс, хөдөө аж ахуй
- 4) Эрчим хүч, геологи, уул уурхай
- 5) Тээвэр холбоо, газрын тос
- 6) Төмөр зам
- 7) Авто зам
- 8) Эрүүл мэнд
- 9) Нэхмэл болон оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- 10) Төрийн болон төсөвт байгууллага

Дээр дурдсан салбарын хэлэлцээрүүд нь тухайн салбарт ажиллагсдын хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон нийгэм, эдийн засгийн эрх, ашиг сонирхлыг нь ханган хамгаалахад тодорхой хэмжээнд хувь нэмэр оруулж байна.

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуульд бүсийн хэлэлцээр байгуулж болохоор хуульчилсан боловч өнөөдрийн байдлаар манай улсын хэмжээнд нэг ч бүсийн хэлэлцээр байгуулагдаж байгаагүй байна.

Харин оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн болон түлш эрчим хүчний салбарт мэргэжлийн тарифын хэлэлцээр байгуулагдсан байна.

ЗУРГАА. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

6.1. ҮЭ-үүдийн эрхийн тухай хуульд: ҮЭ-үүдийн сонгуульд ажилтны нийгмийн хамгааллын асуудал болон эрх зүйн баталгааг хангах, энэхүү хуулийн зүйл, заалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тухайн хуульд тусгаж өгөх, ҮЭ-үүдийн хуулийн этгээдийн эрх зүйн статусыг тодорхойлж, эрх, үүргийг Хөдөлмөрийн тухай хуультай нийцүүлэн нарийвчлан тогтоох, энэ хуулийн биелэлтэд тавих хяналтын механизмыг бий болгох.

6.2. ҮЭ-ийн идэвхтэн, сонгуультныг мэдлэг, туршлагатай, чадварлаг ажилтнаар сэлбэх, тэдний бүтээлч идэвхийг өрнүүлэх замаар ҮЭ-ийн байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлж, н өлөө, нэр хүндийг нь дээшлүүлэхэд чиглүүлсэн үзүүлэлтээр тодорхой урамшуулал олгох журам тогтоон ажиллах.

6.3. Хүний эрхийн үндэсний хөтөлбөрийн 2.2.4.2-т: “Ажиллагсад ҮЭ-д нэгдэн ажил олгогч аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны дур зоргын үйл ажиллагааг илчлэх, няцаах зэргээр эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамтран хамгаалах механизмыг сайжруулна” гэсэн заалтын дагуу холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон аж ахуйн нэгж, байгууллагын ажлыг дүгнэхэд ҮЭ-д эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон ҮЭ-ийн байгууллага байгуулах эрхийг хэрэгжүүлэхэд ямар боломж, нөхцөлөөр хангасан, ҮЭ-ийн байгуулагатайгаа хамтын гэрээгээ хэрхэн байгуулж, дүгнэж байгааг нэг гол үзүүлэлт болгодог журам тогтоох.

6.4. Ажил олгогч, эздийн байгууллагад гурван талт хэлэлцээрийн нэг гол субъектийнх нь хувьд энэ байгууллагын эрх хэмжээ, статусыг тодорхойлсон тусдаа хуультай байх шаардлагыг үндэслэн хуулийн төсөл боловсруулах асуудлыг судлан үзэх.

6.5. Албан бус салбарт ажиллагсдад эрх ашгаа хамгаалах зорилгоор эвлэлдэн нэгдэх талаар сурталчилгаа хийж, байгууллага байгуулах эрхээ эдэлж, хэрэгжүүлэхэд нь эрх зүйн зохицуулалттай болгох замаар холбогдох байгууллагуудаас зохих дэмжлэг үзүүлэх, улмаар албан бус салбарт ажиллагсдын байгууллагаас нийгмийн хэлэлцээрт оролцох боломж, нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

6.6. Ажил олгогчид, ажиллагсад болон ҮЭ-ийн гишүүд сонгуульд ажилтнуудын дунд ОУХБ-ын 87, 98 дугаар конвенци болон ОУ-ын бусад холбогдох гэрээний заалт, ҮЭ-үүдийн эрхийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжийн талаар сургалт, сурталчилгааны ажлыг тусгай хөтөлбөрөөр зохион байгуулах.

ТАКТИКИЙН ЗУРАГЛАЛ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛЫН ТАЛААР

М.Бат-Очир

Эв Аран ТББ-ын Гүйцэтгэх Захирал

Эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бусаар харьцах асуудал нь хүний эрхийн хамгийн хөндүүр, эмзэг сэдэв бөгөөд одоог хүртэл хуулийн байгууллагуудын үйл ажиллагаанд эрүү шүүлт хэрэглэн гэмт хэрэгтэй тэмцэх, хэрэг шийдвэрлэх явдал амь бөхтэйгээр оршоор байгаа билээ. Энэхүү хууль бус ажиллагаа нь манай нийгэмд хүний эрхийн түгээмэл зөрчил болон хувирч, өөрөөр хэлбэл эрүү шүүлт нь хуулийн байгууллагуудын үйл ажиллагаанд тохиолдлын чанартай гарч буй гаж үзэгдэл бус харин хэрэг илрүүлэх, мөрдөн байцаах ажиллагааны түгээмэл арга хэлбэр болж тогтсоныг Хүний эрхийн үндэсний комиссын 2006 оны илтгэлд тодорхой тусгажээ.

Хэдийгээр төрийн болон төрийн бус байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааны хүрээнд эрүү шүүлтийг хориглох, таслан зогсоох чиглэлээр тодорхой ажил, санаачлагуудыг хэрэгжүүлж байгаа боловч энэхүү хууль бус ажиллагааг нөхцөлдүүлж байдаг учир шалтгаан нь өргөн хүрээний асуудлыг хамарч байдгийн хувьд түүний эсрэг нэг удаагийн ажиллагаа хэрэгжүүлэх бус харин тогтолцоогоор нь хамарсан өөрчлөлт хийх шаардлага нэн тэргүүнд тавигдаж байгаа билээ.

Хүний эрхийн зөрчлийг нөхцөлдүүлж байдаг нэг эх үүсвэр нь түүнийг тойрсон харилцан шүтэлцээтэй, ээдрээтэй тогтолцоо байдаг бөгөөд энэ нь зөрчил гаргагчийн оролцоог улам лавшруулж, нөхөн тэжээж, тогтворжуулдаг онцлогтой юм. Энэхүү ээдрээтэй тогтолцоонд зохион байгуулалтын, бүтцийн болон албан бус харилцаа, хамаарал багтдаг байна. Зарим хамаарлыг зөвхөн хөндлөнгийн нөлөөллөөр тэдгээрт тохирсон арга хэрэгслэлийг хэрэглэн өөрчлөх шаардлагатай байдаг байна.

Хүний эрхийг хамгаалдаг, хөхиүлэн дэмждэг дийлэнх байгууллагууд өөрийн суралцах муруйн онцлог, хүний нөөцийн боломж, ажлын үр дүнгийн үнэлгээний байдал, санхүүжилтын гачигдлаас хамааран бүтцийнхээ хүрээнд зөвхөн цөөн тооны гол арга хэрэгслэлийг хэрэглэдэг байна. Энэ нь хувь хүнээр жишээлж үзвэл хүн бүр зөвхөн өөрийн чаддаг юмаа эрхэлдэгтэй адил юм.

Иймд хүний эрхийн түгээмэл тодорхой зөрчлийг нөхцөлдүүлж буй харилцан шүтэлцээтэй, ээдрээтэй тогтолцоог эвдэх, өөрчлөн

сайжруулахын тулд хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих чиглэлийн хамтын ажиллагаагаа бэхжүүлж, нэгдсэн стратеги боловсруулах үндсэн дээр тууштай ажиллах нь чухал юм.

Тактикийн зураглал боловсруулах ажиллагаа нь хүний эрхийн түгээмэл зөрчлийг таслан зогсоох стратегийн зорилгод хүргэхэд дорвитой хувь нэмрээ оруулах чухал аргачлал юм. Энэхүү аргачлал нь тухайн зөрчилтэй холбоотой нөхцөл байдлыг сайтар тодруулах, зөрчлийг нөхцөлдүүлж буй харилцан шүтэлцээг задлан шинжлэх, цаашид анхаарал шаардсан ажлыг тодорхойлох, зөрчилтэй тэмцэх арга хэрэгслэлүүдийн уялдаа холбоог сайжруулах, түүнчлэн хүний эрхийг хамгаалах ажлын үнэлгээ, дүгнэлтэнд хэрэглэж болох хэрэгслэл юм.

Тактикийн зураглал боловсруулах аргачлал нь АНУ-ын Эрүү шүүлтэд өртөгчдийг дэмжих төв (ЭШӨДТ)-өөс санаачлан хэрэгжүүлж буй Хүний эрхийн шинэ тактик хөтөлбөрийн нэг бүрэлдэхүүн хэсэг юм. ЭШӨДТ нь 1985 оноос эхлэн дэлхийн 60 гаруй орны улс төрийн нөхцөл шалтгаанаар эрүү шүүлтэд өртөгчдөд халамж, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлж ирсэн байгууллага юм. Үйлчлүүлэгч, харьцах байгууллага, нөлөө бүхий шийдвэр гаргагчийн хүрээ тэлсээр уг байгууллага нь эрүү шүүлттэй тэмцэх хүний эрхийн хамтын нийгэмлэгэд өөрийн хувь нэмрээ оруулахуйц амжилтад хүрчээ. Түүний Хүний эрхийн шинэ тактик хөтөлбөр (ХЭШТХ) нь ЭШӨДТ-өөс санаачлан боловсруулсан эрүү шүүлттэй тэмцэх шинэлэг арга барил, түүнчлэн тус байгууллагаас үүсгэн манлайлж буй хүний эрхийн байгууллагуудын эвслийн ажиллагааны түршлагаас үүдэлтэй ажээ.

ХЭШТХ нь хүний эрхийн аливаа зөрчлийг нөхцөлдүүлж буй харилцан шүтэлцээтэй, ээдрээтэй тогтолцоог дагнасан нэг арга барилаар таслан зогсоох боломжгүй гэсэн ерөнхий санаанд тулгуурлан үүсгэн байгуулагдажээ. Энэхүү хөтөлбөрийн уриалж буйгаар хүний эрхийн зөрчлийг урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг ахиулахын тулд хүний эрхийн хамгаалагчид тэмцлийн бүхий л арга хэрэгслэлийг бүтээлчээр хэрэглэж, тэдгээрийг хослуулан чадварлаг стратеги боловсруулах хэрэгтэйг онцлон заажээ.

Тактикийн зураглал боловсруулах гэдэг нь хүний эрхийн аливаа зөрчлийг нөхцөлдүүлж буй байгууллага, харилцааг дүрслэн шинжлэх аргачлал бөгөөд ингэснээр тэрхүү дүрслэн гаргаж ирсэн тогтолцоонд нөлөөлөхүйц арга хэрэгслэлийн агууллага, боломжийг нягтлах, цаашлаад хамтаар тодорхойлсон стратегийн хэрэгжилтэд мониторинг хийх хэрэгслэл болох учиртай.

Тактикийн зураглал боловсруулах ажиллагааг эхлэхдээ өөрчлөлт бий болгохыг эрмэлзэж буй зөрчилтэй харилцааг, жишээлбэл эрүүдэн шүүгч, хохирогч хоорондын харилцааг ойлгож, аливаа байгууллагын бүтцийг бүдүүвчээр тодорхойлоход хэрэглэдгийн адил түгээмэл тэмдэг,

тэмдэглэлийг ашиглан тэрхүү зөрчилтэй харилцааг диаграмчлан дүрсэлдэг байна.

Диаграм бэлэн болмогц түүн дээр тухайн зөрчилтэй харилцааг арилгахад чиглэгдсэн бүхий л “арга хэрэгслэлийг буулгаж”, тэдгээр арга хэрэгслэл нь чухам ямар харилцан шүтэлцээ, уялдаа холбоонд хэрхэн нөлөөлж буйд дүн шинжилгээ хийнэ. Дээрхи хоёр ажилбар нь хүний эрхийн түгээмэл зөрчлийн нөхцөл байдалд асар богино хугацаанд үнэлгээ өгөх, түгээмэл зөрчилтэй тэмцэхэд хэрэглэж ирсэн арга хэрэгслэлүүдийг нэгтгэн дүгнэх, түүнчлэн хүний эрхийг хамгаалах ажилд орхигдсон талбарыг илрүүлэн тодорхойлох ач холбогдолтой юм.

Тухайлбал, эрүүдэн шүүгч нь байгууллага, мэргэжил, нийгмийн хамаарал эсхүл ар гэрийн байдлаас үүдэлтэй үй олон хувь хүн, байгууллагатай байнга харьцдаг гэж үзэхэд тактикийн зураглал боловсруулах арга хэрэгслэл нь эдгээрээс хүний эрхийн зөрчлийг нөхцөлдүүлж буй харилцааг таслан зогсоох буюу өөрчлөхөд чиглэгдэх юм. Өөрчлөлт бий болгохын тулд эхлээд аль байгууллага, хувь хүн эерэг нөлөө үзүүлж байгаа, эсхүл нөлөөлж болохыг ойлгох нь чухал юм. Жишээ нь, ХЭШТХ-ийн хүрээнд нийгэм, ар гэрийн байдалд нь тулгуурлаж хэрэглэсэн нэгэн арга хэрэгслэл бол эрүүдэн шүүгчийн гэрийн гадаа эсэргүйшлийн цуглаан зохион байгуулсан явдал юм. Өөр нэгэн жишээг авч үзвэл эрүүдэн шүүгчийг түүний гишүүн мэргэжлийн холбоогоор дамжуулан цээрлүүлэх арга хэрэгслэлийг үүнд дурьдаж болох юм.

Манай нийгэмд хувь хүний халдашгүй дархан байх эрхийг баталгаажуулах, эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах ажлын хүрээнд Хүний эрхийн үндэсний комисс, Эмнэсти Интернэшнл, Эв Аран ТББ хамтран эрүү шүүлтийн тактикийн зураглал боловсруулах ажлыг ХЭШТХ-ийн дэмжлэгтэйгээр хуулийн байгууллага, иргэний нийгэм, эрүү шүүлтэд өртөгчид, тэдгээрийн ар гэрийн төлөөллийг оролцуулан зохион байгуулсан билээ. Энэхүү тактикийн зураглал боловсруулах ажлын ач холбогдол нь эрүү шүүлттэй холбоотой хууль бус ажиллагаанд нөлөөлж буй хүчин зүйлсийг тогтоох, түүнийг бүрдүүлж буй нөхцөл байдал, байгууллага болон албан бус хамаарлуудын өөр хоорондын харилцааг зураглан гаргах аргаар эрүү шүүлтийг нөхцөлдүүлж буй ээдрээтэй тогтолцоог задлан шинжлэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд цаашид хэрхэх талаар санал бодлоо солилцох, шинэлэг арга хэрэгслэл боловсруулахад чиглэгдсэн болно.



Тэмдэглэл



НҮБХХ нь мэдлэг, туршлага, нөөцийг холбож, улс орнуудын өөрчлөлтийг олон нийтэд хүргэх замаар илүү сайн сайхан амьдралыг цогцлон байгуулахад хүмүүст туслах зорилго бүхий НҮБ-ын дэлхий нийтийн хөгжлийн сүлжээ юм.

Эрхэм Уншигчид аа!

Та бүхэн манай сэтгүүлийн талаарх санал, үзэл бодлоо доор хаягаар ирүүлнэ үү.

Хүний Эрхийн Үндэсний Комисс

Хаяг: Улаанбаатар хот, Эрх чөлөөний талбай, Засгийн газрын XI байр, 5 дугаар давхар

Утас: 318082, 262971

Факс: 262971, 320284

Цахим шуудан: contact@nhrc-mn.org

Цахим хуудас: <http://www.mn-nhrc.org>